# Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө

**Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар** **2022 оны жилийн эцэс**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО. | | | | | | | | |
| 1 | 1. АЗДҮАХ-ийн 1.1.1 | 1. Ариутгал, халдваргүйжилт, ариун цэврийн горимыг хангахад шаардлагатай эм хэрэгсэл, ариутгалын бодис, хөрөнгө санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ. | 12 | - | Эм хэрэгсэл, ариутгалын бодис, хөрөнгө санхүүгийн нөөц 30 хувь | 33.7 сая | 2022 онд ковидын болон бусад халдварын ариутгал, халдваргүйжилт, ариун цэврийн горимыг хангахад шаардлагатай эм хэрэгсэл, ариутгалын бодис, хөрөнгө санхүүгийн нөөцийг бүрдүүлэхэд 300.0 сая төгрөгийг төсөвлөсөн бөгөөд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эрсдэлийн үнэлгээгээр бага эрсдэлтэй байгаа тул нөөцөөс зөвхөн ариутгал, халдваргүйтгэлийн бодис хуваарилах зардалд 33.7 сая төгрөгийг зарцуулаад байна. | 100% |
| 2 | | 2. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна. | 12 | - | 93,0 | - | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтад БНСАУ-ын Green gross үйлдвэрийн 13270 хүн тун вакцин татан авснаас 1-12 насны 8438 хүүхэд, 16-64 насны архаг хууч өвчтэй 2692 хүн, 65-аас дээш насны 1110 хүн, жирэмсэн 141, эрүүл мэндийн байгууллагын 685 ажилтан, нийт 13066 хүн хамрагдаж, 98.5%-ийн хамрагдалттай байна. | 100% |
| 3 | | 3. Онцгой байдал, гамшгийн үеийн | 12 | - | 100 | 300 сая | Ковидын болон гамшгийн үеийн халдварын ариутгал, халдваргүйжилт, ариун цэврийн горимыг хангахад шаардлагатай эм хэрэгсэл, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | | | | | ариутгалын бодисын хөрөнгө санхүүгийн нөөцийг бүрдүүлэхэд орон нутгийн төсөвт 300.0 сая төгрөгийг төсөвлөж, аймгийн онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор нэг удаагийн халат 1000 ширхэг, бээлий 50 хайрцаг, дархлааны багц 50 ком, уян бамбар 4000 ширхэг, ариун бамбар 1000 ширхэг, вакумтейнер 5000 ширхэг, түргэвчилсэн тест 9600 ширхэг, ариутгал халдваргүйтгэлийн жавелин 10 флакон, бензин шатахуунд 771.0 мянган төгрөгийн нөөцийг төвлөрүүлээд байна. | |
| 4 | | 4. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд лабораторийн RT-PCR тоног төхөөрөмжийг нийлүүлж, бүх төрлийн халдварын үүсгэгчийг орон нутагтаа оношилдог болно. | 12 | - | БОЭТ-д БХ-ПГУ-ын шинжилгээ хийх төхөөрөмжтэй болж, лабораторийн чадавх нэмэгдсэн байна. | 89 сая төгрөг | Бүсийн Оношилгоо, эмчилгээний төвийн Вирусологийн лабораторид ДЭМБ-ын 60 гаруй сая төгрөгийн дэмжлэгээр БНХАУ-д үйлдвэрлэсэн "HEALGEN" брэндийн 32 сорьцыг 25-28 минутад ялгах хүчин чадал бүхий сорьц ялгах автомат төхөөрөмж, “Био аюулгүй ажиллагааны P-53” төслөөр 89.0 сая төгрөгөөр “Rotogene Q-Splex” маркийн “Полимеразын гинжин урвал-ПГУ”-ын шинжилгээний аппаратыг Зоонозын өвчин судлалын төвд олгосон. | 100% |
| 5 | | 5. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг | 12 | - | Халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны хамруулалт 40.0 хувь | | 2022 он 7 дугаар сард Коронавируст халдвараас сэргийлэх цуврал нэвтрүүлэг 2 удаа, 8 дугаар сард орон нутгийн Ховд телевизэд Коронавируст халдварын эсрэг вакцинаар 5-11 насны хүүхдийг дархлаажуулах, 12-17 насны хүүхдийг нэмэлт тунд хамруулах, вакцинжуулалтын ач холбогдлын талаар, 9 дүгээр сард хичээл сургууль эхлэхтэй холбогдуулан Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтмол зохион байгуулна. | | | | | Khovdnews.mn сайтад мэдээлэл, сурталчилгааг цахимаар хийж нийт 24290 иргэн хандалт авсан байна. Мөн Эрүүл мэндийн газрын фэйсбүүк группт тасралтгүй зөвлөмж, зөвлөгөө байршуулан ажиллаж байна | |
| 6 | | 6. Халдварын голомтыг цомхотгох, хөл хорио тогтооход ажилласан мэргэжлийн байгууллагуудын эмч, албан хаагч, ажилчдад олгох зардлыг шийдвэрлэж ажиллана. | 12 | - | Зардлыг бүрэн шийдвэрлэнэ. | 125.5 сая төгрөг | Аймгийн Онцгой комиссын 2-р сарын 09-ний өдрийн 12 дугаар тогтоол, Монгол Улсын шадар сайд, Эрүүл Мэндийн сайдын хамтарсан 05/А/12 дугаар тушаалын дагуу Короновируст халдвар ковид-19 цар тахлын үеийн хариу арга хэмжээнд 1-10 сар хүртэлх хугацааны илүү цагийн хөлсийг тооцож 148 хүнд 125.6 сая төгрөгийг олгоод байна. | 100% |
| 7 | | 7. Булган боомтод тандалтын нэгж байгуулна. | 12 | - | Булган боомтод тандалтын нэгж байгуулагдсан байна. | | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн А/373 дугаар тушаалаар баталсан "Томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд суурилан короновируст халдвар (ковид 19) тандалтыг өргөжүүлэх журам"-ыг хэрэгжүүлж, хилийн нэвтрэх цэгт томуу, томуу төст өвчин, коронавируст халдварын үүсгэгчийг илрүүлэх сорьц цуглуулах, тээвэрлэх тандалтыг эрчимжүүлэх зорилгоор Булган хилийн боомтын ажилчид, оршин суугчдаас сорьц цуглуулан халдварт өвчин судлалын үндэсний төвийн вирус судлалын лавлагаа лабораторид 2022 оны 11 дүгээр сарын 10-ний байдлаар нийт 100 сорьц цуглуулан тээвэрлэж, хүргүүлэхэд 7 сорьцонд Omicron BA.5 хувилбар илэрсэн бөгөөд тандалтыг журмын дагуу тасралтгүй гүйцэтгэж байна. | 100% |

| 2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 1. АХ-2050-2.2.1, МУТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-АХТ-2.1.1.4, АЗДҮАХ-2.1.1 | 8. Иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулан өвчлөлийг бууруулах “Эрүүл иргэн” дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ. | 12 | - | Хөтөлбөр батлагдаж нийт үзлэгээс урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 4.0 хувиар нэмэгдсэн байна. | 133500000 төгрөг | Тус онд “Эрүүл иргэн” дэд хөтөлбөрийг батлуулж хөтөлбөрийн 1.7-д төлөвлөгдсөний дагуу “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг 2022.05.03-ны өдөр 12 их эмч, 13 сувилагч, тусгай мэргэжилтэн нийт 25 хүний бүтэц орон тоотойгоор 10 амбулотариин тусламж үйлчилгээ, шинжилгээ, оношилогоог хийх хүчин чадалтайгаар албан ёсоор нээж, тус төвөөр 2022 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар эрт илрүүлэх үзлэг шинжилгээ оношилгоонд 0-17 насны 3667 хүүхдийг, 18-аас дээш насны 2377 хүн, нийт 6044 иргэдийн үзлэгт хамрууллаа. Мөн БОЭТ-ийн дэмжих төвөөр төр, хувийн хэвшлийн 31 албан байгууллагын 2510 ажилтан, албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн 1703 сурагч нийт 4213 хүнийг, Оюутны эрүүл мэндийг дэмжих сараар 480 оюутныг үзлэгт хамруулж, “Нутгийн намар” арга хэмжээг сумдад зохион байгуулж нийт 4477 иргэд, нийт 20370 иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсан байна. Эрт илрүүлгийн болон урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулснаар үзлэг оношилгооны хамралтын хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 хувиар нэмэгдсэн байна. Хөтөлбөрийн зорилт болох үйлчилгээний болон орчны стандартыг сайжруулахаар орон нутгийн дэмжлэгээр хийгдэх Мөст сумын эмнэлгийн засвар, моргийн барилгын ажил, Баатархайрхан өрхийн Эрүүл мэндийн төвийн засварын ажил дуусч, Дарви сумын Эрүүл мэндийн төвийн засвар, Эрүүл мэндийн газрын барилгын сантехникийн засварын ажлууд 70-90 хувийн гүйцэтгэлтэй, Буянт өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын газрын асуудлыг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэрлэж, төсвийн тооцоо судалгааг хийж эхлүүлээд байна. Мөн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор Мянгад, Дөргөн, Ховд сум, өрхийн 6 эрүүл мэндийн төвүүд, нийт 9 эрүүл мэндийн төвд яаралтай тусламжийн машин, улсын болон орон нутгийн хөрөнгөөр 42 ширхэг мотоциклыг багийн эмч нарт олголоо. | |
| 9 | | 9. Халдварт өвчин ялангуяа бэлгийн замын /тэмбүү/ дамжих халдвар, сүрьеэ өвчний тархалтыг хязгаарлана. | 12 | - | Халдварыг өнгөрсөн оны мөн үеэс 0.5 хувиар бууруулсан байна. | 120 сая төгрөг | Тус онд давхардсан тоогоор шинээр хяналтанд орсон жирэмсэн 5378 эмэгтэйчүүдэд БЗДХ-ын илрүүлэх шинжилгээг хийж 16 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 16 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Мөн сонгосон сумууд болох Мөнххайрхан, Мөст, Цэцэг, Манхан Мянгад сумдад, бэлгийн замаар дамжих халдвар буюу ХДХВДОХ, тэмбүү, сүрьеэ илрүүлэх үзлэгийг 468 иргэнд үзлэг оношилгоо хийхэд 51 иргэн шинжилгээгээр халдвартай болох нь батлагдаж, Цэцэг сумын Хөшөөтийн уурхайн 125 иргэнийг ХДХВДОХ, тэмбүүг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамруулахад 4 халдварын тохиолдол бүртгэгдэж 55 иргэнийг хяналтанд авч эмчилгээнд хамрууллаа. 2022 онд 2421 хүнд сүрьеэ өвчний учир, 483 хүнд хяналтын, 1548 хүнд урьдчилан сэргийлэх, 1896 хүнд эрт илрүүлгийн, нийт 4599 иргэнд сүрьеэг илрүүлэх үзлэг оношилгоог хийж, хавьтлын 726 иргэнийг үзлэг оношилгоонд хамрууллаа. Эхний 10 сарын байдлаар сүрьеэгийн 77 тохиолдол бүртгэгдсэнээс эмэнд тэсвэртэй 36, эмэнд мэдрэг 41 тохиолдол байгаагаас уушгины бус 14, уушгины 24 тохиолдол бүртгэгджээ. Сумдаас нийт 288 сорьцыг БОЭТ-ийн сүрьеэгийн лабораторид илгээснээс 3 өвчлөл илэрч, аймгаас ХӨСҮТ-ийн лабораторид 89 сорьц илгээснээс эмэнд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дасалтай сүрьеэ 4, эерэг илэрсэн 6 сорьц бүртгэгдэж хяналтанд авлаа. Цэцэг сумын Хөшөөтийн уурхайд ажиллаж буй зорилтот бүлгийн иргэдээс сүрьеэгийн үзлэг шинжилгээнд 146 иргэн хамрагдснаас 40 нь 14 хоногоос дээш хугацаанд ханиалгасан зовиуртай тул сорьцыг вирусологийн лабораториор шинжлүүлж шийдвэрлүүллээ. | |
| 10 | | 10. Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна. | 12 | - | Эх хүүхдийн эндэгдлийг 2.5 хувиар бууруулсан байна. | 40 сая төгрөг | “Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ” дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан батлуулж 2 зорилтын хүрээнд 3 томоохон арга хэмжээг дэвшүүлэн ажиллаж байна Хөтөлбөрийн 1-р зорилтын хүрээнд эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн байдалд судалгаа хийж БОЭТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн клиникт эх барих, эмэгтэйчүүдийн эрчимт эмчилгээний чиглэлээр мэргэшсэн эмчийг бэлтгэн ажиллуулж, эрчимт эмчилгээний өрөөнд хяналтын монитор, өвчтний автомат ор, дуслын автомат шахуурга, дефибрилятор, хүчилтөрөгчийн аппарат зэрэг нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулж тусламж үзүүлэх боломжоор хангасан, 2-р зорилтын арга хэмжээний хүрээнд өсвөр үеийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн эмчийг бэлтгэж, өсвөр үеийн нөхөн үржихүйн кабинетийн үйл ажиллагааг ажиллуулснаар үйл ажиллагаа тогтмолжсон, 3-р зорилтын арга хэмжээний хүрээнд Эх, хүүхдэд үзүүлэх тумсламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Mindray брендийн зөөврийн хэт авиан оношилгооны аппарат, Medison 3D эхо аппарат, 2 ширхэг ургийн зүрхний цахилгаан бичлэгийн аппаратыг тус тус нийлүүлснээр эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний чанарыг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайжруулахад ихээхэн ач холбогдол өгч, ургийн төрөлхийн хөгжлийн гажгийн 14 тохиолдлыг илрүүлж, амьдралд үл нийцэх хөгжлийн гажгийн 4 тохиолдлыг тасалсан, хөдөөгийн сумдын эрүүл мэндийн төвийн эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор алслагдсан, эндэгдэл, хүндрэл өндөртэй сумдад эх барих эмэгтэйчүүдийн 7, хүүхдийн 7 нийт 14 эмчийг ажиллуулж эх, хүүхдэд үзүүлэх тусмламж үйлчилгээг иргэддээ ойртуулж байгаа зэрэг үр дүнд хүрсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ. | |
| 11 | 4. АХ-2050-2.2.15, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.3.4, АЗДҮАХ-2.1.9 | 11. Эрэгтэйчүүдэд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх “Эрүүл эр хүн” хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ. | 12 | - | Хөтөлбөрийг боловсруулж батлуулсан байна. | 86 сая төгрөг | "Эрүүл эр хүн” хөтөлбөрийг боловсруулан батлуулж тус онд хөтөлбөрт тусгагдсан “Андрологийн кабинет” байгуулах төсөл арга хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангаас 86.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, БОЭТ-ийн 3 давхрын 2 өрөөг “Андрологийн төв”-ийн зориулалтаар тохижуулж шаардлагатай багаж, лабораторийн урвалж, тоног төхөөрөмжийг Biosystems компанитай гэрээлэн нийлүүлж үйл ажиллагааг эхлүүллээ. Мөн уг кабинетэд ажиллах эмч 1, сувилагч 1-ийг бэлтгэж ажиллуулж байна. | 100% |
| 12 | 5. АХ-2050-2.2.26, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.11.1, | 12. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлнэ. | 12 | - | Барилгын ажлыг 40 хувьд хүргэнэ | - | Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-6” төслийн хүрээнд БОЭТ-ийн одоо байгаа эмнэлгийн барилгыг өргөтгөн, дутагдалтай байгаа оношилгоо, эмчилгээний хэсгийг нэмэлтээр оруулах зорилгоор 150 ор бүхий эмнэлэг барихаар 2 удаагийн танилцуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулж, эмнэлгийн барилгын зураг төсөлд оруулах саналыг хүргүүлсэн бөгөөд төслийн үйл ажиллагааны | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | АЗДҮАХ-2.1.17. | | | | | | судалгаа, бэлтгэлийн үйл ажиллагаа явагдаж байна. | |
| 13 | | 13. Зооноз өвчин судлалын барилгын ажлыг эхлүүлнэ | 12 | - | Орон нутагт Зоонозын өвчин судлалын төвийн барилгын ажлыг эхлүүлсэн байна. | | Зооноз өвчин судлалын төвийн барилгын зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулж холбогдох яамдад хүргүүлсэн ба одоогийн үйл ажиллагаа явуулж буй барилгатай Эрүүл мэндийн сайд газар дээр нь танилцаж шинээр барихаар шийдвэрлэсэн. | 50% |
| 14 | 6. АХ-2050-2.2.7, МУТЖҮЧ-2.2.1, ЗГҮАХ-АХТ-1.1.3.2, ЗДҮАХ-2.1.11 | 14. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ѐс зүй, харилцаа хандлага, мэдлэг чадварыг дээшлүүлэх, гадаад, дотоодод сургаж мэргэшүүлэх “Чадварлаг эмч, мэргэжилтэн” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | 12 | - | Хөтөлбөрийг боловсруулж, батлуулсан байна. | 20 сая төгрөг | Хөтөлбөрийн хүрээнд шилдэг эмч шалгаруулах журмын дагуу шилдэг эмчээр БОЭТ-ийн Мэс заслын тасгийн эрхлэгч, их эмч Ж.Ганхуяг, Рашаант өрхийн Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч З.Цоож, Алтай сумын Эрүүл мэндийн төвийн их эмч Т.Ганчимэг, шилдэг эмнэлгийн мэргэжилтнүүдээс анх удаа Монгол Улсын “Сувилахуйн судлалын зөвлөх зэрэг” хамгаалсан Хүний нөөцийн албаны менежер Т.Энхтуяа, төрөх тасгийн хагалгааны сувилагч Б.Сувданчимэг, гемадиализийн техникч Т.Ганбүүрэг, Эрчимт эмчилгээний тасгийн туслах сувилагч Х.Цэцэгээ, Жаргалан өрхийн эрүүл мэндийн төвийн бага эмч Ч.Хандмаа, Зэрэг сумын эрүүл мэндийн төвийн багийн бага эмч А.Цагаанбаяр, Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төвийн сувилагч Ц.Байгалмаа зэрэг 10 хүнийг шалгаруулж тус бүр 10.0 сая хүртлэх төгрөгийн тэтгэлэгийг үзүүллээ. | 100% |
| 15 | 7. АХ-2050-2.2.4, 2.2.26, МУТЖҮЧ-2.2.8, ЗГҮАХ- | 15. БОЭТ-д шинэ технологи, ажилбарыг нутагшуулах, мэргэшүүлэх, чадавхжуулахаар лавлагаа | 12 | - | Гүйцэтгэлээр | 6 сая төгрөг | Тухайн онд “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах, тархины үхэл тодорхойлох”, “Элэг, цөс, нойр булчирхай болон хөхний хавдрын мэс заслын менежмент” сэдвүүдээр лавлагаа төвүүдээс 10 эмч мэргэжилтнийг урин ажиллуулж ажлын байрны дагалдан сургалтаар 45 эмч, мэргэжилтнийг хамрууллаа. Мөн эрүүл мэндийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | АХТ-2.1.9.1 АЗДҮАХ-2.1.19 | төвүүдээс томилогдон ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн орон нутагт амьдрах хугацааны байрны асуудлыг шийдвэрлэнэ. | | | | | тусламж үйлчилгээнд хамгийн сүүлийн үеийн технологийн шинэчлэлтэй программ хангамж бүхий олон үйлдэлтэй “Ангиографийн оношилгоо”-ны тоног төхөөрөмжийг суурилуулж, БОЭТ-д лавлагаа төвийн 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ажлын байран дээр нь дадлагжуулж, ажиллаа. Энэхүү оношилгоо эмчилгээг мэдрэл, зүрх судас, элэгний эмгэгтэй нийтдээ 40 гаруй хүнд үзүүлж, аймгуудаасаа анхдагч нь болж, нийтдээ 17 эмчийг лавлагаа төвөөс урин ажиллуулжээ. Түүнчлэн ходоодны ургацыг авах дурангийн мэс ажилбарыг анх удаа орон нутагт амжилттай хийснээс гадна цусны хүчил шүлтийн шинжилгээ, дутуу нярайг амьсгалын аппаратаар удирдах, хавдрын шалтгаантай элэг тайрах, ходоод тайрах, уушигны багтаамж (спирограмм) үнэлэх, дурангаар ходоодны цус алдалтыг тогтоох полип авах, дутуу нярайн ретинопатийн скрининг хийж эхэлсэн зэрэг 7 төрлийн шинэлэг технологи, санаачлагыг нэвтрүүллээ. | |
| 16 | 8. АХ-2050-2.2.4, 2.2.26, МУТЖҮЧ-2.2.8, ЗГҮАХ-АХТ-2.1.9.1, АЗДҮАХ-2.1.21 | 16. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг бий болгон, эмч мэргэжилтэнг чадавхижуулна. | 12 | - | БОЭТ-д төгсөлтийн дараах сургалт явуулдаг болсон байна. | 3.5 сая төгрөг | Тус онд Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийг авсан нь орон нутагтаа үндсэн мэргэжлийн эмч, мэргэжилтэн бэлтгэх боломж бүрдэж эмч, мэргэжилтний хамрагдалтыг нэмэгдүүлэх, боловсон хүчнийг орон нутагтаа чадавхижуулах боломжтой болж, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран орон нутагт 6 сургагч (яаралтай тусламж 2, Хүүхэд 2, Эх барих 1, дотор 1) багшийг бэлтгэв. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | 9. АХ-2050-2.2.4, 2.2.26, МУТЖҮЧ-2.2.8, ЗГҮАХ-АХТ-2.1.9.1, АЗДҮАХ-2.1.19 | 17. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмж, бүртгэл, хяналтыг цахимжуулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ. | 12 | - | Цахим үйлчилгээ бий болсон байна. | | Эрүүл мэндийн тухай хуулийн зохицуулалтын хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч нар олон улсын эмнэлзүйн удирдамж, ангиллын дагуу эм бичих боломжийг бүрдүүлж, бүх эмийн сан сонгон шалгаруулалтгүйгээр Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх боломжийг бий болгосон. Тархины саажилт, уналт таталттай 0-19 насны хүүхдийн уналт, таталтын эсрэг эмийг ЭМД-ын сангаас 100 хувийн хөнгөлөлттэй үнээр, 72-оос дээш настай хүмүүсээс хурууны хээ шаардахгүйгээр эмийн нэршлээр эмчээсээ код аваад хамгийн ойр байгаа эмийн сангаасаа эмээ авах боломжийг хууль журмаар зохицуулж, эмийн жорыг цахим хэлбэрт оруулах замаар эмийн зохистой хэрэглээ төлөвшүүллээ. | 100% |
| 18 | 11. АХ-2050-2.2.25, МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-АХТ-2.1.6.1, 2.1.7.12, АЗДҮАХ-2.1.25 | 18. Эрүүл мэндийн үйл ажиллагаанд цахим үйлчилгээ, оношилгоо, алсын зайн анагаах ухааныг ашиглана. | 12 | - | Эрүүл мэндийн байгууллагад цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна | 141.1 сая төгрөг | Тус онд эмнэлгүүдийн мэдээлэл, технологийн техник хангамжийг сайжруулахад 103.2 сая, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэхэд 1.9 сая төгрөгийг зарцуулснаас гадна Эрүүл мэндийн яамнаас 182.8 сая төгрөгийн өртөг бүхий 93 ширхэг суурин комьпютерыг Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар сум, өрхийн 23 эрүүл мэндийн төвүүдэд 23 ширхэг зөөврийн комьпютерыг, ОНХС-ийн 40.0 сая төгрөгийн хөрөнгөөр 6 өрх, 4 сум, БОЭТ-д нийтдээ 12 ширхэг комьпютер, нийт 128 ширхэг компютерийг олгосноор төлбөр тооцоо, мэдээ, тайлангийн бүрдүүлэлт стандартын дагуу хийгдэх, бүртгэл мэдээллийн системийг сайжруулахад тодорхой үр дүн өглөө. 2022 оны байдлаар 5 суманд эрүүл мэндийн төвийг алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлж, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сум өрхийн эрүүл мэндийн байгууллагууд Zoom болон телемедицин төхөөрөмж суурилуулж ашигласнаар анхан шатны эмнэлэг болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс зайнаас яаралтай тусламж үйлчилгээний зөвлөгөө авах боломж бүрдсэнээс гадна мэдээ мэдээлэл, эмчийн үзлэг, өвчний түүхийг цахимжууллаа. | |
| 19 | 12. АХ-2050-2.2.17, АЗДҮАХ-ийн 2.1.12, 2.1.13 | 19. Аймгийн төвийн Буянт өрхийн ЭМТ-ийн барилгыг шинээр барьж, Мянгад сумын эмнэлгийн барилгыг өргөтгөж, Дарви сумын барилгыг засварлана. | 12 | - | Барилгуудын санхүүжилтийн асуудал шийдэгдэж барьж эхэлсэн байна. | 2100,0 сая төгрөг | Улсын төсвийн 5100.0 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2018-2022 онд Хүүхдийн эмнэлгийн 50 орны хүчин чадалтай барилга угсралтын ажлыг "Мото блок" ХХК хийж гүйцэтгэн 2022 онд улсын комисст хүлээлгэн өгсөн. Дөргөн сумын 10 ортой Эрүүл мэндийн төвийн барилга усралтын ажлыг "Толхын ойл"ХХК гүйцэтгэж 80 хувийн гүйцэтгэлтэй он дамжин хэрэгжинэ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Буянт багийн өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг "Жаргалант ургамал" ХХК гүйцэтгэж ажлын явц 50 хувьтай, он дамжин хэрэгжинэ. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Булган сумын Булган өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг 2100.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр хувийн компани хандиваар барьж улсын комисст хүлээлгэн өгсөн. | 100% |
| 20 | 1. АЗДҮАХ-ийн 2.2.1 | 20. Иргэдийн нийтийн биеийн тамир, их спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, нийтийн биеийн тамирын арга хэмжээг | 12 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт 50 хувь | - | Аймгийн бүх сумдад спорт сурталчлах нийтийн биеийн тамирын өдөрлөгийг бүсчилж зохион байгууллаа. Булган суманд баруун бүсийн сумууд, Манхан суманд төвийн бүсийн сумууд, Эрдэнэбүрэн суманд зүүн бүсийн сумуудын биеийн тамирын өдөрлөгийг спортын 5 төрлөөр амжилттай зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлагаар зохион байгуулагдасан “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” аянд аймгийн 17 сум 80 гаруй | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | санаачлан зохион байгуулах иргэд, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлнэ. | | | | | байгууллагын албан хаагчид, эрүүл мэндээ эрхэм болгосон ахмад буурлууд, хүүхэд багачууд, залуучууд идэвхитэй оролцож давхардсан тоогоор 211000 гаруй хүн дасгал хөдөлгөөнд хамрагдаж Ховд аймаг улсад тэргүүн байранд шалгарлаа. | |
| 21 | 2. АЗДҮАХ-ийн 2.2.2 | 21. “Спортын аварга” хөтөлбөр, тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулах журмыг шинэчлэн хэрэгжүүлнэ. | 12 | - | Хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувь | 75 сая төгрөг | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 67 дугаар тогтоолоор “Спортын аварга” дэд хөтөлбөр, Олимп, дэлхий, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилт гаргасан тамирчин дасгалжуулагч нарт олгох мөнгөн урамшууллын журмын хамт батлуулан хэрэгжүүлж байна. Энэ оны тамирчдын урамшуулал 12 сард олгуулахаар бичиг баримтаа бүрдүүлж байна. Улсын аварга шалгаруулах тэмцээнүүд дуусаагүй байна. Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийг 8-н төрлөөр тогтмол хичээллүүлж байна. Өсвөрийн шигшээ багт /Жүдо, Таеквондо, Чөлөөт бөх, Волейбол, Сагсан бөмбөг, Ширээний теннис, Бокс, Шатар/ нийт 673 тамирчин тогтмол бэлтгэлд хамрагдаж бүс, улс, тив дэлхийн 23 тэмцээнд амжилттай оролцож 315 медаль хүртээд байна. | 100% |
| 22 | 3. АЗДҮАХ-ийн 2.2.3. | 22. Орон нутгийн спортын клубуудыг магадлан итгэмжлэлд хамруулж, спортоор хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | 12 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт 50 хувь | | Энэ онд 4 спорт клубад 190 гаруй иргэд тогтмол хичээллэсэн байна. 2023 онд магадлан итгэмжлэлд орох 1 фитнесс клуб саналаа өгсөн байна. | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | 4. АЗДҮАХ-ийн 2.2.4 | 23. Олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, тамирчид, дасгалжуулагчдын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | 12 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт 30 хувь | 25 сая төгрөг | Ширээний теннисний Ахмадын улсын аварга шалгаруулах 27 дахь удаагийн тэмцээнийг Ховд аймагт зохион байгуулсан. Тус тэмцээнд Улаанбаатар хот, 18 аймгийн 40-с дээш насны 200 гаруй тамирчид оролцлоо. Багийн нийлбэр дүнгээр Жигүүр гранд групп тэргүүлж, дэд байранд Орхон аймаг, гутгаар байранд Хэнтий аймгийн багууд тус тус шалгарсан. "МОНГОЛЫН ОЛОН ӨДӨР 2022" арга хэмжээг дугуйн холбоо, клубүүдтэй хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Олон улсын хэмжээний мастер 4, спортын мастер 12 тамирчин нийт 120 гаруй дугуйчид оролцлоо. Олон зай төрөлд Ховд-Булган, Ховд-Манхан, Ховд-Эрдэнэбүрэн, Ховд-Дарви гэсэн маршрутаар зохиогдлоо. | 90% |
| 24 | 5. АЗДҮАХ-ийн 2.2.5 | 24. Аймгийн Засаг даргын дэргэд амжилт гаргаж, өсөж дэвших ирээдүйтэй өсвөрийн шигшээ баг, тамирчдыг бэлтгэж, материаллаг баазаар хангана. | 12 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт 30 хувь | 5 сая төгрөг | Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийг 8-н төрлөөр тогтмол хичээллүүлж байна. Өсвөрийн шигшээ багт /Жүдо, Таеквондо, Чөлөөт бөх, Волейбол, Сагсан бөмбөг, Ширээний теннис, Бокс, Шатар/ нийт 673 тамирчин тогтмол бэлтгэлд хамрагдаж бүс, улс, тив дэлхийн 23 тэмцээнд амжилттай оролцож 315 медаль хүртээд байна. | 100% |
| 25 | 6. АЗДҮАХ-ийн 2.2.8 | 25. Рашаант-Цамбагарав, багт стандартын шаардлага хангасан биеийн тамирын болон тоглоомын | 12 | - | Барилгын гүйцэтгэл 100 хувь | 140 сая төгрөг | Рашаант-Цамбагарав, багт стандартын шаардлага хангасан биеийн тамирын болон тоглоомын талбай байгуулж, ашиглалтад хүлээн авлаа. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | талбай байгуулна. | | | | | | |
| 26 | 7. АЗДҮАХ-ийн 2.2.8 | 26. Алагтолгой-Хайрхан багт стандартын шаардлага хангасан биеийн тамирын болон тоглоомын талбай байгуулна | 12 | - | Барилгын гүйцэтгэл 100 хувь | 1.5 тэрбум төгрөг | Бугат, Хайрхан багт стандартын шаардлага хангасан тоглоомын талбай байгуулах ажлыг улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Элбэг гүн" ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70 хувитай явагдаж байна. | 90% |
| 27 | 8. АЗДҮАХ-ийн 2.2.9 | 27. “Төв цэнгэлдэх хүрээлэн”-д их засвар хийнэ. | 12 | - | Гүйцэтгэл 100 хувь | 239 сая төгрөг | Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар /Жаргалант сум/-н ажлыг 2021-2022 онд 200,0 сая төгрөг тусгагдан батлагдсан. Өнгөрсөн жил засварын ажлыг "Алтайн бөөрөг" ХХК хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгч, үлдэгдэл санхүүжилтийг энэ жил олгосон. Харин Төв цэнгэлдэх хүрээлэнгийн урсгал засварт зориулан 2021 онд 20 сая, 2022 онд 19,0 сая төгрөгөөр зарцуулсан. | 100% |
| 28 | 9. АЗДҮАХ-ийн 2.2.10 | 28. Спортын салбарын тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэн, материаллаг баазыг бэхжүүлнэ. | 12 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт 50 хувь | 38 сая төгрөг | Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулатаар Боксын иж бүрэн рингийг 40 сая төгрөгөөр батлуулж, ашиглалтад хүлээн авч БТСГазарт хүлээлгэн өглөө. | 100% |
| 29 | 10. АЗДҮАХ-ийн 2.2.11 | 29. Биеийн тамир, спортын газрын их зааланд урсгал, бага заалны | 12 | - | Барилгын засвар 50 хувь | | Хугацаа болоогүй. /2022-2024 онуудад их зааланд урсгал, бага заалны барилгад их завсар хийнэ./ Зураг төсөв хийгдсэн. | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | барилгад их завсар хийнэ. | | | | | | |
| 30 | 11. АЗДҮАХ-ийн 2.2.12 | 30. Хүүхэд залуучууд, төрийн албан хаагчдын эрүүл мэнд бие бялдрыг хөгжүүлэх “Дугуйтай Ховд” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 12 | - | Хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувь | 7 сая төгрөг | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 172 дугаар тогтоолоор “Дугуйтай Ховд” дэд хөтөлбөрийг батлуулж, 2 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "МОНГОЛЫН ОЛОН ӨДӨР 2022" арга хэмжээг дугуйн холбоо, клубүүдтэй хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Олон улсын хэмжээний мастер 4, спортын мастер 12 тамирчин нийт 120 гаруй дугуйчид оролцлоо. Олон зай төрөлд Ховд-Булган, Ховд-Манхан, Ховд-Эрдэнэбүрэн, Ховд-Дарви гэсэн маршрутаар зохиогдлоо. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2.2.12 дахь заалтыг хэрэгжүүлэх, ундаг дугуйг өдөр тутмын хэрэглээ болгох, хүүхэд залуучуудын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх дугуй сонирхогчдын тоог нэмэгдүүлэх, сурталчлан таниулах зорилгоор “Монгол Алтай- дугуйн холбоотой хамтран “Засмал замын дугуйн аймгийн аварга” шалгаруулах тэмцээн, “Уулын дугуйн аймгийн аварга” шалгаруулах тэмцээнийг 5 насны ангиллаар зохион байгууллаа. Тус тэмцээнд нийт 100 гаруй тамирчин оролцож 18 шилдэг тамирчин шалгарсан. “Алтан дөрөө” клуб аймгийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулсан байна. | 100% |
| 31 | 12. АЗДҮАХ-ийн 2.2.13 | 1. Иргэдийн эрүүл дадал хэвшлийг дэмжих зорилгоор гүйлт, алхалтын замыг | 12 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт 50 хувь | 300 сая төгрөг | Иргэдийн эрүүл дадал хэвшлийг дэмжих зорилгоор гүйлт, алхалтын замыг аймгийн Орон нутгийн төсвийн 300,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Их гүүр, Шар сүмийн чиглэлд барьж, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Их гүүр, Шар сүмийн чиглэлд байгуулна. | | | | | ашиглалтад хүлээн авч, иргэд олон нийт ашиглаж эхэллээ. | |
| 32 | 1. АЗДҮАХ-ийн 2.3.1 | 1. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, яслийн үйлчилгээг өргөжүүлнэ | 12 | - | Хүүхэд харах үйлчилгээний тоо 16, яслийн бүлгийг 1-ээр нэмэгдүүлнэ. | | Хүүхэд харах үйлчилгээг 2021 оны 03 дугаар сараас аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт шилжүүлсэн бөгөөд хүүхэд харах үйлчилгээг Алтай, Булган, Үенч сумдын 6 төв хэрэгжүүлж 30 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн цэцэрлэгт давхар бүртгэлтэй суралцаж байгааг боловсролын салбарын мэдээллийн системд тулгаж хяналт хийж давхардсан сурагчийн мэдээллийг ГБХЗХГ-т мэдэгдэж хамтран ажиллаж байна. Аймгийн хэмжээнд цэцэрлэг яслийн зориулалттай баригдсан 16 дугаар цэцэрлэгт яслийн 3 бүлэгт 61 хүүхэд хичээллэж байна. | 100% |
| 33 | 2. АЗДҮАХ-ийн 2.3.2 | 1. Сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхдүүдийг хамруулж, хувилбарт сургалтын чанар хүртээмжийг сайжруулан, хамран сургалтыг нэмэгдүүлнэ. | 12 | - | СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлж 84 хувьд хүргэнэ | | Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн 33, хувийн өмчийн 8 цэцэрлэг нийт 41 цэцэрлэгт өдрийн болон хувилбарт сургалтаар 250 бүлэгт 7504 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд өдрийн 227 бүлэгт 6627 хүүхэд хамрагдаж байна. Хувилбарт сургалтаар 23 бүлэгт 877 хүүхэд хамрагдаж байна. Үүнээс 50 бага бүлэгт 1339, 61 дунд бүлэгт 1759, 52 ахлах бүлэгт 1588 64 бэлтгэл бүлэгт 1941 хүүхэд суралцаж байна. 2021 оны хүн амын тоог нас дэвшүүлэн тооцоход 2-5 насны 9057 хүүхэд цэцэрлэгт хамрагдахаар байгаагаас 7504 буюу 82,8% нь хамрагдаж байна. Энэ нь өнгөрсөн хичээлийн жилийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 2021-2022 оны хичээлийн жилийн намрын /ковидтой/ байх үеийн хамрагдалтаас 22,4% иар их, хаврын ковидын хорио тавигдсаны хойно хамрагдсан хувиас 5,3%-аар нэмэгдсэн байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хувилбарт сургалт өнгөрсөн хичээлийн жилд 15 бүлэгт 1006 байсан бөгөөд энэ хичээлийн жилд 129 хүүхдээр буурч өдрийн бүлэгт 830 хүүхдээр нэмэгдсэн байна. Хувилбарт сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилт тавьж ажилласан боловч хувилбарт сургалтаас өдрийн бүлэгт сургах нь илүү чухал тул өдрийн ангид шилжиж суралцсан. | |
| 34 | 3. АЗДҮАХ-ийн 2.3.3 | 1. 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ. | 12 | - | 5 настай хүүхдийн 97 хувийг хамруулсан байна. Бага боловсролын хамралт 97,5 суурь боловсролын хамралт 96,5 байна | | 2022-2023 оны хичээлийн жилийн намрын статистик мэдээгээр өдрийн ахлах бэлтгэл бүлэгт 1701, хувилбарт сургалтаар 226 хүүхэд буюу нийт 1927 хүүхэд 5 настай хамрагдаж байгаа нь энэ хичээлийн жилийн 7504 хүүхдийн 25,7%-ийг эзэлж байгаа бөгөөд 2021 оны хүн амын тоогоор 5 настай хамрагдах 2103 хүүхдийн 91,6%-ийг хамруулсан нь зорилтот түвшинд хүрэхээс 6,9%-аар бага хамруулсан байна. Сургуулийн өмнөх боловсролд хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй 17 хүүхэд сурч байгаа бөгөөд эдгээрээс 5 настай 7 хүүхэд байна. Хөдөөгийн дуут, зэрэг, мөст, цэцэг сумдын цэцэрлэгт 4 хүүхэд бусад хүүхэд аймгийн төвд суралцаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 25 сургуулийн 752 бүлэгт өдрөөр 20966 хүүхэд суралцаж байгаагаас бага боловсролын 336 бүлэгт 10412 хүүхэд, дунд ангийн 259 бүлэгт 7063 хүүхэд, ахлах ангийн 157 бүлэгт 3491 хүүхэд суралцаж байна. Бага боловсролын 1 дүгээр ангид 2123 хүүхэд суралцахаар байгаа бөгөөд энэ хичээлийн жил 6 настай 1885 хүүхэд суралцаж байгаа нь нийт суралцах 6 настай хүүхдийн 88,7% аймагтаа элсэн суралцаж байна. Мөн 1 дүгээр ангид орой элссэн өөрөөр хэлбэл 7 настай 298, 8 настай 15 хүүхэд байна. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 95,4% байгаа нь хүрэх | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | түвшингээс 0,6% иар бага байна. Бага боловсролын хамран сургалтын бохир жин нь 95,6% байгаа нь хүрэх түвшингээс 0,4%-р бага байна. Суурь боловсролын хамран сургалтын бохир жин нь өөрөөр хэлбэл 11-14 насны сурч байгаа хүүхэд 94,8% байгаа нь хүрэх түвшингээс 1,5% бага байна. Суурь боловсролын цэвэр жин буюу дунд ангид сурч байгаа 11-14 насны хүүхдийн эзлэх хувь 91 байна. | |
| 35 | 4. АЗДҮАХ-ийн 2.3.4 | 1. Чанартай боловсрол" дэд хөтөлбөр хэрэгжүүлж орон нутгийн ерөнхий боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэн, сургалтын чанарыг сайжруулна. | 12 | - | Чанарын үнэлгээний аймгийн нэгдсэн хуваарийн дагуу 2-12 дугаар ангийн чанарын үнэлгээг зохион байгуулж дундаж гүйцэтгэлийг 45 хувьд хүргэнэ. | | Боловсролын үнэлгээний төвийн баталсан удирдамжийн дагуу "Чанарын үнэлгээ"-г PISA олон улсын үнэлгээнд баримжаалсан чанарыг үнэлгээний шалгалт, судалгааг 24 сургуулийн давхардсан тоогоор 16566 суралцагч, 20 судлагдахуунаар 145 шалгалт өгч 69,8 оноогоор үнэлэгдсэн нь улсын дундаж /72,5/-аас 2,7-оор, аймгуудын дундаж /71.7/-аас 1,9-ээр бага байна. Гүйцэтгэлийн үнэлгээг шалгаснаас гадна багш нарын талаар эцэг эх асран хамгаалагч, суралцагчаас санал авахад гүнзгийрүүлсэн сургалттай Прогресс сургууль 73,6%, лаборатори 1 дүгээр сургууль 72,1%-тай, ердийн 22 сургууль-69,3%-тай шалгагдсан бол аймгийн төвийн сургуулиуд /7 сургууль/ 70,8%, хөдөөгийн сургууль /17 сургууль/-69%-тай үнэлэгдсэн. Үнэлгээ асуулгаа хамгийн өндөр хувьтай шалгагдсан Цаст-Алтай цогцолбор -75,2%-тай бол хамгийн бага үнэлгээтэй мөст сумын сургууль-64%-тай шалгагдсан. Аймгуудын дундаж оноо 71,7%-аас дээш үнэлэгдсэн 7 сургууль, 17 сургууль доош үнэлэгдсэн. Бичгийн шалгалтын үнэлгээ улсад-51,1%, аймгуудын дундаж-48,9% тай байгаа бол манай аймгийн хувьд 48,3%-тай байгаа нь улсаас - 2,8%, аймгуудаас 0,3%-аар бага байна. Эдгээр үнэлгээ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нь бүх ангийн сурагчдаас түүврийн аргаар сонгогдсон сурагчдаас шалгалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан бол дэд хөтөлбөрийн журмын дагуу 9 дүгээр ангийн математикийн хичээлээр 46 бүлгийн 1388 сурагч буюу нийт хүүхдийн 91,9% , 9 дүгээр ангийн монгол хэлний хичээлээр 57 бүлгийн 1496 буюу 95,2%, 5 дугаар ангийн монгол хэл 68 бүлгийн 1956 буюу 95,8%, 5 дугаар ангийн биеийн тамир эрүүл мэндийн 68 бүлгийн 2014 буюу 95,4%, СӨББ-ын ахлах бүлгийн танин мэдэхүйн хөгжлийн түвшний хөгжлөөр шалгалт авсан бөгөөд нийт чанарын үнэлгээний дундаж 53%-тай шалгагдсан байна | |
| 36 | 5. АЗДҮАХ-ийн 2.3.5 | 1. Сургуулиудын бүтэц хэв шинжийг орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн оновчтой болгож, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, олон улсын хөтөлбөртэй сургуулиудыг хөгжүүлнэ. | 12 | - | Булган сумын сургуулиудыг төрөлжсөн сургалтын хөтөлбөрөөр хичээллүүлнэ. Цаст-алтай цогцолбор сургуульд Кембрижийн хөтөлбөрөөр 3 судлагдхууны сургалт явуулж эхэлсэн байна. | | Аймгийн хэмжээнд сургуулиуд нь цогцолбор 2, гүнзгий сургалттай 2, лаборатори 1, ердийн сургалттай 20 сургуультай үйл ажилагаа явуулж байна. Жаргалант сумын ЕБ-ын “Прогресс” сургууль 6, 10 дугаар ангиас англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай тус бүр 1 ангийг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн авч, 2022-2023 оны хичээлийн жилд 6-р ангийн 1 бүлэгт 24, 7-р ангийн 1 бүлэгт 25, 9 дүгээр ангийн 1 бүлэгт 24 , 10 дугаар ангийн 1 бүлэгт 18 нийт 4 бүлэгт 91 хүүхэд хичээллүүлж байна. Ховд их сургуулийн дэргэдэх ахлах сургууль 10-12 дугаар ангид математик, хими, физик, биологи, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай хөтөлбөр хэрэгжүүлж, БШУЯ-ны сайдын тушаалаар ЦАЦС-ыг Кембрижийн хөтөлбөрөөр сургалт явуулахаар шийдвэрлэсэн. | 100% |
| 37 | 6. АЗДҮАХ-ийн 2.3.6 | 1. Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, зан | 12 | - | Сургууль, цэцэрлэгт монгол ёс  заншлын | 15.4 сая төгрөг | Ховд нутагт төрснөөрөө бахархдаг өв соёл, эх түүхээ үр хойчдоо хадгалан үлдээх даган дуурайх, дээдлэх багаар ажиллах, бие даан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чанар, ёс суртахуунтай уялдсан сургалтын хөтөлбөрийг боловсруулан өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ. | | | өргөөг 10 цэцэрлэг, 5 сургуульд байгуулна. | | суралцах чадвар дадалтай өөртөө итгэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй найз нөхдийгөө хүндэтгэх, үүрэг хүлээх, хариуцлагатай байх чадваруудыг хөгжүүлсэн “Чадварлаг багш, сурагч, оюутан” дэд хөтөлбөрийг батлууллаа. Хөтөлбөрийн 3.2.2 арга хэмжээний “Бид Ховдын хүүхдүүд” аяныг зохион байгуулж, 25 сургууль 33 цэцэрлэгийн нийт 58 байгууллагууд хичээл сургалтын үйл ажиллагаандаа сурагч болон цэцэрлэгийн хүүхдүүдээр нутгийн уул ус, домог түүх, олон угсаатны бүжиг, дуу, тоглоом наадгай, судалгааны ажил гэх мэт 996 үйл ажиллагааг зохион байгуулж сургууль цэцэрлэгийн 490 бүлгийн 14547 хүүхэд багачууд аянд оролцож “Бид Ховдын хүүхдүүд”, “Багшийн хөгжил-Боловсрол, шинжлэх ухааны газар” гэсэн сошиал бүлгүүдээр үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлж 65875 хүний хандалт авч 8000 гаруй эерэг сэтгэгдлүүдийг үлдээсэн байна. Аяны хүрээнд сургууль цэцэрлэгүүд 15.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтуудыг хийж материаллаг баазаа бүрдүүлж байна. | |
| 38 | 7. АЗДҮАХ-ийн 2.3.7 | 1. Тогтвортой хөгжлийн боловсрол дэд хөтөлбөр боловсруулж олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийг хөгжүүлж сургууль бүхлээрээ ажиллах арга, | 12 | - | Олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийг тус бүр 3-аар нэмэгдүүлж, сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг 8 сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, | 3.4 сая төгрөг | Тогтвортой хөгжлийн боловсрол дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж, ЕБС-ын 24 сургуулийг тогтвортой хөгжлийн боловсрол, эко сургуулийн үзэл баримтлалын арга зүйн сургалтад бүрэн хамруулж, 7 цэцэрлэг эко цэцэрлэгийн анхан шатны сургалтад 7 цэцэрлэг хамрагдсан. Тогтвортой хөгжлийн боловсрол -2 төслийн зорилтод сургууль болох Мөнххайрхан, Буянт, Жаргалант 1, 2 дугаар сургуулиудын туршлагыг аймгийн төвийн 8 сургууль, 16 цэцэрлэгт түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ, сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа. “Тогтвортой хөгжлийн боловсрол–Ховд“ page цахим хуудас ажиллуулан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хандлагыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн, олон нийтийн оролцоо, түншлэлийг өргөжүүлнэ. | | | түншлэгч байгууллагын тоог 10-аар нэмэгдүүлнэ. | | олон нийтэд түгээж нийт гишүүдийн тоо 760 болж өнгөрсөн мөн үеэс 500 гишүүнээр нэмэгдсэн бөгөөд энэ оноос сургууль бүр цахим хуудас нээн ажиллуулж байна. Сурагчдын сайн дурын эко клубийн 30 гишүүдийг чадваржуулж, 24 сургуульд сайн дурын 24 эко клубтэй болж, гишүүдийн тоо 648-д хүрч өслөө. Тогтвортой хөгжлийн боловсролын интеграци хичээлийн 72 хөтөлбөр боловсруулж, 25 сургуульд 108 ширхэг 5 төрлийн гарын авлага ном тараасан. Мөн хөтөлбөрийн хүрээнд “Хоггүй-Ногоон ховд аймаг” бүтээлч аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж хог хаягдал бууруулах, ногоон байгууламж нэмэгдүүлэх, ус, эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр сургууль,цэцэрлэгүүд бүтээлч ажлыг өрнүүлж шалгаруулан 5 цэцэрлэг, 3 сургуулийг 3,4 сая төгрөгөөр дэмжиж урамшуулав. | |
| 39 | 8. АЗДҮАХ-ийн 2.3.8 | 1. Монгол хэл бичгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 12 | - | 4 зорилтын хүрээнд ажил үйлчилгээ хийгдсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 45 хувь | 7.8 сая төгрөг | Хөтөлбөрийн хүрээнд ЕБС, СӨБ-ын байгууллагаас монгол бичгээр гэрэлтдэг том хаяг-14, жижиг хаяг-56, 940 анги танхимын хаягийг монгол бичгээр хийж байршуулснаас гадна Жаргалант сумын 13 байгууллагыг том жижиг монгол хаягтай болголоо. ЕБС, СӨБ-ын байгууллагын албан хаагчдаас анхан шат-1074, дунд шат-703, ахисан шат 192 буюу 77 хувь нь монгол бичгийн сургалтад хамрагдаж, 66 байгууллагын 740 албан хаагчдад монгол бичгийн хичээлийг заажээ. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын /Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хүрээнд Монгол бичгийн хичээлийг МУГБ Б.Даваадорж/ Ховд ТВ бэлтгэн цахимаар нийтэд хүргэсэн ба хичээлийг Үндэсний бичиг, өв соёл-Олон ястны бахархал цахим хуудсаар түгээлээ. Мөн 1-р сургуулийн “Эх хэл | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичгийн өргөө” танхимаар дамжуулан Үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүй" сургалтыг зохион байгуулж, 16 сумын ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан, аймгийн ЗДТГ-ын хүрээний 44 байгууллагын 44, нийт 60 хүн хамрагдахаас 46-г нь хамрууллаа. Хэлний бодлогын үндэсний зөвлөл, архивын ерөнхий газраас зохион байгуулсан төрийн байгууллагын бичиг хэргийн ажилтнуудад албан бичгийг үндэсний бичгээр бичих сургалтад хамруулж, “Үнэт өв, үндэсний Дархлаа-Эх хэл минь” аяныг зохион байгууллаа. тус онд Монгол хэлний хичээлээр 5 /57.8%/, 9-р ангийн /50.3%/ анги нийтийн чанарын үнэлгээний шалгалтыг зохион байгуулж, Чанартай боловсрол дэд хөтөлбөрөөс 7.8 сая төгрөгөөр урамшууллаа. | |
| 40 | 9. АЗДҮАХ-ийн 2.3.9 | 1. Багш нарын мэргэжил ур чадварыг сайжруулна. | 12 | - | Хөтөлбөрийн хэрэгжилт 45 хувь | 21 сая төгрөг | Тус онд аймгийн ажил үйлсээрээ шилдгээр шалгарсан 5 багш нарт 21.0 сая төгрөгийн урамшууллыг олголоо. | 100% |
| 41 | 10. АЗДҮАХ-ийн 2.3.9. | 1. Амжилт гаргасан сурагчдыг урамшуулна | 12 | - | Хөтөлбөрийн хэрэгжилт 45 хувь | 6.9 сая төгрөг | Тус онд элсэлтийн ерөнхий шалгалтад 750-800 оноо авсан 18 сурагчдад 6.9 сая төгрөгийн урамшууллыг олголоо | 100% |
| 42 | 11. АЗДҮАХ-ийн 2.3.9 | 1. Олон улсын болон улсын түвшинд амжилт гаргасан оюутнуудыг урамшуулна | 12 | - | Хөтөлбөрийн хэрэгжилт 45 хувь | | МУИС-ын Ховд аймаг дахь салбар сургууль БНСУ-ын Чангшин их сургуультай хамтран Эрхзүй, Санхүүгийн менежмент, Програм хангамж мэргэжлийн чиглэлээр “2+2” хос дипломын бакалаврын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж тус онд 8 оюутаныг БНСУ-д хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулж байна. Мөн Тайваний Чиенкуо технологийн их сургууль хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 3 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцагчийг хятад хэлний бэлтгэл ангид Тайвань улсад тэтгэлэгтэй суралцуулхаар бүртгэл явагдаж байна. | |
| 43 | 12. АЗДҮАХ-ийн 2.3.10 | 1. "Стандарттай Ховд хөтөлбөр"-ийг сургууль цэцэрлэгийн орчин, үйл ажиллагаанд нэвтрүүлнэ | 12 | - | 5 сургууль, 8 цэцэрлэгийг стандарттай сургууль, цэцэрлэг болгоно. | | Аймгийн Засаг даргын тамгын газраас ерөнхий боловсролын 25 сургууль, төрийн өмчийн 33 цэцэрлэгийн удирдах ажилтнуудыг оролцуулан 2 өдрийн турш стандарттай Ховд хөтөлбөрийн хүрээнд нэгдсэн сургалтыг зохион байгуулсан.Сургужулийн орчинд хүүхдүүдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд анхаарч ойролцоо явган хүний замын гарц орчимд 12 хурд сааруулагчийг хийж, таних тэмдэг анхааруулгуудыг хийж байршуулж, сургуулийн эцэг эхийн төлөөллүүдийг графикаар гарцын зохицуулалтыг хийлгэж осолоос сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. | 70% |
| 44 | 13. АЗДҮАХ-ийн 2.3.11 | 1. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлнэ. | 12 | - | Хүүхэд ээлтэй орчныг нийт сургуулиудын 40 хувьд хүргэх | | Жаргалант сумын ЕБ-ын 3, 6, 7 дугаар сургууль, Буянт сумын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв байгуулж, Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэг, Манхан, Зэрэг сумын цэцэрлэгүүдэд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүд, багш нарт арга зүйн сургалтууд зохион байгууллаа. Мөн аймгийн бүх сургууль, цэцэрлэгүүдэд дэд бүтэц, хүртээмжийн үнэлгээ хийлгэж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах орчин бүрдүүлж ажиллах зөвлөмж хүргүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн сэргээн засах эмч, хүүхдийн сэтгэл зүйч, хөдөлгөөн засалчид цогц үзлэг, оношилгоо, эрт илрүүлэх үзлэг хийж 65 эцэг эх, хүүхэд, 7 нийгмийн ажилтан, 5 сэтгэл зүйч, 21 багш нарт арга зүйн зөвлөгөө өглөө. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах эрх зүйн баримт бичгийн | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмхэтгэл, хараан бэрхшээлтэй хүүхдийн сурах бичиг, сонсдог ном, суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага гэх мэт 10 төрлийн 741 ширхэг ном гарын авлага, сурах бичгийг сургууль, цэцэрлэгүүд хүлээн авч сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. | |
| 45 | 14. АЗДҮАХ-ийн 2.3. 12 | 1. Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөнө | 12 | - | Жаргалант Буянт багийн 6 дугаар цэцэрлэгт 100 хүүдийн өргөтөл барьж эхлэнэ. Тухайн онд санхүүжих төсөв-500,0сая.төг | | Жаргалант сумын IX цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтанд орж тойргийн хамран сургалтын дагуу хүүхдүүдийг уг цэцэрлэгт хамруулахаар шийдвэрлэсэн тул YI цэцэрлэгийн барилгыг барих асуудлыг хойшлуулсан. Харин 2018 онд орон нутгийн төсвийн 2,0 сая төгрөгөөр Жаргалант сумын 6-р цэцэрлэгийн барилгын засварын ажлын зураг, төсвийг "Алтайн газрын хүч"ХХК-иар хийлгүүлэн авч, ажлын төсвийг жил бүр Улсын болон орон нутгийн төсөвт тусгуулахаар санал оруулсан боловч дэмжигдээгүй байна. | 50% |
| 46 | 15. АЗДҮАХ-ийн 2.3. 12 | 1. Жаргалант сумын 5 дугаар цэцэрлэгийн барилгад их засвар хийнэ. | 12 | - | Жаргалант сумын 5 цэцэрлэгийн барилгйн их засвар Тухайн онд санхүүжих төсөв-120,0сая.төг | | 5-р цэцэрлэгийн барилгын засвар санхүүжилтгүй тул хийгдээгүй болно. | 0% |
| 47 | 16. АЗДҮАХ-ийн 2.3. 12 | 1. Зэрэг сумын цэцэрлэгийн барилгад их засвар хийнэ. | 12 | - | Зэрэг сумын цэцэрлэгийн хуучин барилгад их засвархийнэ. Тухайн онд | 205 000 000 | Аймгийн их засварын хөрөнгөөр 175.0 сая төгрөгөөр засвар хийгдсэн. Мөн сургуулийг бүрэн камержуулсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санхүүжих төсөв-177,0сая.төг | | | |
| 48 | 17. АЗДҮАХ-ийн 2.3. 12 | 1. Эрдэнэбүрэн сумын цэцэрлэгийн барилгад их засвар хийнэ. | 12 | - | Эрдэнэбүрэн цэцэрлэгийн барилга их засвар хийнэ. Тухайн онд санхүүжих төсөв-190,0 сая.төг | 2 500 000 2023 онд хэрэгжинэ. Төсөв 105 сая | Их засварын зураг төсвийг 2018 онд орон нутгийн 2,5 сая төгрөгөөр "Алтайн газрын хүч"ХХК хийлгэсэн. 2023 онд Хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварт 105 сая төгрөг батлагдсан байна. | 50% |
| 49 | 18. АЗДҮАХ-ийн 2.3. 12 | 1. Манхан сумын цэцэрлэгийн барилгад их засвар хийнэ. | 12 | - | Манхан сумын цэцэрлэгийн хуучин барилга засвар хийнэ. Тухайн онд санхүүжих төсөв-120,0 сая.төг | 75 000 000 | Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 75,0 сая төгрөгийн санхүүжилтээр Цэцэрлэгийн барилгад засварын ажлыг "Жаргалант хонгор хайрхан"ХХК-иар 4 ангийн засвар, дээвэр, гадна фасад, цахилгааны монтажийг тус тус хийж гүйцэтгүүлэн улсын комисст хүлээн авсан. | 100% |
| 50 | 19. АЗДҮАХ-ийн 2.3. 12 | 1. Ховд сумын цэцэрлэгийн барилгад их засвар хийнэ. | 12 | - | Ховд сумын цэцэрлэгийн засвархийнэ. Тухайн онд санхүүжих төсөв-220,0 сая.төг | | Цэцэрлэгийн барилгын засварын зураг төсөв хийгдсэн, жил бүр их засварын саналд явуулж байгаа боловч батлагдаагүй | 30% |
| 51 | 20. АЗДҮАХ-ийн 2.3.13 | 1. Жаргалант суманд 12 жилийн 8 дугаар бүрэн дунд сургуулийг шинээр барьж, сургуулиудын ачааллыг тэнцвэржүүлж, сургалтын чанарыг ахиулна | 12 | - | Жаргалант сумын 8 дугаар сургуулийн шинэ барилга барьж эхэлнэ. Тухайн онд санхүүжих төсвийн дүн-2000,0 сая.төг | Улсын төсвийн 4801.9 сая төгрөг. | Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2024 онд Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол/-н 4801.9 сая төгрөг батлагдсан. Тус ажлын гүйцэтгэгчээр "Баганат орд" ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 20 хувьтай хэрэгжиж байна. Энэ жил 200,0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Ажил он дамжин хэрэгжинэ. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | 21. АЗДҮАХ-ийн 2.3.14 | 1. Манхан суманд сургуулийн дотуур байр барина. | 12 | - | Манхан сумын сургуулийн дотуур байр барьж эхлэнэ. Тухайн онд санхүүжих төсөв 400,0 сая.төг | Улсын төсвийн 3135,2 сая төгрөг. | Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2024 онд 3135,2 сая төгрөг батлагдсан. Тус ажлын гүйцэтгэгчээр "Ховд шинэ Асар"ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 50 хувьтай хэрэгжиж байна. Энэ жил 800,0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Ажил он дамжин хэрэгжинэ. | 90% |
| 53 | 22. АЗДҮАХ-ийн 2.3.14 | 1. Зэрэг суманд сургуулийн дотуур байр барина. | 12 | - | Зэрэг сумын сургуулийн дотуур байр барьж эхлэнэ. Тухайн онд санхүүжих төсөв-400,0 сая.төг | | Ашиглагч байгууллага нь Сургуулийн дотуур байрны зураг төсвийг "Алтайн газрын хүч"ХХК-иар хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Тус гэрээт ажлын төсөвт өртгийг томосгосон байдлаар гарган улсын төсөвт тусгуулах санал хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна. | 50% |
| 54 | 23. АЗДҮАХ-ийн 2.3.15 | 1. Мөнххайрхан сумын сургуулийн барилгыг өргөтгөнө. | 12 | - | Мөнххайрхан сумын сургуулийн өргөтгөлийн барилгыг ажлыг эхлүүлнэ. | | Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд 160 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөл баригдахаар тусгагдсан барилгын ажлыг эхлүүлсэн. | 90% |
| 55 | 24. АЗДҮАХ-ийн 2.3.15 | 1. Буянт сумын сургуулийн барилгад их засвар хийнэ. | 12 | - | Буянт сургуулийн их засвар хийнэ. Тухайн онд санхүүжих төсөв-355,8сая.төг | | 2018 онд орон нутгийн төсвийн 4,0 сая төгрөгийн хөрөнгөөр сургуулийн барилга, дотуур байрны барилгын зураг төсвийг "Алтайн газрын хүч"ХХК-иар гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн. Жил бүр улсын болон орон нутгийн төсөвт засварын ажлыг суулгуулахаар санал хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй хүлээгдсээр байна. | 70% |
| 56 | 25. АЗДҮАХ-ийн 2.3.15 | 1. Зэрэг сумын сургуулийн барилгад их засвар хийнэ. | 12 | - | Зэрэг сумын сургуулийн барилгад их засвар хийнэ. | 287 | 2020 онд улсын төсвийн 287,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургуулийн барилгад "Зөөлөн тэмүүлэл"ХХК гэрээ байгуулан хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн. | 100% |

| | | | | | | | | |
| 157 | 11. АЗДҮАХ-ийн 3.4.11 | 11. Усалгаатай газар тариалангийн бүс нутагт жимс, жимсгэний тариалалт эрхлэх иргэд аж ахуй нэгжүүдэд газар олгож, тариалалтыг нэмэгдүүлнэ. | 12 сар | - | 100 га | | Аймгийн "Жимс, жимсгэнэ" хөтөлбөрийг боловсруулан 3 дугаар сард газар тариалангийн үйлдвэрлэл, жимс, жимсгэнэ эрхлэгчдийн дунд цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд жимс, жимсгэний тариалалтыг тусгаж, үйл ажиллагааг төлөлөгөөний дагуу хэрэгжүүлж байна. 2022 онд шинээр 90.3 га талбайд жимс жимсгэнэ тариалж 242 тн жимс, жимсгэнэ хураан авсан. Булган сумын хэмжээнд алимны модны үрсэлгээний тариалалт нэмэгдэж монгол улсын хэмжээнд худалдан борлуулт хийгдэж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 5/09 тогтоолоор батлагдсан "Аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үр тарианы усалгаатай тариалангийн зориулалтаар 500 га газрыг олгохоор төлөвлөсөнөөс Булган суманд 50 га, Алтай суманд 300 га газрыг сумын Засаг даргын захирамжаар эзэмшүүлсэн. | 100% |
| 158 | 12. АЗДҮАХ-ийн 3.4.12 | 12. Тарвасны үрийн шинэчлэл хийнэ | 12 сар | - | 350 кг тарвасны орон нутагт нутагшсан сортын үрийг үржүүлнэ. /Буянт-1, Огонёк/ | 1 800 000 төгрөгі | Ховдын тарвас, Булган голын алимыг газарзүйн заалттай болгохоор ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн докторууд, Монголын жимс жимсгэний холбоо, Монголын тариаланч гурил үйлдвэрлэгчдийн холбооны төлөөллөл Ховд аймагт 2 удаа ирж ажилласан ба Ховд аймгийн газар тариалангийн өнөөгийн байдал цаашдын чиг хандлага сэдэвт онол үйлдвэрлэлийн бага хурлыг зохион байгуулсан. Газар зүйн заалт тодорхой орон нутгийн үйлдвэрлэгчдийн мэдлэг, ноу-хауд тулгуурлан, тухайн газар нутгийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон өвөрмөц шинж чанар бүхий бүтээгдэхүүний нэрийг хамгаалах оюуны өмчийн эрх юм. Ховд аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн томоохон байр суурийг эзэлж тариалагддаж буй том жимст алим, нутгийн улаан хальст саримс, тарвас зэргийг газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр судалгаанд суурилсан тодорхойлох, судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулан ажиллаж байна. Эдгээр ажлын хүрээнд тарвас, ягаан хальст саримсын үр үржүүлэх ажил давхар хийгдээд явж байна. Энэ онд тарвасны Астарханский сортын 1,8 сая төгрөгийн 6,5 кг үрийг 80 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр тариаланчдад олгосон. | |
| 159 | 13. АЗДҮАХ-ийн 3.4.12 | 13. Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын үрийг шинэчлэл хийнэ | 12 сар | - | 150 тн үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын үрийг үржүүлж шинэчлэнэ. | 31 900 000 | 2022 оны Хаврын тариалалтад шаардлагатай хүнсний ногооны үрийг ХХААХҮЯ-наас тариаланчдад 80 хувийн хөнгөлөлттэй үнээр 12.2 тн, 22 төрлийн 31.9 сая төгрөгийн үрийг нийлүүлж газар тариалан эрхлэгчдэд үрийн шинэчлэл хийхэд хувь нэмрээ оруулаад байна. | 100% |
| 160 | 14. АЗДҮАХ-ийн 3.4.13 | 14. Газар тариалан эрхлэгчдийг бага оврын тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр үе шаттайгаар хангана. | 12 сар | - | 15-20 ширхэг тоног төхөөрөмжөөр хангах | 389 600 000 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 211,3 сая төгрөгийн үнэ бүхий станц зэргийг тариаланчдад 80.0 хувийн хөнгөлөлттэй хадуур, гар үрлэгч, хүнсний ногоо ухагч, хураагч, нийлэг хальсан хүлэмж, зөөврийн усан сан, төмсний мотоблок, цаг уурын бичил үнээр нийлүүллээ. Германы хамтын ажиллагааны Биологийн олон янз байдлыг хамгаалах “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төслийн 49.8 сая төгрөгийн санхүүжилтээр Манхан, Үенч сумдад тус бүр 1 ширхэг дамартай усалгааны систем, 209.8 сая | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгийн санхүүжилтээр Үенч суманд 3, Мөнхайрхан суманд 1, Булган суманд 5, Дөргөн суманд 3, Жаргалант суманд 8, Чандмань суманд 3, Алтай суманд 5, Цэцэг суманд 5, нийт 8 сумын 31 иргэн, аж ахуйн нэгжид 1 га-гийн бороожуулагч услалтын систем тус тус олголоо. Мөн тус төслийн 130.0 сая төгрөгийн санхүүжилтээр Сум дундын ойн ангид 90 морины хүчтэй чадалтай тракторыг газар хагалагч, сийрүүлэгч, модны нүх ухагч иж бүрдлийн хамт нийлүүлсэн байна. | |
| 161 | 15. АЗДҮАХ-ийн 3.4.14 | 15. Бэлчээрийн доройтлыг бууруулах газар зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж, зохистой ашиглан хамгаалж, нөхөн сэргээх ажлыг олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | 12 сар | - | 100га | | Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулагч хортон царцааны тодотгох судалгаа хийж, тэмцэх ажиллагаа зохион байгуулах хүсэлтийг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсний дагуу Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн нарын хамтарсан судалгааны баг 2022 оны 05 дугаар сарын 30-аас 06 дугаар сарын 03-ны хооронд Цэцэг, Булган, Мөст, Мөнххайрхан, Манхан, Зэрэг, Мянгад, Дуут сумдад явж тандалт судалгаа хийж ажилласан. Судалгааны дүнд Дуут, Мянгад сумын нийт 10000 га талбайд устгал хийхээр болсон боловч устгал хийх зардал байхгүйн улмаас энэ ажил 2 дахь жилдээ хойшлогдоод байна. Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төсөлтэй хамтран 7 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн хийж, 3 сумын төлөвлөгөөг шинээр хийж байна. Аймгийн хэмжээнд бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторнгийн аргаар үнэлэх, бэлчээрийн ургац даац тогтоох, ургамлын судалгааны ажлыг 2022 оны 08 дугаар сард гүйцэтгэж, хүчтэй | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | доройтсон 27 цэг буюу 535600.01 га, маш хүчтэй доройтсон 4 цэг буюу 86034.09 га газрын талаарх мэдээлэл болон Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газраас 2022.11.10-ны өдрийн 1/2120 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг газрын даамлуудад танилцуулж, хүчтэй доройтсон болон маш хүчтэй доройтсон бэлчээрийг 2023 оны төлөвлөгөөнд тусгаж өнжөөх, сэлгэх арга хэмжээ авах зөвлөмж өгч ажилласан. | |
| 162 | 16. АЗДҮАХ-ийн 33.4.15 | 16. Инженерийн хийцтэй бэлчээрийн худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлж ашиглагдахгүй байгаа бэлчээрийн хангамжийг нэмэгдүүлнэ. | 12 сар | - | 6 ширхэг инженерийн хийцтэй худагтай | 528 000 000 төгрөг | Аймгийн хэмжээнд нийт худаг уст цэг 2409 үүнээс инженерийн хийцтэй худаг 407, энгийн уурхайн худаг 1992, усан сан 10 байна. 2022 онд улсын төсвийн 375.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 9 суманд нийт 11 инженерийн хийцтэй худгийг 2023 оны 7 дугаар сард хүлээлгэн өгөх гэрээтэйгээр "Алтайн хар сувд" ХХК, "Эвлэл" ХХК-нуудтай ХХААХҮЯ гэрээ хийн ажиллаж байна. Орон нутгийн төсвөөр 2 суманд нийт 4 худгийг 153.0 сая төгрөгөөр гаргаж хүлээлгэн өгсөн байна. 2022 онд 4 сумын 11 цэгт хайгуул хийлгэх захиалгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. | 100% |
| 163 | 17. АЗДҮАХ-ийн 3.4.16 | 17. Хөдөө аж ахуйн болон Мал эмнэлгийн газрын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна. | 12 сар | - | Барилгын ажлын явц 60 хувьд хүрэх | 1 913,184,223 төгрөг | Хүнс хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын барилгын ажлыг 2021-2022 онд ашиглалтад оруулахаар улсын төсөвт 1 913,184,223 төгрөг тусгагдаж, тендер шалгаруулах ажил 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр болж, “Саруул цамхаг” ХХК шалгарч, барилгын ажил 2022 оны байдлаар  4 давхарын ажил бүрэн хийгдэж барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 164 | 18. АЗДҮАХ-ийн 3.4.17 | 18. Мал эмнэлгийн лабораторийн барилгад их засвар хийж, өргөтгөн Баруун бүсийн мал эмнэлгийн судалгаа шинжилгээний төв байгуулж, лабораторийн оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлэн, шинжээч эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулна | 12 сар | - | Барилгын ажлын явц 60 хувьд хүрэх | | Бүсийн лаборатори болох зорилтын хүрээнд Лабораторийн чанарын болон удирдлагын тогтолцоог сайжруулж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг лаборатори болох зорилгоор Мал эмнэлгийн лабораторийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулан ажиллаж байна. НҮБ-ын ХХААБ-ийн МАЭЗЭН төслийн зүгээс Мал эмнэлгийн лабораторийн барилгын цэвэр, бохир усны системийн бүрэн шинэчлэл хийх, лабораторийн хүйтэн дулааны хэм тохируулах иж бүрэн систем суурилуулахтай холбоотой уг төслийн зохицуулагч, инженер техникийн ажилтнаас бүрдсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж тус ажлын үнэлгээ хийсэн. Одоо ТЭЗҮ хийх шатандаа явагдаж байна. Мал эмнэлгийн оношилгооны чадавхыг нэмэгдүүлэх, шинжээч нарыг чадавхжуулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр: 1.Молекулбиологийн тасгийн үйл ажиллагааг жигдрүүлэх зорилгоор ПГУ-ын дулаан сэлгэх машины эвдрэл гэмтлийг засварлуулж хэвийн үйл ажиллагаанд орсноор Молекулбилогийн шинжилгээний хүчин чадал нэмэгдлээ. 2.Ариун цэврийн магадлан шинжилгээ малын эмийн бодисын үлдэгдэл илрүүлэх шинжилгээний чадавхыг сайжруулах зорилгоор мах, сүү, өндөг, ийлдэс, бөөр, элэг, тэжээлд малын эмийн үлдэгдэл илрүүлэх Comet-8 багаж худалдан авч өмнөх жилүүдэд тус шинжилгээг хийх боломжгүй байсан шинжилгээг хийж хүчин чадлыг нэмэгдүүлээд байна. Шинжээч нарыг чадавхжуулах чиглэлээр: 1.Лабораторийн чанар хангалтыг сайжруулах хүрээнд “Мал эмнэлгийн лабораторийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, хэмжлийн эргэлзээг үнэлэх” сэдэвт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтад АЦМШинжээч С.Энхжаргал, Ийлдэс, шимэгч судлалын шинжээч Д.Хишигт нар хамрагдлаа. 2.Молекулбиологийн шинжилгээний арга зүй эзэмших, дадлагажих зорилгоор Нян судлал, молекулбиологийн шинжээч Г.Бямбадолгор МЭХ болон УМЭАЦТЛ-д тус бүр 14 хоногийн дадлага ажил гүйцэтгэж ПГУ-аар шинжилгээ хийх арга зүй эзэмшлээ. | |
| 165 | 19. АЗДҮАХ-ийн 3.4.18 | 19. “Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлнэ. | 12 сар | - | Жил бүр 12-15 мянган толгой малыг хамруулж, эрүүл аймаг, сум, багийг баталгаажуулах | 462.7 сая төгрөг | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” 225 дугаар тогтоолын дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх дотрын халдварт хордлого (ДХХ), дуут хавдар, цусан халдвар, колибактериоз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцины үнэ, үйлчилгээний хөлсөнд 342,0 сая, халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмж, эм бодис, хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ)-ийн үнэ 107,5 сая, лабораторийн шинжилгээ, тандалт судалгааны зардалд 13,2 сая, нийт 462,7 сая төгрөг батлуулж, аймгийн Засаг даргын 2022 оны А/78 дугаар захирамжаар зардлыг зарцуулах эрхийг Мал эмнэлгийн газрын даргад шилжүүлж, газрын даргын тушаал, шийдвэрээр гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллалаа. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны А/28, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны А/07 дугаар тушаалын дагуу 17 суманд мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг 42 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй гурвалсан гэрээ байгуулж, технологит хугацаанд нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1082.8 мянган толгой мал хамруулснаар нийт 1039,4 мянган толгой мал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамрагдаж, 96,0 хувийн гүйцэтгэлтэйгээр дархлаажуулалтын ажлыг хийж дуусгав. | |
| 166 | 20. АЗДҮАХ-ийн 3.4.19 | 20. Сум бүрт стандартын шаардлага хангасан, байгаль орчинд ээлтэй, орчин үеийн технологи ашигласан мал угаалгын ванн барьж, мал угаалгын ажлыг тогтмолжуулж, чанар, үр дүнг нэмэгдүүлнэ | 12 сар | - | 20% | | Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны “Хяналт шалгалт хийх тухай” А/39 дүгээр тушаалаар 17 сумын Мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн 42 мал эмнэлгийн үйлчилгээний үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд 3 ажлын хэсэг ажиллаж, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (МЭҮН) бүрээр шалган үнэлгээ өгч, стандартын үнэлгээг Мал эмнэлгийн нэгдсэн системд оруулан баталгаажуулав. Мал эмнэлгийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим төлөвлөгөөт ажлуудын гүйцэтгэлийг хангах, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны “Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх тухай” 01 дүгээр нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлж, сумдын МЭҮН-ийн стандарт, мал, амьтны эмийн сангийн стандартын үзлэг шалгалт хийх, МЭТ, үйл ажиллагаа түүний явц, үр дүнг газар дээр нь үзэж шалган үнэлж, дотоод хяналт хийн тасаг, нэгжийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж үүрэг чиглэл өгч ажиллалаа. Ингэснээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулсан болон гэрээт эмч, Мал эмнэлгийн тасгийн эмч, МЭҮН-ийн эмч нарт Мал эмнэлгийн үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журам, заавар, мэдээ судалгаа гаргах, шимэгчтэх, халдварт, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт өвчин болон шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөлт гүйцэтгэл оруулах зэрэг сэдвээр 18 удаагийн танхимын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон цахим сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 150 гаруй албан хаагчдыг хамрууллаа. | |
| 167 | 21. АЗДҮАХ-ийн 3.4.20 | 21. Сумдын мал эмнэлгийн тасаг, нэгж, малын эмч нарын ажиллах орчин нөхцөл, мэргэжил ур чадварыг сайжруулна. | 12 сар | - | 20 хувиар | | Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны “Хяналт шалгалт хийх тухай” А/39 дүгээр тушаалаар 17 сумын Мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн 42 мал эмнэлгийн үйлчилгээний үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд 3 ажлын хэсэг ажиллаж, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (МЭҮН) бүрээр шалган үнэлгээ өгч, стандартын үнэлгээг Мал эмнэлгийн нэгдсэн системд оруулан баталгаажуулав. Мал эмнэлгийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим төлөвлөгөөт ажлуудын гүйцэтгэлийг хангах, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны “Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх тухай” 01 дүгээр нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлж, сумдын МЭҮН-ийн стандарт, мал, амьтны эмийн сангийн стандартын үзлэг шалгалт хийх, МЭТ, үйл ажиллагаа түүний явц, үр дүнг газар дээр нь үзэж шалган үнэлж, дотоод хяналт хийн тасаг, нэгжийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж үүрэг чиглэл өгч ажиллалаа. Ингэснээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулсан болон гэрээт эмч, Мал эмнэлгийн тасгийн эмч, МЭҮН-ийн эмч нарт Мал эмнэлгийн үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журам, заавар, мэдээ судалгаа гаргах, шимэгчтэх, халдварт, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт өвчин болон шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөлт гүйцэтгэл | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулах зэрэг сэдвээр 18 удаагийн танхимын болон цахим сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 150 гаруй албан хаагчдыг хамруулсан. | |
| 168 | 22. АЗДҮАХ-ийн 3.4.21 | 22. Мал эмнэлгийн нэгдсэн цахим системийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлнэ. | 12 сар | - | 20% | | Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан "Мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт хийх" 01 дүгээр нэгдсэн удирдамжийн дагуу Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны "Хяналт шалгалт хийх тухай" А/39 дүгээр тушаалаар 17 сумын Мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн 42 мал эмнэлгийн үйлчилгээний үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалт хийх нэгдсэн удирдамж баталж, энэ хүрээнд 3 ажлын хэсэг ажиллаж, МЭТ-ийн дотоод ажлыг үнэлж дүгнэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, МЭҮН, малын эмийн сангийн стандартын хэрэгжилтийг үнэлгээний хуудсаар үнэлэх, Мал эмнэлгийн нэгдсэн системийн хэрэгжилтийг хянах, төлөвлөлт, гүйцэтгэлийг бүрэн оруулан ажиллав. | 100% |
| 169 | 23. АЗДҮАХ-ийн 3.4.22 | 23. Халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж, тандан шинжилгээг цаг тухай бүрт хийж гоц халдварт өвчингүй бүс нутгийн статусыг хадгална. | 12 сар | - | 3.257.0 | 528 000 000 | Тайлант 2022 онд Чандмань, Ховд, Мянгад, Дөргөн, Эрдэнэбүрэн, Цэцэг сумдад мал амьтны гоц халдварт шүлхий өвчин гарч, уг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор баталсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам", Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/187 дугаар тушаал, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоол зэрэг холбогдох эрх зүйн баримт бичиг, заавар журмын дагуу зохион байгуулан дээрх 6 сумын 10 голомтод шүлхий өвчнөөр 42 тэмээ, 231 үхэр, 2273 хонь, 2972 ямаа, нийт 5518 толгой мал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өвчилж, тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж ажилласны үр дүнд шүлхий өвчний гаралт тархалтыг 100 хувь таслан зогсоож шүлхий өвчний голомтыг тайван байдалд шилжүүлээд байна. Энэ онд мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг МЭЕГ-ын даргын А/49, А/77 дугаар тушаалаар 4 удаа зохион байгуулан 17 сумын давхардсан тоогоор 10021 өрхийн 429,857 үхэр, 62,325 хонь, 76850 ямаа, 563 гахай нийт 569,595 толгой мал, амьтан вакцинжуулсан байна. Бог малын мялзан өвчний шинж тэмдэгт суурилсан тандалтын асуумж судалгааг 17 сумын 427 малчин өрхөөс авч хүргүүлээд байна. 1.Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний халдварын түвшин тогтоох, “Мялзан”, “Үхрийн өвчний арьс товруутах”, “Хонь, ямааны цэцэг” өвчний эрт илрүүлэх тандах шинжилгээг Ховд аймгийн Алтай, Булган, Үенч, Мөнххайрхан, Мянгад, Чандмань, Ховд, Буянт /8 сумын 20 баг/ сумдын 30 малчин өрхөөс 146 хурга, 214 ишиг, 120 тугалаас нийт 480 ширхэг дээж бэлтгэн дээрх өвчний эсрэг биет илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээг Ховд аймгийн Мал эмнэлгийн лабораторид тандалт тус бүрээр 100% хийж гүйцэтгэв. Шинжилгээгээр “Шүлхий” өвчний байгалийн халдвар 23.3%-д, “Мялзан” өвчний эсрэг биет 2.5%-д илэрч, “Үхрийн арьс товруутах”, “Хонь ямааны цэцэг” өвчнөөр тайван болохыг баталгаажуулаа. | |
| 170 | 24. АЗДҮАХ- | 24. Орон нутгийн түүхий эд, инновацид суурилсан шинэ | 12 сар | - | Аймгийн ИТХТэргүүлэгчдээс баталсан журмын дагуу жил | 15 000 000 төгрөг | “Цайны зам өв соёлын III наадам", Цагаан сарын баярыг тохиолдуулан “Хаврын өнгө 2022” өргөтгөсөн худалдааг 2022.01.20-28-ны хооронд Эвийн хүч худалдааны төвд зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ийн 3.4.23 | бүтээгдэхүүн брэнд бий болгох санал санаачлага, төсөл хөтөлбөрийг дэмжинэ | | | бүр 3 бүтээгдэхүүнийг шалгаруулж 3,0 сая төгрөгөөр шагнаж урамшуулна. | | өргөтгөсөн худалдаанд Жаргалант, Буянт, Зэрэг, Үенч сумдаас 45 иргэн, аж ахуйн нэгж, нийт 123 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 60.840.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна. Мөн “Цайны зам өв соёлын III наадам"-ын хүрээнд “Ховдод үйлдвэрлэв соёлын бүтээлч үйлдвэрлэл”-ийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд 17 сумын 40 гаруй аж ахуйн нэгж, 30 хувиараа хөдөлмөр эрхлэгчид оролцон 100 нэр төрлийн бүтээгдэхүүний худалдаа хийж, 120.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлууллаа. 2022 оны 09 дүгээр сард “Тарвас эвент” арга хэмжээг зохион байгуулж, тус арга хэмжээнд 100 гаруй тариаланч болон аж ахуйн нэгж оролцон тарвасаар ундаа, шүүс, цэлцгэнүүр, чихэр, зайрмаг торт зэрэг 20-28 нэр төрлийн бүтээгдэхүүн хийж олон нийтэд сонирхуулав. Мөн “Хамгийн том тарвас”, ”Тарвасаар хамгийн олон бүтээгдэхүүн” хийх, ”Тарвасан дээрх сийлбэр” зэрэг 3 төрлөөр шилдэг бүтээл шалгаруулж", 3,0 сая төгрөгөөр шагнаж урамшуулав. | |
| 171 | 1. АЗДҮАХ-ийн 3.5.1 | 1. Чулуун соёлын дижитал музей бүхий нүүдэлчдийн соёлын судалгаа, мэдээллийн төв байгуулна. Сангийн хэрэм-аялал жуулчлалын гудамж байгуулна. “Гурван Сэнхэр төвтэй таван од” | 12 сар | - | Төсөл эхлүүлэх | | Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Тогтвортой аялал жуулчлал-2” төслийн ТЭЗҮ боловсруулагдаж дууссан. Орон нутгаас шаардагдах холбогдох мэдээллүүдийг хүргүүлсэн болно. Одоогоор Улсын их хурлын байнгын хороон дээр хэлэлцэгдэж байна. | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | аялал жуулчлалын хөтөлбөрийн аяллын маршрутын дагуу отоглох цэг, үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Аймгийн аялал жуулчлалын маршрутад орсон байгалийн үзэсгэлэнт газар, өв соёл, түүхийн дурсгалт газруудын чиглэлд автозам, гүүр барих Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор жижиг төслүүдийг хэрэгжүүлэх | | | | | | |
| 172 | 2. АЗДҮАХ-ийн 3.5.2 | 2. “Цайны зам өв соёлын наадам” зохион байгуулна. | 12 сар | - | Цайны зам өв соёлын наадмыг зохион байгуулсан байх. | Орон нутгийн төсөв 59,0 сая төгрөг /“Цайны зам” өв соёлын III наадам/ | Олон угсаатны соёлын биет болон биет бус өвийг өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх, цайны соёлыг сурталчлах, өв соёлоороо дамжуулан орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Цайны зам-2022 өв соёлын III дугаар наадам"-ыг зохион байгууллаа. Тус наадамд Ховд аймгийн 17 сумын соёлын өвлөн уламжлагчид, Хөвсгөл, аймгийн соёлын өв | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тээгчид, аймгийн ЕБС-ийн сурагчид гээд 5000 гаруй хүн угсаатны соёл уламжлалаа илтгэсэн үндэсний хувцсаараа гоён баярын жагсаалд оролцож, урлагийн үзүүлбэр үзүүллээ. Манхан сумаас тэмээн жингийн цуваа хөтлөн нүүдэллэж ирсэн жинчид аймгийн төв талбайд ирж, тэмээнд ачаа тэгнэн нүүдэллэх эртний соёл уламжлал, ёс заншлын нэгээхэн хэсгийг олон нийтэд сурталчлан харууллаа. Наадмын хүрээнд Монгол туургатны Тууль, Цуур, Уран нугаралтын улсын уралдаан, Морин хуур, Бий биелгээний аймгийн уралдаан, “Угсаатны цай чанах ёслол”, Язгуур урлагийн тоглолт”, “Цайны зам” эрдэм шинжилгээний III бага хурал зэрэг арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. | |
| 173 | 3. АЗДҮАХ-ийн 3.5.3 | 3. “Мөнгөлөг шагшуурга” цас мөсний баярыг зохион байгуулна. | 12 сар | - | “Мөнгөлөг шагшуурга” цас мөсний баярыг зохион байгуулсан байх. | | "Мөнгөлөг шагшуурга" цас мөсний баярын эвент арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын эхний 7 хоногт зохион байгуулахаар ажлын хэсэг хурлаа хийж ерөнхий төлөвлөгөө гаргасан бөгөөд энэхүү арга хэмжээг улсын чанартай эвент арга хэмжээ болгуулах саналаа зохих газарт хүргүүлсэн. Соёл урлагийн салбарын хувьд энэхүү арга хэмжээнд олон угсаатны өв соёлыг харуулсан урлаг, соёлын арга хэмжээ болон "Өв соёлоороо гоёцгооё" угсаатны хувцасны уралдааныг зохион байгуулахаар удирдамжаа төсөл хэлбэрээр гаргасан. Мөн “Мөнгөлөг шагшуурга-2023” фестивалын үеэр  Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд Ховд аймагт 2023 оны 1-р сарын 19-22-ны өдрүүдэд “Invest Khovd” хөрөнгө оруулалтын форумыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 174 | 4. АЗДҮАХ-ийн 3.5.4 | 4. Булган суманд хилийн аялал жуулчлалын баяр тэмдэглэх | 12 сар | - | Хил дамнасан аялал жуулчлалын арга хэмжээг хэрэгжүүлэх | | 2022 оны 7 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Булган суманд хилийн аяллын маршрут гаргах ажлыг SPACES төсөлтэй хамтран зохион байгууллаа. Хилийн бүсээр аялах 1258км-ийн маршрут гаргасан. | 70% |
| 175 | 5. АЗДҮАХ-ийн 3.5.4 | 5. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах ажлыг цахим сүлжээгээр дамжуулан дотоодын гадаадын жуулчдад мэдээлэл түгээх | 12 сар | - | Бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах. | | travelkhovd.com цахим хуудас, “Ховд аймгийн аялал жуулчлал” фэйж хуудсаар аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, зорих газруудын мэдээллийг сурталчилж байна. 65 мэдээлэл оруулсан.Цайны зам өв соёлын наадам”, “Тэмээн жин”, “Монгол нүүдэл”-ийн сурталчилгааны нэвтрүүлгүүдийг хийж бэлтгэн, техникийн дэвшил ашиглан олон улсын болон дотоодын цахим сүлжээнд байршуулан сурталчилж байна. Мөн “Гурван Сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын хөтөлбөрийн 5 маршрутын I, II, III чиглэлийн маршрутын дагуу монголын томоохон туроператор компаниудын шинэ бүтээгдэхүүн бий болгох аяллын нэвтрүүлэг хийгдсэн. | 90% |
| 176 | 6. АЗДҮАХ-ийн 3.5.4 | 6. “ITM” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр оролцож аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний сурталчлах | 12 сар | - | Уг үзэсгэлэнд оролцож бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилсан байх. | | 2022 оны 10-р сарын 28-30-ны өдрүүдэд “ITM-2022” аялал жуулчлалын үзэсгэлэн аймгийн Аялал жуулчлалын холбоотой хамтран салбарын сурталчилгааг хийлээ. Холбооны төлөөлөл 5 аж ахуйн нэгж хамрагдаж сурталчилгаа хийсэн. | 100% |
| 177 | 7. АЗДҮАХ-ийн 3.5.4 | 7. “Улаанбаатар травэл экспо” дотоодын аялал жуулчлалын | 12 сар | - | Уг үзэсгэлэнд оролцож бүтээгдэхүүн үйлчилгээгээ | | 5 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд БОАЖЯ, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо хамтран аялал жуулчлалын боловсролыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын сөрөг нөлөөллийг бууруулах, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үзэсгэлэнд жил бүр оролцож аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний сурталчлах | | | сурталчилсан байх. | | салбарын бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой “Төрсөн нутгаараа аялцгаая” уриатай “Улаанбаатар травэл экспо” аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцлоо. Үзэсгэлэнд аймгийн ЗДТГ, Хөгжимт драмын театр, “Цаст Алтайн угсаатан” аялал жуулчлалын холбоо, 8 аж ахуйн нэгж оролцлоо. | |
| 178 | 8. АЗДҮАХ-ийн 3.5.4 | 8. “Гурван Сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын хөтөлбөрт тусгагдсан маршрут, бүтээгдэхүүнийг сурталчилсан богино хэмжээний сурталчилгааны нэвтрүүлэг, кино хийх | 12 сар | - | Хөтөлбөрийн тусгагдсан маршрут, бүтээгдэхүүнийг сурталчилсан богино хэмжээний сурталчилгааны нэвтрүүлэг, кино хийгдсэн байх | | Цайны зам өв соёлын наадам”, “Тэмээн жин”, “Монгол нүүдэл”-ийн сурталчилгааны нэвтрүүлгүүдийг хийж, сурталчилан ажилласан. | 100% |
| 179 | 1. АЗДҮАХ-ийн 3.6.1 | 1. Ховд хотын өсөн нэмэгдэж буй цахилгааны хэрэглээг тооцож, тоолуурын систем нэвтрүүлнэ./ айл өрхөд / | 12 сар | - | 6540 | | Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, ухаалаг тоолуур суурилуулах /Ховд, Жаргалант сум/-н барилга угсралтын ажлыг “Залаа Алтай” ХХК-н 2000 ширхэг ухаалаг тоолуур суурилуулах ажлыг хийж гүйцэтгээд явж байна. ажлын гүйцэтгэл 90 хувьтай . гэр хорооллын 2500 ширхэг тоолуур, орон сууцны 2000 ширхэг тоолуур | 100% |
| 180 | 2. АЗДҮАХ-ийн 3.6.1 | 2. Цахилгааны хэрэглээг тооцож, | 12 сар | - | 3333 | 730 сая төгрөг | Агаар орчны бохирдлыг бууруулах сангийн хөрөнгө оруулалтаар орон сууцны айл өрх болон | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоолуурын систем нэвтрүүлнэ./ албан байгуулага/ | | | | | албан байгууллагад нийт 2000 ширхэг тоолуур суурилуулсан байна. | |
| 181 | 3. АЗДҮАХ-ийн 3.6.1 | 3. Ховд хотын өсөн нэмэгдэж буй дулааны хэрэглээг тооцож, тоолуурын систем нэвтрүүлнэ. | 12 сар | - | 76 | 40 000 000 | Орон нутгийн 40 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Сайрын хороо" ХХК- ний аймгийн төвийн болон сумын цэцэрлэгүүдэд нийт 12 ширхэг ухаалаг дулааны тоолуур суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувь | 100% |
| 182 | 4. АЗДҮАХ-ийн 3.6.2 | 4. Сумдын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл хийнэ. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 30% | 1 тэрбум 300 сая төгрөг | Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, ухаалаг тоолуур суурилуулах /Ховд, Жаргалант сум/-ын барилга угсралтын ажлыг “Залаа Алтай” ХХК, Сумдын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл шинэчлэлийн 695,000,000 сая төгрөгийн санхүүжилттэй ажлыг “Ноён сайхан” ХХК, цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, өргөтгөл /Ховд Манхан сум/-ын ажлыг "Коон Арч" ХХК тус тус хийж гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай. | 100% |
| 183 | 5. АЗДҮАХ-ийн 3.6.2 | 5. Сумдын цахилгаан дамжуулах агаарын шугам өргөтгөл шинэчлэлийг үргэлжлүүлэн хийнэ. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 30 % | | Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, ухаалаг тоолуур суурилуулах /Ховд, Жаргалант сум/-ын барилга угсралтын ажлыг “Залаа Алтай” ХХК, Сумдын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл шинэчлэлийн 695,000,000 сая төгрөгийн санхүүжилттэй ажлыг “Ноён сайхан” ХХК, цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, өргөтгөл /Ховд Манхан сум/- | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ын ажлыг "Коон Арч" ХХК тус тус хийж гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай. | |
| 184 | 6. АЗДҮАХ-ийн 3.6.3 | 6. Ховд хотын дулааны эх үүсвэрийг өргөтгөх, шугам сүлжээг шинэчлэх, засварлах, байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлж, шугам сүлжээний насжилтыг уртасгана. | 12 сар | - | ддт 16 ширхэг | 574 000 000 | Ховд дулааны станцын аваарын нөөц бүрдүүлэлт хангах зорилгоор 172,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “МЭЗ” ХХК хийж гүйцэтгэсэн. - Жаргалант сумын Бугат багт орон сууцны шинэ хорооллыг байгуулах зорилгоор ДДТөв-9 шинээр барих-300,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Мөнхбаян Эрдэнэ”ХХК хийж гүйцэтгэсэн. - ДДТөв-13-н барилгын ажлыг 102 сая төгрөгөөр "Очир буян өргөө" ХХК- н хийж гүйцэтгэсэн. Тус дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд шаардлагатай 90 сая төгрөгийг Засаг даргын нөөц сангаас төсөвлөн шийдвэрлэсэн. | 100% |
| 185 | 7. АЗДҮАХ-ийн 3.6.4 | 7. Ховд хотын орон сууцнуудын дулаан хангамжийг сайжруулж, байнгын хэрэглээний халуун устай болгоно. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 100% | | Ховд хотын орон сууцуудын дулаан хангамжийг сайжруулж, байнгын хэрэглээний халуун устай болгох ажлын хүрээнд нийтийн орон сууцанд дулааны улиралд хэрэглээний халуун усаар хангах ажлын хүрээнд “Ховд дулаан станц” ТӨХК- н өөрийн хэрэглэгчийг байнгын хэрэглээний халуун усаар хангаж ажиллалаа. Жаргалант сумын нийтийн орон сууцны халаалт дулааныг сайжруулах ажлын хүрээнд “Оюу мандал” ХХК-ийн 36 айлын орон сууцны гадна дулааны шугам, “Шим-Ус” ОНӨААТҮГ, Мэргэжлийн хяналтын газрын 36 айлын орон сууцны хэрэглээний халуун ус, цэвэр усны шугам, Тулгын 30 айлын орон сууцны дулааны узель шинэчлэх, 3-р 60 айлын орон сууцны гадна дулааны шугам, усжуулахын 24 айлын орон сууцны узель шинэчлэх, “Алтайн буйлааст” ХХК-ийн 24 айлын орон сууцны дулааны шугамын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | засварын ажлыг үе шаттайгаар хийж ашиглалтад оруулаад байна. | |
| 186 | 8. АЗДҮАХ-ийн 3.6.5 | 8. Мянгад суманд 10 Мвт-ын нарны цахилгаан эрчим хүчний станц байгуулна. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 30% | Дэлхийн банкны 39,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт | Мянгад суманд 10 Мвт-ын нарны цахилгаан эрчим хүчний станц байгуулах ажил нь дэлхийн банкны 39,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Смарт плас”ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгч, 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр албан ёсоор нээлтээ хийлээ. Тус станц ашиглалтад орсноор эрчим хүчний дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, жилд 17-22 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх бөгөөд баруун бүсийн нийт хэрэглээний 10 орчим хувийг хангах боломжтой юм. Мөн ОХУ-аас худалдаж авах эрчим хүчний зардлыг жилд дунджаар 3.4 тэрбум төгрөгөөр хэмнэх боломж бүрдэж байна. | 100% |
| 187 | 1. АЗДҮАХ-ийн 3.7.1 | 1. Нутгийн зам хөтөлбөрийн хүрээнд Чандмань, Цэцэг, Ховд, Эрдэнэбүрэн, Дөргөн сумын төвүүдийг хатуу хучилттай автозамаар холбоно. | 12 сар | - | Төслийн явц 50% | Улсын төсөв 43,597.0 сая төгрөг Улсын төсөв 1,100.0 сая төгрөг Улсын төсөв 1,500.0 сая төгрөг Улсын төсөв 500.0 сая төгрөг Замын сан 30.0 сая төгрөг Замын сан 80.0 сая төгрөг | Монгол Улсын төсвийн 43,597.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 56.9 км /Ховд/”, Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Ховд, Алтай сум/ төслүүд нь 2022 оны батлагдсан төсвийн дагуу тус тус амжилттай хэрэгжиж байна. Мөн улсын төсвийн 1,500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Чоно харайхын гүүр /Ховд, Дөргөн сум/” ажлын хүрээнд баригдсан төмөр бетон 37 метр гүүрийг, 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Авто замын засвар, шинэчлэл /Ховд, Чандмань сум/” ажлыг ашиглалтад оруулав. Аймгийн Замын сангийн 30,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Зам засвар /Ховд сум, Баянбулаг баг/” ажлын хүрээнд зуслангийн ердийн хөрсөн зам засвар, 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Гүүр барих | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Замын сан 100.0 сая төгрөг | /Буянт сум. Цагаан бургас баг, Захын гуу, Зэгэстээн гол" ажлын хүрээнд голын хоёр гармыг тус тус хийж ашиглалтад оруулав. Мөн тус сангийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Хөшөөтийн уурхайг холбох авто замын зураг төсөв" ажлын хүрээнд нарийвчилсан зураг төслийг боловсруулан Цэцэг сумын хатуу хучилттай авто замаар холбох ажлын бэлтгэл хангагдав. | |
| 188 | 2. АЗДҮАХ-ийн 3.7.2 | 2. Жаргалант сумын Рашаант, Бугат, Хайрхан, Тахилт, Бичигт, Баатархайрхан багийн автозамыг хэсэгчлэн сайжруулж, хатуу хучилттай болгоно. | 12 сар | - | Төслийн явц 50% | -Замын сангийн 80,0 сая төгрөг - Орон нутгийн 20,0 сая төгрөг - Орон нутгийн 275,0 сая төгрөг - Замын сангийн 60,0 сая төгрөг - Улсын төсвийн 913.0 сая төгрөг | Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар "Авто замын засвар нөхөөс" ажлын хүрээнд Ховд хотын авто замын хөдөлгөөний идэвхжил ихтэй байршлуудад эвдрэл нөхөөс үүссэн 585 мкв хэсгийг асфальтбетоноор нөхөж, ан цав үүссэн 1500 метр урт хэсгийг битумээр гагнах засварыг Ховд АЗЗА ТӨХК-тай гэрээлэн хийж гүйцэтгэв. Авто замыг хэсэгчлэн сайжруулах ажлын хүрээнд Ховд хотын төв авто замын засвар шинэчлэлийн техникийн зургийг "Монголиан нэйшнл хайвэй" ХХК-аар гүйцэтгүүлэв. Ховд хотын авто замыг үе шаттайгаар сайжруулахын тулд Улсын бүртгэлийн хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газар, Бугат багийн цэцэрлэг баригдаж буй шинэ суурьшлын бүсийн авто замын зураг төсөл боловсруулах Ажлын даалгавар, трассыг батлан нарийвчилсан зураг төсвийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэж байна. Замын сангийн 60,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Наран багийн 16-р цэцэрлэг хүртэл хатуу хучилттай авто зам тавих ажлыг ашиглалтад оруулав. Улсын төсвийн 913.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Ховд, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Жаргалант сум, Баатархайрхан, Бичиг баг/" төсөл өргө хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллав. | |
| 189 | 3. АЗДҮАХ-ийн 3.7.3 | 3. Авто замын даацын хяналтыг тогтмолжуулна. | 12 | - | Төслийн явц 100% | 7.3 сая төгрөг | Ховд аймгийн Цагдаагийн газрын Замын Цагдаагийн тасгаас аймгийн нутаг дэвсгэрт 4 цэгт авто замын даацийн хяналтыг тогтмол хийж байна. ҮҮний үр дүнд энэ оны 10 дугаар сарын байдлаар даац хэтрүүлсэн 142 зөрчлийг илрүүлж 7.3 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. | 100% |
| 190 | 4. АЗДҮАХ-ийн 3.7.4 | 4. Ховд-Улаангом хотыг 163.3 км хатуу хучилттай авто замаар холбох төслийг хэрэгжүүлнэ. | 12 сар | - | Төслийн явц 50% | Азийн Хөгжлийн банк | Монгол Улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Улаангом Ховдыг холбох 163,3 километрийн хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлэх зорилгоор Азийн Хөгжлийн банк болон Монгол Улсын Засгийн газар, Зам тээврийн яамны хамтарсан ажлын хэсэг Ховд аймагт хоёр удаагийн уулзалтыг хийж ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлсэн ба ингэхдээ тус замын трассын дагуу судалгааг гарган ажиллав. Тус ажлын хүрээнд шаардлагатай трасс дайран өнгөрөх сумдын судалгаа, хүн амын судалгаа, хүнс хөдөө аж ахуйн тээврийн судалгаа, аймгийн замын сангийн зарцуулалтын мэдээлэл мөн хэрэгжиж буй томоохон төсөл арга хэмжээний судалгааг гарган ажлын хэсэгт хүргүүлж, аймгийн зүгээс ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллав. | 50% |
| 191 | 5. АЗДҮАХ-ийн 3.7.5 | 5. Нисэх буудлыг Олон улсын 4С ангилалд оруулах хөрөнгө оруулалт, өргөтгөл шинэчлэл хийнэ. | 12 сар | - | Төслийн явц 50% | Орон нутгийн хөгжлийн сан 100,0 сая төгрөг | Ховд нисэх буудлыг шинэчлэх ажлын хүрээн 4С ангиллын олон улсын зэрэглэлтэй нисэх буудлын Зураг төсвийг хийж гүйцэтгэсэн ба тус зураг төсвийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын саналд Сангийн яаманд хүргүүлэн ажиллав. Мөн тус төсөлтэй холбоотой дэд бүтэц. эдийн засаг, аймагт | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжиж буй төслүүдийн мэдээллийг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлэн ажиллав. Аймгийн хэмжээнд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх, орон нутгийн нислэгийн чиглэлийн тоог нэмэх зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чандмань суманд бага оврын агаарын хөлөг хөөрч буух талбайг хийж гүйцэтгэв. | |
| 192 | 6. АЗДҮАХ-ийн 3.7.6 | 6. Говь-Алтай-Ховд-Баян-Өлгий чиглэлийн авто замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээний “Ховд” цогцолбор байгуулна. | 12 сар | - | Төслийн явц 50% | Орон нутгийн хөгжлийн сан 50,0 сая төгрөг Улсын төсвийн хөрөнгө оруулалт 760,0 сая төгрөг | Алтай - Ховд – Өлгий чиглэлийн авто зам, Ховд – Булган- Хилийн боомт чиглэлийн авто замын огтлолцох Манханы гурван замын уулзварт Аялал жуулчлалыг хөгжүүлэх, дамжин өнгөрөх жуулчдад мэдээллийг дэлгэрэнгүй хүргэх зорилгоор цахим мэдээллийн нэгдсэн төвийг байгуулахаар зураг төсвийг боловсруулж, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хоёр авто машины зогсоолыг барин ашиглалтад оруулав. Мөн олон улсын авто замыг түшиглэн Гурван Сэнхэрийн агуйг аялал жуулчлалын төв болгох зорилтыг тавин улсын төсвийн 760,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цахилгаан дамжуулах агаарын шугамыг тавьж дэд бүтцийн нэг хэсгийг сайжруулав. | 100% |
| 193 | 7. АЗДҮАХ-ийн 3.7.7 | 7. Ховд голын Цагаанбулангийн модон гүүрийг шинэчилнэ. | 12 сар | - | Төслийн явц 100% | | Модон гүүрийг шинэчлэхэд шаардлагатай тоон судалгаа гарган, 2023 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. | 30% |
| 194 | 1. АЗДҮАХ-ийн 3.8.1. | 1. Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 100% | 153.9 төгрөг | Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын санхүүжилтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 10/06 дугаар аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 195 | 2. АЗДҮАХ-ийн 3.8.1. | 2. “Стандарттай Ховд” хөтөлбөрийн хүрээнд шинээр баригдах орон сууц, барилга байгууламжуудад стандартын шаардлагыг мөрдүүлж, байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссын үйл ажиллагааг ил тод болгоно. | 12 | - | Ажлын гүйцэтгэл 70% | | Улсын комиссын гишүүдийг Засгийн газрын 2021 оны 212-р тогтоолд заасан бүрэлдэхүүний дагуу аймгийн Засаг даргын захирамжаар томилж ажиллаж байна.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээг хүлээн авахдаа Засгийн газрын 212 дугаар тогтоолоор барилга байгууламжийн ажлыг хүлээн авахдаа эхний ээлжинд зураг төсөл зохиогчийн дүгнэлт, захиалагчийн дүгнэлтийг үндэслэн улсын комиссыг томилон ажиллуулж байна. Харин комиссын үйл ажиллагааг газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас тухай бүрт бичлэг болгон гаргаж хэвлэл мэдээлэл болон https://www.facebook.com/khovdaimaggazriinkhariltsaa цахим хаягаар олон нийтэд ил тод хүргэн ажиллаж байна. Нийт 140 төсөл арга хэмжээг ил тод, нээлттэй байршуулсан байна.Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 25 аж ахуйн нэгжийн 638 айлын орон сууц баригдаж байгаа бөгөөд 9 аж ахуйн нэгжийн 229 айлын орон сууц байнгын ашиглалтад орж гадна явган зам талбай, гадна авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай зэргийг норм, дүрмийн дагуу хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажилласан. | 100% |
| 196 | 3. АЗДҮАХ-ийн 3.8.2 | 3. “Стандарттай Ховд” хөтөлбөрийн хүрээнд /Гадна зам талбай/ | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 70% | -Замын сангийн 80,0 сая төгрөг -Орон нутгийн 20,0 | Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар “Авто замын засвар нөхөөс” ажлын хүрээнд Ховд хотын авто замын хөдөлгөөний идэвхжил ихтэй байршлуудад эвдрэл нөхөөс үүссэн 585 мкв хэсгийг асфальтбетоноор нөхөж, ан цав үүссэн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сая төгрөг - Орон нутгийн 275,0 сая төгрөг - Замын сангийн 60,0 сая төгрөг - Улсын төсвийн 913.0 сая төгрөг | 1500 метр урт хэсгийг битумээр гагнах засварыг Ховд АЗЗА ТӨХК-тай гэрээлэн хийж гүйцэтгэв. Авто замыг хэсэгчлэн сайжруулах ажлын хүрээнд Ховд хотын төв авто замын засвар шинэчлэлийн техникийн зургийг “Монголиан нэйшнл хайвэй” ХХК-аар гүйцэтгүүлэв. Ховд хотын авто замыг үе шаттайгаар сайжруулахын тулд Улсын бүртгэлийн хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газар, Бугат багийн цэцэрлэг баригдаж буй шинэ суурьшлын бүсийн авто замын нарийвчилсан зураг төсвийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэж байна. Замын сангийн 60,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Наран багийн 16-р цэцэрлэг хүртэл хатуу хучилттай авто зам тавих ажлыг ашиглалтад оруулав. Улсын төсвийн 913.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичиг баг/" төсөл өргө хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллав. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 25 аж ахуйн нэгжийн 638 айлын орон сууц баригдаж байгаа бөгөөд 9 аж ахуйн нэгжийн 229 айлын орон сууц байнгын ашиглалтад орж гадна явган зам талбайг норм, дүрмийн дагуу хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажилласан. Засгийн газрын 212 дугаар тогтоолоор барилга байгууламжийн ажлыг хүлээн авахдаа эхний ээлжинд зураг төсөл зохиогчийн дүгнэлт, захиалагчийн дүгнэлтийг үндэслэн улсын комиссыг томилон ажиллуулж байна. Харин комиссын үйл ажиллагааг газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас тухай бүрт бичлэг болгон гаргаж хэвлэл мэдээлэл болон https://www.facebook.com/khovdaimaggazriinkharilt | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | saa цахим хаягаар олон нийтэд ил тод хүргэн ажиллаж байна. Нийт 140 төсөл арга хэмжээг ил тод, нээлттэй байршуулсан байна. | |
| 197 | 4. АЗДҮАХ-ийн 3.8.2 | 4. “Стандарттай Ховд” хөтөлбөрийн хүрээнд /хогийн цэг/ | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 70% | 125 сая төгрөг | Монгол улсын Засгийн газрын бодлого, зорилт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зарласан “Хоггүй цэвэрхэн Монгол” аян, Хог хаягдлын тухай хууль, Ховд аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тус тус эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 158 дугаар тогтоолоор “Ховд аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр”-ийг 5 зорилтыг хэрэгжүүлэх 23 зорилттойгоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүний хүрээнд аймгийн Засаг даргын А/72 дугаар захирамжаар хөдөөгийн 16 сум болон Ховд хотын хэмжээнд бүх нийтийг хамарсан их цэвэрлэгээг зохион байгуулж нийт 5,407 тн орчим хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэн отволдох болон ландфиллын аргаар булж устгаад байна.Ховд аймаг нь 2022 оны 11 сарын байдлаар 18,407 мянган тонн хог хаягдлыг нийтийн эзэмшлийн гудамж талбай, айл өрхийн ахуйн хог хаягдлаас цуглуулан тээвэрлэж төвлөрсөн хогийн цэгт хүргэж сумдын хэмжээнд хог хаягдлыг устгах, цуглуулах, тээвэрлэхэд 92,910,800 төгрөгийг зарцуулсан байна Ховд аймгийн эрүүлийн мэндийн газруудаас аюултай хог хаягдал 17 тн гарч ариутгал халдваргүйжүүлэлт хийж, төвлөрсөн хогийн цэгт хүргэн устгаж байна. Баруун бүсийн оношилгоо эмчилгээний нэгдсэн төв эмнэлэгээс 11 дүгээр сарын байдлаар 27391 тн хог хаягдал гарч төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажиллаж байна. Хог | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаягдлын менежментийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 онд Чандмань сумын төвлөрсөн хогийн цэгийн 25 га талбайд хур хог хаягдлыг дарж булшлах ажлын 75 сая төгрөгний тендер зарлагдаж, “Бэйст буйдан хаус” ХХК шалгарч Чандмань сумын сумын төвлөрсөн хогийн цэгийн хур хог хаягдлыг устгах, булшлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Ховд аймгийн “Шинэ Ховд Жаргалант” ТҮК ОНАҮААТҮГ байгаль хамгаалах сангийн улирал бүр 50 сая төгрөгний хөрөнгөөр 2022 онд Жаргалант сумын төвлөрсөн хогийн цэгт ландфилл хийх, зам гаргаж булшлах ажлыг зохион байгуулж ажиллав. | |
| 198 | 5. АЗДҮАХ-ийн 3.8.2 | 5. “Стандарттай Ховд” хөтөлбөрийн хүрээнд /авто зогсоол, хүүхдийн тоглоомын талбай/ | 12 | - | Ажлын гүйцэтгэл 70% | | Алтай - Ховд – Өлгий чиглэлийн авто зам, Ховд – Булган- Хилийн боомт чиглэлийн авто замын огтлолцох Манханы гурван замын уулзварт Аялал жуулчлалыг хөгжүүлэх, дамжин өнгөрөх жуулчдад мэдээллийг дэлгэрэнгүй хүргэх зорилгоор цахим мэдээллийн нэгдсэн төвийг байгуулахаар зураг төсвийг боловсруулсан бол аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хоёр авто машины зогсоолыг барин ашиглалтад оруулав. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын 30 айлын орон сууцны урд талбайд хүүхдийг тоглоомын талбай, спорт талбай тохижилтыг хийж ашиглалтад оруулав. Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 25 аж ахуйн нэгжийн 638 айлын орон сууц баригдаж байгаа бөгөөд 9 аж ахуйн нэгжийн 229 айлын орон сууц байнгын ашиглалтад орж гадна авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай зэргийг норм, дүрмийн дагуу хийж гүйцэтгэхэд хяналт | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тавьж ажилласан.  Хөшөөт хөгжлийн сангийн 75 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын 3, 4 дүгээр хорьтын талбайд шинэ хүүхдийн тоглоомын талбайтай болгож ашиглалтад оруулсан.  Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээг хүлээн авахдаа Засгийн газрын 212 дугаар тогтоолоор барилга байгууламжийн ажлыг хүлээн авахдаа эхний ээлжинд зураг төсөл зохиогчийн дүгнэлт, захиалагчийн дүгнэлтийг үндэслэн улсын комиссыг томилон ажиллуулж байна. Харин комиссын үйл ажиллагааг газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас тухай бүрт бичлэг болгон гаргаж хэвлэл мэдээлэл болон https://www.facebook.com/khovdaimaggazriinkharilt saa цахим хаягаар олон нийтэд ил тод хүргэн ажиллаж байна.  Нийт 140 төсөл арга хэмжээг ил тод, нээлттэй байршуулсан байна. | |
| 199 | 6. АЗДҮАХ-ийн 3.8.2 | 6. “Стандарттай Ховд” хөтөлбөрийн хүрээнд /ногоон байгууламж/ | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 70% | 15 000 000 | 2022 онд Жаргалант сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр нийтийн эзэмшлийн 204 ширхэг хашаа бүхий саадыг 650 кг зүлгийн үрээр 1,5 га-д ургамлын бүрхэвчгүй сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүллээ. Мөн услалтын системийг дуслын аргаар давхар шийдвэрлүүлсэн. 2022 оны 8 дугаар сарын 12-ны өдөр аймгийн Засаг даргын орлогч ХОАХААА/202203047 зүлэг цэцгийн үр нийлүүлэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу “Буянт үр жимс инженеринг нэгдэл” ХХК 30,000ш, иргэн Н.Эрдэнэбаяраас 6500ш, иргэн Г.Мишгаагаас 5000 ш, П.Таравхүү 400 ш, иргэн н.Ганцэцэгээс 1750 ширхэг нийт 13650 ширхэг цэцгийн үрсэлгээг авч Хот тохижуулах газарт хүлээлгэн өгч тариалалт хийж хотын өнгө | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үзэмжийг нэмэгдүүлсэн.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт эрчимжүүлэх зорилгоор намрын мод тарих сарын аяныг "ӨРХ БҮР ХАШААНДАА 10 Ш МОД ТАРЬЯ-2022" стандартын тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг 10 дугаар сарын 14,15-ний өдрүүдэд “Ард-Аюуш”-ийн талбайд зохион байгуулж, иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудад мод тарьж ургуулахтай холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөөг 50 гаруй иргэнд өглөө. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд Жаргалант сумын иргэд, аж ахуй нэгж, байгууллагууд Буянт гол, хорихын урд засмал зам дагуух 2 байрлалд хотынхоо өнгө үзэмж нэмж мод, бут сөөг тарилаа. Энэхүү үйл ажиллагааг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд энэ жил хоёр голын дунд 7000 мод, засмал зам дагууд 550 мод тарьж хамгаалалтын ойн зурвас байгууллаа. | |
| 200 | 7. АЗДҮАХ-ийн 3.8.2 | 7. Ховд хотын дахин төлөвлөлт, хэсэгчилсэн төлөвлөлтийг хийж, иргэдийн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар орон сууцжуулах ажлыг үе шаттай зохион байгуулна. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 100% | 50 000 000 төгрөг | Орон нутгийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ховд хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Шинэ суурьшлын бүсийн 20 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг "Алтан орд констракшн"ХХК-аар хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Эхний ээлжинд ерөнхий төлөвлөлтийн санаа шийдлийг боловсруулан гаргаж, ИТХ-р хэлэлцүүлэн батлуулснаар бусад дэд бүтцийн зураг төслийг боловсруулах боломжтой болсон. Одоогийн байдлаар иж бүрэн дэд бүтцийн зураг төслөө хийж гүйцэтгэн боловсруулж, Барилгын хөгжлийн төвд хянуулан батлуулахаар ажиллаж | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. Ингэснээр иж бүрэн 20 га хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв гарч цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилгуудын төлөвлөлтийг тогтоох бүрэн боломжтой болно. | |
| 201 | 8. АЗДҮАХ-ийн 3.8.3 | 8. Нийгмийн даатгал төлдөг, бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууцанд ороход нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 4-6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлэнд хамруулна. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 30% | 15 000 000 төгрөг | Тус ажлын хүрээнд энэ жил Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 2 албан хаагчдад байрны урьдчилгаа төлбөр болох тус бүр 15,0 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг олгож банкны 6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлэнд хамруууллаа. Харин энэ асуудлаар Засгийн газар Нийгмийн даатгал төлдөг, бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууцанд ороход нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 4-6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлэнд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна | 90% |
| 202 | 9. АЗДҮАХ-ийн 3.8.4 | 9. Баруун бүсийн барилгын материалын нэгдсэн лабораторийг байгуулна | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 100% | 150 000 000 | Лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Металл эдлэхүүний лабораторийг байгуулахаар төлөвлөн орон нутгийн төсвийн захиалагчийн хяналтын зардлаас 150,0 сая төгрөгөөр тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зарлан гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулан ажлыг хийж гүйцэтгүүллээ. БХТ-ийн Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийн “Металл эдлэхүүний лабораторит дадлагажих” сургалтанд 2022 оны 10 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд лабораторийн шинжээч, лаборант нарыг хамруулсан. Ингэснээр нийтдээ 4 нэр төрлийн лабораторитай боллоо. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 203 | 10. АЗДҮАХ-ийн 3.8.5 | 10. Барилгын материал үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжинэ. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 100% | | Буянт сумын нутагт “Вестерн Холд“ ХХК нь жилдээ 300 мянган тонн цемент үйлдвэрлэж, баруун бүсийн аймгуудын цементийн хэрэглээг бүрэн хангах “Ховд эко цементийн үйлдвэр”-ийг барьж ашиглалтад, 2022 оны 10 дугаар сард ашиглалтад орсон бөгөөд барилгын материалын гол түүхий эд болох цементийг үйлдвэрлэж эхэлсэн. Цемент үйлдвэрлэж эхэлсэнээр ховд аймагт барилгын болон цементийн үнэ буурах боломж нөхцөл бүрдсэн. МБМҮХолбооны тусгай зөвшөөрлийн экспертизийн багтай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 08-09-ны өдрүүдэд тус аймагт үйл ажиллагаа явуулдаг барилгын материалын үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах болон шинээр авах талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан. | 100% |
| 204 | 11. АЗДҮАХ-ийн 3.8.6 | 11. Ховд хотын үерийн далан, борооны ус зайлуулах суваг, хоолойг үе шаттай байгуулна. | 12 сар | - | 2 км | Замын сангийн 100,0 сая төгрөг | Аймгийн Замын сангийн 100,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Жаргалант сумын Нисэхийн хашаанаас хогийн нэгдсэн цэг хүртэлх 2,1 км үерийн шороон далангийн ажлыг хүлээн авсан. Барилга хот байгуулалтын яамны захиалгаар Жаргалант сумын үерийн хамгаалалтын байгууламжийг, зураг төсвийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэхээр 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. | 100% |
| 205 | 12. АЗДҮАХ-ийн 3.8.7 | 12. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Ховд хот, сумын төвүүдэд 1000 айл өрхийг орон сууцжуулах | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 30% | | Хувийн хэвшлийн хөрөнгөөр Жаргалант сумын Магсаржав багт гэр бүлийн хэрэгцээний газрыг худалдан авч, “Пламбинг деволопмент” ХХК, “Сац гурван хайрхан” ХХК, “Тэгш стандарт” ХХК-нууд 5 айлын 4385м2 газарт 90 айлын орон сууц, “Эрдэний шим” ХХК 2 айлын 1896 м2 газарт 45 айлын орон сууц, “Бат арга билэг” ХХК 2 айлын 1894 м2 газарт 45 айлын орон сууцны барилга | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төсөл хэрэгжүүлнэ. | | | | | барьж, тус онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Мөн Жаргалант сумын Бугат багт “Ховд баганат” ХХК 1 айлын 1100м2 газарт 28 айлын орон сууц, “Баруун жонон” ХХК 1 айлын 1372м2 газарт 28 айлын орон сууц, “Шүрэн баян уул” ХХК 2 айлын 3107м2 газарт 75 айлын орон сууц, “Марч констракшн” ХХК 2 айлын 4712м2 газарт 138 айлын орон сууц, “Ховдын хаш өргөө” ХХК 2 айлын 2436 м2 газарт 72 айлын орон сууц, “Эрхэт модун” ХХК 2 айлын 1411м2 газарт 180 айлын орон сууц, “Залай Алтай” ХХК 2 айлын 3363м2 газарт 56 айлын орон сууц, Цамбагарав багт 8 айлын 9553м2. 240 айлын орон сууцны хотхон хорооллын барилга угсралтын ажил эхлүүлээд байна. Жаргалант сумын Бугат багт “Ховд баганат” ХХК 1 айлын 1100м2 газарт 28 айлын орон сууц, “Баруун жонон” ХХК 1 айлын 1372м2 газарт 28 айлын орон сууц, “Марч констракшн” ХХК 2 айлын 4712м2 газарт 138 айлын орон сууц, “Ховдын хаш өргөө” ХХК 2 айлын 2436 м2 газарт 72 айлын орон сууц, “Эрхэт модун” ХХК 2 айлын 1411м2 газарт 180 айлын орон сууц, барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьтай “Шүрэн баян уул” ХХК 2 айлын 3107м2 газарт 75 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 50 хувтай, “Залай Алтай” ХХК 2 айлын 3363м2 газарт 56 айлын орон сууц, Цамбагарав багт 8 айлын 9553м2орон сууцны барилга угсралтын ажил дуусаж ашиглалтад хүлээлгэж өгөхөд бэлэн болоод байна. Нийт Ховд аймагт гэр хорооллын 6 байршилд 29 айлын 35229м2 хашааны газарт 1031 айлын орон сууцны хотхон, хороолол баригдах ажил хийгдэж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 206 | 13. АЗДҮАХ-ийн 3.8.8 | 13. Настжилт өндөртэй орон сууцнуудын дээвэр, фасад, шугам сүлжээ, орц, хонгил, зам талбайг шат дараатайгаар засварлана. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 30% | 234.4 сая төгрөг | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хуучирч муудсан шугам сүлжээний засвар / Жаргалант сум/ 96 сая төгрөг, ЕБС, цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл хангах, болзошгүй эрсдэлийн зардал-100 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шугам сүлжээ муудсан нийтийн орон сууцны барилга-6, ЕБСургуулийн барилга-4, өрхийн эмнэлгийн барилга-1, төрөх эмнэлгийн барилга-1, цэцэрлэгийн барилга-3. Цэвэр, бохир, дулааны шугам сүлжээний урсгал, хэсэгчилсэн засварыг хийж гүйцэтгээд байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө 38,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Динотос" ХХК-тай гэрээ байгуулан Гаалийн 12 айлын орон сууцны гадна фасадны ажлыг хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгөв. | 100% |
| 207 | 14. АЗДҮАХ-ийн 3.8.9 | 14. Аймгийн хэмжээнд газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалт хийнэ. | 12 сар | - | Ажлын гүйцэтгэл 100% | 105.7 сая төгрөг | Хаягийн мэдээллийн сангийн өгөгдлийг газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөлтэй болон газар дээрх хаягжуулалттай харьцуулан шалгах, засварлах зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлыг хаягийн мэдээллийн систем дээр хийж гүйцэтгэлээ. Уг ажил Буянт сум хилийн цэсийн маргаантай тул лэнд менежер програмд ороогүй, Алтай сум Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гараагүй, Булган сум вэбд нэвтрэх эрх алдаа заасан шалтгаанаар хийгдээгүй. Дуут, Дарви, Цэцэг сумдын хаягийн тэмдэг, тэмдэглэгээ суурилуулах ажил хийгдсэн. Хаягийн мэдээллийн сангийн өгөгдлийг шинэчилж, Дуут, Дарви, Цэцэг сумдын хаягийн тэмдэг, тэмдэглэгээ суурилуулах ажил хийгдсэн. Хаягийн мэдээллийн сангийн өгөгдөл засварлах ажил хийгдэж дууссан. Аймгийн хэмжээнд хаяг олгогдоогүй нэгж талбаруудыг засварлах, хаягийн мэдээллийн сангийн системийг эрхлэх | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | талаар сумдын газрын даамлуудад цахим сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр зохион байгуулж, чиглэл өгч ажиллалаа. Мөн Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 2022 оны 180 дугаар тогтоол, 181 дугаар тогтоолуудын холбогдох хэсгүүдийн хэрэгжилтийг хангах ажиллаж орон нутгийн хэмжээнд шинэ хаягийн системд бүртгэгдсэн шинэчилсэн мэдээллээр 125 иргэн аж ахуйн нэгж байгууллагад үйлчилгээ үзүүллээ. 2022 онд шинээр хаягжуулах шаардлагатай нэгж талбарын судалгааг гарган, хаяг олгох ажлыг хийж байна. Мөн 2022 оны орон нутгийн төсөвт Эрдэнэбүрэн, Манхан, Алтай сумдууд хаягжуулалт хийлгэхээр 22 сая төгрөг тусгаж батлуулсан. | |
| 208 | 15. АЗДҮАХ-ийн 3.8.10 | 15. Хот суурин газрын ус хангамжийн хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 12 сар | - | 48600м | | Гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/-н 9,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Ховдын өргөө” ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд 900 м бохир усны шугам, 1100 м цэвэр усны шугамын ажил хийгдэж, 2014 онд ашиглалтад орсон станцын насос сольсон. 2022 онд хийгдэх 15 км шугам сүлжээний ажлыг 100 хувь хийж гүйцэтгээд байна. Мөн агаар орчны бохирдлыг бууруулах сангийн эрх шилжсэн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас 731,0 сая төгрөгөөр гэр хорооллын 400 айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлын тендерт “Шим ус” ОНӨААТҮГазар тендерт шалгаран гэрээ байгуулан ажлаа эхэлсэн 2022 оны 09 дүгээр сарын30 -ны байдлаар гэр хорооллын 120 айлыг цэвэр бохирын шугам сүлжээнд холбоод байна. 46200м- Цэвэр усны шугам сүлжээний ажил нийт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90 хувьтай хэрэгжиж байна. Усны 2 дахь эх үүсвэрийн зураг төсөв хийгдсэн. | |
| 209 | 16. АЗДҮАХ-ийн 3.8.11 | 16. Хот суурин газрын ариутгах татуургын хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 12 сар | - | 31804 | Улсын төсвийн хөрөнгө оруулалт 9.3 тэрбум Агаар орчны бохирдлыг бууруулах сангийн эрх шилжсэн 731 сая | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/-н 9,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Ховдын өргөө” ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд 900 м бохир усны шугам, 1100 м цэвэр усны шугамын ажил хийгдсэн. 2022 онд хийгдэх 15 км шугам сүлжээний ажлыг 100 хувь хийж гүйцэтгээд байна. Мөн агаар орчны бохирдлыг бууруулах сангийн эрх шилжсэн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас 731,0 сая төгрөгөөр гэр хорооллын 400 айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлын тендерт “Шим ус” ОНӨААТҮГазар тендерт шалгаран гэрээ байгуулан ажлаа эхэлсэн 2022оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар гэр хорооллын 120 айлыг цэвэр бохирын шугам сүлжээнд холбоод байна. Ажил хэвийн үргэлжлэн явагдаж байна. | 100% |
| 210 | 17. АЗДҮАХ-ийн 3.8.12 | 17. Ховд хотын шугам сүлжээнд /бохир/ өргөтгөл, шинэчлэл хийнэ. | 12 сар | - | 34304 | 6 тэрбум төгрөг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/-ний 9,3 тэрбум төгрөгийн ажлыг “Ховдын өргөө” ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд 2022 онд бохир усны 5875м шугамын угсралтын ажлыг гүйцэтгэсэн. | 100% |
| 211 | 18. АЗДҮАХ-ийн 3.8.12 | 18. Ховд хотын /цэвэр/ шугам сүлжээнд | 12 сар | - | 48000 | 731,0 сая төгрөг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/-ийн 9,3 тэрбум төгрөгийн төсөвт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өргөтгөл, шинэчлэл хийнэ. | | | | | өртөгтэй ажлыг “Ховдын өргөө” ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд 900 м бохир усны шугам, 1100 м цэвэр усны шугамын ажил хийгдсэн. 2022 онд хийгдэх 15 км шугам сүлжээний ажлыг 100 хувь хийж гүйцэтгээд байна. Мөн агаар орчны бохирдлыг бууруулах сангийн эрх шилжсэн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас 731,0 сая төгрөгөөр гэр хорооллын 400 айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлын тендерт “Шим ус” ОНӨААТҮГазар шалгаран гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн. Нийт 6961.9м шугам холбохоос 3881.6 гүйцэтгэсэн бөгөөд хос шугамаар 200 гаруй айл өрх холбосон, үлдэгдэл 3080м шугамыг 2023 оны хавар холбож дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| 212 | 19. АЗДҮАХ-ийн 3.8.12 | 19. Ховд хотын /дулаан/ шугам сүлжээнд өргөтгөл, шинэчлэл хийнэ. | 12 сар | - | 48300м | нийт 847.0 сая төгрөг | Энэхүү ажлын хүрээнд аймгийн 16 сумын нэгдсэн дулаан хангамж, шугам сүлжээ, зуухны барилга угсралт, дулаанаар хангах ажлыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж Үенч, Дуут, Мөнххайрхан сумуудыг нэгдсэн дулаан хангамжид холбож нийтдээ 14 сумыг нэгдсэн халаалттай болголоо. Мөн давхар төрийн байгууллагуудыг нэгдсэн халаалтад бүрэн холбогдсон. Ховд дулааны станцын аваарын нөөц бүрдүүлэлт хангах зорилгоор 172,0 сая төгрөгний төсөвт өртөгтэй ажлыг “МЭЗ”ХХК хийж гүйцэтгэж байна. Жаргалант сумын Бугат багт орон сууцны шинэ хорооллыг байгуулах зорилгоор ДДТөв-9 шинээр барих-300,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Мөнхбаян Эрдэнэ”ХХК хийж гүйцэтгэж байна. Ажлын явц-100 хувьтай. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ДДТөв-13 шинээр барих-102 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Очир буян | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өргөө"ХХК- хийж гүйцэтгэсэн. дулаан дамжуулах төв - 13- н тоног төхөөрөмжийн өргөтгөлийн ажлын дэмжлэг 90 сая төрөгийг нэмэлтээр шийдвэрлэсэн. Нийт 847,0 сая төгрөгийг зарцууллаа. | |
| 213 | 20. АЗДҮАХ-ийн 3.8.13 | 20. Аймгийн 90 жилийн ойг угтаж "Цайны зам" цогцолбор байгуулна. | 12 сар | - | - | 80 сая төгрөг | Орон нутгийн төсвийн 80 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн 90 жилийн ойг угтаж "Цайны зам" цогцолбор байгуулах талбайн тохижилтын ажлыг Ховд аймаг дахь ШШГГ- 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангитай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлэн, улсын комисс хүлээн авсан | 100% |
| 214 | 21. АЗДҮАХ-ийн 3.8.14 | 21. Цайны замын эхлэл, дундах буудал, /өртөөний газар/, төгсгөл цэгүүдэд дурсгалын болон мэдээллийн самбар байгуулна. | 12 сар | - | Мэдээллийн самбар байршуулах | 40 000 000 | Цайны замын эхлэл, дундах буудал, /өртөөний газар/, төгсгөл цэгүүдэд дурсгалын болон мэдээллийн самбаруудыг байршуулах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 40 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Сод прогресс"ХХК-тай гэрээ байгуулан, тус гэрээний хүрээнд 3 цэгт самбаруудыг байршуулан хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 4. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | |
| 215 | 1. АЗДҮАХ-ийн 4.1.1 | 1. Нэг иргэн-нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлнэ. | 12 | - | Нэг иргэн-нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлнэ. | | Ховд аймгийн хэмжээнд 17 сумын бүртгэлийн нэгжүүдийг онлайн нэгдсэн системд холбож үйл ажиллагааг орон зайнаас үл хамааран хөдөөгийн иргэдэд хүргэж байна. Орон нутагт улсын бүртгэлийн үйлчилгээ авсан иргэдийн бүх бүртгэл цахимаар архивлагддаг болсон. Ингэснээр иргэд ирээдүйд өөрт хамааралтай мэдээллээ цахим архиваас өөрөө авах боломж бүрдүүлсэн. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд Тоон гарын үсгийн олголт хийгдэж байгаа бөгөөд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өнөөдрийн байдлаар 15000 иргэн хамрагдсан байна. | |
| 216 | 2. АЗДҮАХ-ийн 4.1.1 | 1. Иргэдийн төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд төрийн цахим үйлчилгээг сумандаа шуурхай авдаг болно | 12 | - | Иргэдэд хүргэх цахим үйлчилгээний тоо-181 | 12 сая төгрөг | Цахим хөгжил, харилцаа холбооны яам, e-mongolia академитай хамтран иргэд болон төрийн албан хаагчдад цахим хэрэглээний мэдлэг, ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 66 төрлийн үйлчилгээг цахимжуулж e-mongolia системд нэгтгэснээр цахим үйлчилгээний нэгдсэн портал https://e-mongolia.mn/-ээс 70 гаруй төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломж бүрдлээ. Ингэснээр төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.erp.e-mongolia.mn системд 17 сум, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлаг, төсөвт байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд болох 78 байгууллага холбогдож, албан хэрэг хөтлөлтийг цахимаар шийдвэрлэж, 11 дүгээр сарын байдлаар албан байгууллагуудаас 481 албан бичиг хүлээн авч, 486 албан бичиг явуулсан дүнтэй байна. Цаашид “Цахим Ховд” дэд хөтөлбөрийн хүрээнд албан бичгийн эргэлтийг цахимжуулах, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг сайжруулах зорилгоор төрийн болон нутгийн захиргааны 108 байгууллагад тус системийг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн бүх сумдад операторуудаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр 2450 иргэнд 54 төрлийн лавлагааг гаргаж үйлчилгээ үзүүлжээ. | 100% |
| 217 | 3. АЗДҮАХ-ийн 4.1.2 | 1. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа | 12 | - | 5 Төрийн байгууллагын нэгдсэн системд холбоно | 8 сая төгрөг | Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон "И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, байгууллага хоорондын уялдаа | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | холбооны технологийн дэвшил, инноваци нэвтрүүлж, үр ашгийг дээшлүүлнэ. | | | | | холбоо, мэдээллийн урсгалыг сайжруулах, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор аймаг, сумын төрийн байгууллагын 630 албан хаагч болон Их буян зах, Политехник коллежийн багш ажилчид, суралцагч нарт мэдээлэл технологийн сургалт зохион байгууллаа. Аймгийн 17 сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, сургууль цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем”-ийг нэвтрүүлж, албан бичгийг цаасаар биш цахимаар явуулж хэвшлээ. Төрийн үйлчилгээг операторын тогтолцоонд шилжүүлж, (https://operator.e-mongolia.mn/auth/login) систем нэвтрүүлж, орон нутгийн өмчит болон төрийн байгууллагуудын 66 үйлчилгээг нэмж одоогоор 158 үйлчилгээг ард иргэдэд цахимаар үзүүлж байна. | |
| 218 | 4. АЗДҮАХ-ийн 4.1.3 | 1. “Цахим-Ховд” хөтөлбөрийн хүрээнд хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбож, төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэн иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах | 12 | - | Цахим-Ховд хөтөлбөрийн хэрэгжилт 55 хувь | | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн технологи, цахим мэдээлэл солилцооны нэгдсэн системийг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлж, ажлын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Цахим Ховд” дэд хөтөлбөр боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 68 дугаар тогтоолоор батлуулан, амжилттай хэрэгжүүлж, “smart khovd” гар утасны апликейшн, нэг биллийн систем зэрэг технологийн дэвшил, инноваци нэвтрүүлэхээр тусган, хэрэгжүүлж байна. 17 сум Шилэн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нөхцөл бүрдүүлнэ. | | | | | кабелиар холбогдсон. Мобинэт ХХК-тай хамтран Сумдын Засаг даргын Тамгын газрын интернэт хурдыг 4мб хурдыг 10 мб, аймгийн ЗДТГ-ын интернэтийг хурдыг 40 мв болгож нэмэгдүүлэв. Иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7043-1111 мэдээллийн нэгдсэн төвд ирсэн санал хүсэлтийг Khovd-1111.mn сайтад байршуулан шийдвэрлэлтийн явцыг иргэд олон нийтэд нээлттэй байдлаар хүргэж байна. Олон шатлалт үйлчилгээ буюу орон нутгийн төрийн байгууллагаас гарах үйлчилгээг 54 төрлөөр нэмэгдүүлж нийтдээ 158 төрлийн орон нутгийн үйлчилгээ үзүүлж байна. Мөн аймгийн хэмжээний ил тод байдлын нэгдсэн системийг хийхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 219 | 5. АЗДҮАХ-ийн 4.1.4. | 1. Төрийн бүхийл байгууллагуудад ил тод байдлыг хангаж, Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлнэ | 12 | - | Ил тод байдлыг хангах, Шилэн дансны хуулийн хэрэгжилт | | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “SMS” МТ үйлчилгээгээр төсвийн захирагч, нягтлан бодогчдод мессеж хүргүүлэн урьдчилан сануулж төсөв, санхүүгийн мэдээллийг хугацаанд нь бүрэн ил тод мэдээлж байна. Шилэн дансны сайтад 2022 оны 12 сарын 31-ний байдлаар орон нутгийн байгууллагуудын нийт 17 сум, 89 байгууллагын 15954 мэдээллийг байршуулахаас 15631 мэдээллийг байршуулсан байна. Нийт байршуулсан 15631 мэдээллийн 14100 мэдээллийг хуулийн хугацаанд, 1531 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна. Үүнээс Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны мэдээлэл 97.1 хувьтай, төсвийн байгууллагуудын мэдээлэл 98.3 хувь, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын мэдээлэл 96.3 хувийн дундаж үзүүлэлттэй байна. Аймгийн орон нутгийн байгууллагуудын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийт дундаж үзүүлэлт 98.0 хувьтай мэдээлсэн байна. | |
| 220 | 6. АЗДҮАХ-ийн 4.1.5 | 1. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 12 | - | Хөтөлбөрийн хэрэгжилт-78 | | Ховд аймгийн хэвлэл мэдээллийн тогтолцоо, салбар болон байгууллагуудын ажиллах орчин, ажиллагсдын хөдөлмөрлөх нөхцөлийн тухай нөхцөл байдлын үнэлгээг 2022 оны 4 сараас 2 үе шаттайгаар хийн ажиллаж байна. Мөн салбарын хөгжлийг дэмжих, багаар ажиллах онцлог бүхий мэдээллийн тогтмол хөтөлбөртэй болох ажлуудын концепцийг боловсруулж, санал солилцох уулзалтыг 2022 оны 4 сарын 22, 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын дунд зохион байгуулж, анхдагч арга хэмжээнүүд, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтуудыг хийсэн. Сэтгүүлчдийг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлж, он гарсаар редакци бүрээс 1-2 сэтгүүлчийг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онлайн сургалтанд (2022 оны 3 сарын 17-18-нд), салбарын хэмжээнд 5 сэтгүүлчийг Улаангом хотод болсон Хэвлэлийн хүрээлэнгийн сэтгүүл зүйн онолын сургалтанд (4 сарын эхний хагаст), мөн 2 сэтгүүлчийг Улаанбаатар хотод мэдээллийн дата өгөгдөл ашиглах, боловсруулах сургалтанд (4 сарын сүүлийн хагаст), 2 сэтгүүлчийг мэдээллийн задлан шинжилгээний сургалтанд (5 сарын эхний хагаст) хамрууллаа. | 100% |
| 221 | 1. АЗДҮАХ-ийн 4.2.1 | 1. Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, | 12 | - | ТЗ-95 ТҮ-270 | | Төрийн албан хаагчдын чадавхжуулах сургалтын хүрээнд Удирдлагын академитай хамтран төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдын чиглүүлэх богино хугацааны сургалтад 11, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 22, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, мэдлэг чадвар, харилцаа хандлагыг сайжруулна. | | | | | сургалтад 6, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ "алсын хараа-2050" сэдэвт богино хугацааны сургалтад 8, "Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь" сэдэвт богино хугацааны зайн сургалтад 20, Төсвийн хөрөнгө оруулалт: үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ сэдэвт богино хугацааны зайн сургалтад 7, "Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг " сэдэвт богино хугацааны зайн сургалтад 9, "Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчлэл" сэдэвт богино хугацааны зайн сургалтад 10, "Төсвийн хөрөнгө оруулалт:үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ” сургалтад 6, "Жендерийн ахисан түвшний” сургалтад 4 төрийн албан хаагч хамрагдаж, энэ онд нийт 17 сум, 14 агентлагийн 104 төрийн албан хаагч тус тус сургалтад хамрагджээ. | |
| 222 | 2. АЗДҮАХ-ийн 4.2.1 | 1. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг ая тухай орчинд ажиллах нөхцөл боломцоог хангана. | 12 | - | Хэрэгжилт-95% | 862 сая төгрөг | Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдаж, түүнийг дагаж гарсан дүрэм, журмын хүрээнд 17 сумын ЗДТГ, ЗД-ын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлаг “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад буцалтгүй тусламж үзүүлэх, цалинтай чөлөө олгох зэрэг асуудлуудыг байгууллагууд хөдөлмөрийн журмандаа тусган шийдвэрлэж байна. Баруун бүсийн эмчилгээний төвийн Булган сумын нэгдсэн эмнэлэг “Эмч эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс хөнгөлттэй нөхцөлтэй байр, орон сууцаар хангах” арга хэмжээний хүрээнд газрын асуудлыг шийдвэрлэн Ховдын Жаргалант луу, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ховдын өргөө ХХК-тай хамтран 2 тэрбум 400 сая төгрөгний санхүүжилтээр 45 айлын орон сууцыг бариулж ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна. Мөн эмнэлгийн байгууллага шинээр барих болон эрүүл мэндийн салбарын эмч, ажилчдад зориулсан амьдрах нөхцлийг сайжруулах чиглэлээр газар, дэд бүтцийн асуудлыг эн тэргүүнд шийдвэрлэн аятай тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бололцоогоор хангасан байна. 2022 оны судалгаагаар Эрүүл мэндийн салбарын ажилчдаас ипотекийн болон түрээсийн орон сууцны зээлд хамрагдах хүсэлтэй 190 эмч мэргэжилтэн байна. Эмч, мэргэжилтний нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор аймгийн Засаг дарга эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудын орон сууцны хэрэгцээнд зориулан 400 м кв газрын асуудлыг шийдвэрлэж эрхийг баталгаажуулсан батламжийг гардуулж, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхээр болж, БОЭТ нь гэр бүлээрээ олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа 2 эмчид орон сууцны урьдчилгаа болох 40.0 сая төгрөгийн, нийгмийн хамгаалал шаардлагатай, байгууллагадаа үр бүтээлтэй ажиллаж буй 11 өрхөд иж бүрэн гэр олгох, байгууллагынхаа эмч, ажилчдын нийгмийн асуудалд анхаарч нэг хүнд 800.000 мянган төгрөг буюу нийт 400.0 сая төгрөг, нийт 862.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ. | |
| 223 | 3. АЗДҮАХ-ийн 4.2.2 | 1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, | 12 | - | Ёс зүйн зөрчилгүй байгууллага хамт олон бий болно | | “Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, хариуцлага, бүтээмжийг сайжруулах журам”-ыг хэрэгжүүлж, 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн дарга аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлагийн дарга нартай “Ёс зүйн дүрэм”-ийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сахилга хариуцлагыг шалгуур болгож ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | | | | | сахих хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Тайлант 2022 оны байдлаар ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагч бүртгэгдээгүй байна. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Төрийн албаны хууль, холбогдох журмын дагуу төрийн албан хаагчдын харилцаа хандлага, багаар ажиллах чадварыг байгууллагын үнэлгээний багаар үнэлүүлэхийн зэрэгцээ, иргэдэд шууд үйлчилгээ үзүүлдэг албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг тооцдог болов. | |
| 224 | 4. АЗДҮАХ-ийн 4.2.3 | 1. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, ажлын үр дүн тооцож, хариуцлагыг сайжруулна. | 12 | - | Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирна. | | Аймгийн удирдах ажилтнуудын зөвлөгөөн, Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр болон Засаг даргаас өгсөн бусад үүрэг даалгавруудыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн системд оруулж, хэрэгжилтийг цахимаар хянадаг боллоо. Төрийн бодлого шийдвэрийг орон нутагт хамтран хэрэгжүүлэх, төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор “Хамтын ажиллагаа-амжилтын үндэс” уулзалтыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Ховд аймгийн Прокурорын газар, Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газар, Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Ховд аймгийн нийтийн номын сан, Америкийн Нэгдсэн Улсын олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй "Хөгжлийн шийдэл" ТББ-аас хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн Ховд салбар зэрэг байгууллагуудтай хийж 2022 онд хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурлаа. Мөн нийгмийн салбарын байгууллагуудын удирдах ажилтны ээлжит уулзалт, хэлэлцүүлгийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллага дээрээ зохион байгуулсан. Мөн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний Өдрийн үйлчилгээ, Явуулын үйлчилгээг Ахмад чөлөөт эмч нар ТББ-аар, Гэрийн асрамж халамжийн үйлчилгээг Ховд аймаг дахь Улаан загалтайн нийгэмлэгээр, Ахмад настан, ХБИ-дэд протез, ортопедийн хэрэгсэл нийлүүлэх үйлчилгээг Улаан соёот ХХК-аар, Ерөнхий боловсролын хүүхдүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг Оюуны язгуур ТББ-аар, Мэргэжил олгох богино хугацааны сургалтыг Хөгжил политехник коллежоор, Үйлдвэр дээрх сургалтыг Вестерн холд ХХК, Хантан түнгэл ХХК, Ховдын өргөө ХХК-аар, Ажил олгогчдын сургалтыг Ажил мэргэжлийн стандарт, хүний хөгжлийн хүрээлэн ТББ-аар, Зээлийн өмнөх ба дараах сургалтуудыг "Хөгжлийн шийдэл" ТББ-тай тус тус гэрээлэн гүйцэтгүүлж байна. | |
| 225 | 5. АЗДҮАХ-ийн 4.2.4 | 1. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно. | 12 | - | Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянана. | 48.976.500 төгрөг | Цахим Ховд” дэд хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын нэг болох төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болгосноор төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулан, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал үр дүнгээ өгсөн ажил болж, орон зайнаас | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үл хамааран аль ч сумын иргэн тус төвөөр үйлчлүүлж, төрийн үйлчилгээг нэг дороос авах боломж бүрдлээ. Тус төвд 6 байгууллагын 10 мэргэжилтэн байнга ажиллаж, 7500 иргэнд 37 төрлийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүргэж, 17 сумын операторуудаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж, 2450 иргэнд 54 төрлийн лавлагаа, мэдээлэл олгосон байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг, 11 байгууллага, 17 сумын Засаг даргын Тамгын газар, 86 төсөвт байгууллага, 91 багт ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын мэдээг 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар нэгтгэн гаргахад нийт 15995 өргөдөл, гомдол хүлээн авч, 15039 өргөдлийг шийдвэрлэн хариу өгч, 647 өргөдлийг холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж, 309 өргөдлийг шийдвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 98.1 хувьтай байна. Мөн тайлант хугацаанд аймгийн Засаг дарга 550 иргэнийг биечлэн хүлээн авч уулзан асуудлыг шуурхай шийдвэрлэж, хариу өгч ажиллалаа. Түүнчлэн дэмжлэг хүссэн 444 өргөдөл ирүүлсний 147 нь шийдвэрлэж, 48,976,500 төгрөгийн санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлсэн байна. | |
| 226 | 6. АЗДҮАХ-ийн 4.2.5 | 1. Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох, | 12 | хувь | 88 хувиас дээш | 857 сая төгрөг | Аймгийн Иргэдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 84 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийг батлуулан 4 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг төлөвлөн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | жендерийн тэгш байдлыг хангах бодлого баримталж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манллайллыг нэмэгдүүлнэ. | | | | | хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сумдаас авч нэгтгэхэд нийт 425 ажиллагсадаас 201 нь эрэгтэй, 224 нь эмэгтэй ажиллагсад байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч 205 эмэгтэйд 857 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон. 2022 оны 3 дугаар сард Аймгийн гар урлаач эмэгтэйчүүдийн анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд аймгийн 17 сумын 130 гаруй гар урлал эрхлэгч эмэгтэйчүүд оролцож өөрсдийн туршлагаа солилцон үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ ард иргэддээ сурталчлан таниулж, 3.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | |
| 227 | 7. АЗДҮАХ-ийн 4.2.6 | 1. Төрийн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг бүх талаар дэмжиж, иргэний нийгэм, нийгмийн бүлгүүд, иргэд засаглалын үйл явцад хяналт тавих боломжийг хангана. | 12 | - | Төрийн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллана. | | "Дөргөн ногоон хөгжил үндэсний нийгэмлэг"-тэй хамтран сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, үрсэлгээ бий болгох зорилгоор 3000 ш заг модны үрээр үрсүүлсэн бортоготой үрсэлгээг суулган заг мод тариалалтын ажлыг эхлүүлээд байна. Залуучуудын чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх үүднээс ахуй үйлчилгээний төвийн барилгын засварласан өрөөнд Фитнес төв”-ийн өрөө гаргаж“Фитнес төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллаж байна. Сумын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг шинээр бий болгох ажлын хүрээнд "Хатан Ерөөлт“ нөхөрлөлийн үйлдвэрлэсэн талх нарийн боов болон бусад бүтээгдэхүүнийг цэцэрлэг, дотуур байрны хүнсний хэрэгцээнд нийлүүллэн ажиллаж байна. 2022 онд аймгийн Засаг даргын орлогч ХОАХААА/202203047 зүлэг цэцэгний үр нийлүүлэх гэрээ байгуулж, “Буянт үр жимс инженеринг нэгдэл” ХХК 30,000 ш, иргэн Н.Эрдэнэбаяраас 6500 ш, иргэн Г.Мишгаагаас | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 5000 ш, П.Таравхүү 400 ш, иргэн н.Ганцэцэгээс 1750 ширхэг нийт 13650 ширхэг цэцэгний үрсэлгээг авч Хот тохижуулах газарт хүлээлгэн өгч тариалалт хийж, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт эрчимжүүлэх зорилгоор намрын мод тарих сарын аяныг "ӨРХ БҮР ХАШААНДАА 10 Ш МОД ТАРЬЯ-2022" стандартын тарьц, суулгацын үзэлсгэлэн худалдааг 10 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд “Ард-Аюуш”-ийн талбайд зохион байгуулав. | |
| 228 | 8. АЗДҮАХ-ийн 4.2.7 | 1. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлж, хамтын үйл ажиллагааг сайжруулна. | 12 | - | Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлнэ. | | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого-”ын нэг чиглэл болох төрийн бүтээмжийг сайжруулах, мөн Цахим Ховд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системийг аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, сумдын Засаг даргын Тамгын газарт хөгжүүлэхээр төлөвлөж, тус ажлыг хэрэгжүүлэхээр “Ухаалаг засаглал” ТББ-ын удирдах зөвлөлийн дарга Ц.Амарбаясгалан ирж, холбогдох сургалтуудыг 11 дүгээр сарын 2, 3, 4-ний өдрүүдэд зохион байгууллаа. Үүнд аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нар болон нийт мэргэжилтнүүдийн хүрээнд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын ЗДТГ-ын хүрээнд тус тус зохион байгуулсан байна. Дээрх системийг хөгжүүлснээр аймгийн хяналт-шинжлгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг өөртөө агуулсан, аймгийн бүх төрийн албан хаагчдын оролцоог хангасан, үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоог бий болгох "Ухаалаг аймаг" төслийг хэрэгжүүлэх боломж бүрдэж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар нь дээрх системээр дамжуулан аймгийн нийт төрийн байгууллагууд, сумдын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааг үнэлж дүгнэх боломжтой болж байна. Мөн хотын ногоон байгууламж, ойжуулалт, хот тохижилт, хот доторх зорчигч тээврийн үйлчилгээ зэрэг ажлуудыг төр-хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгэж байна. | |
| 229 | 9. АЗДҮАХ-ийн 4.2.8 | 1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 12 | - | Ажиллах орчин сайжирч иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | Хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын нэг төрийн бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж, 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа эхлүүлсэн нь баруун бүс нутагтаа анхдагч болж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулан, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал үр дүнгээ өгсөн ажил болж, орон зайнаас үл хамааран аль ч сумын иргэн тус төвөөр үйлчлүүлж, төрийн үйлчилгээг нэг дороос авах боломж бүрдлээ. Тус төвд иргэд хамгийн ихээр үйлчлүүлдэг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Жаргалант сумын оператор зэрэг 6 байгууллагын 10 мэргэжилтэн 40 гаруй төрлийн үйлчилгээ үзүүлж, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 7500 иргэнд 37 төрлийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүргэсэн байна. | 100% |
| 230 | 10. АЗДҮАХ-ийн 4.2.9 | 1. Стандарттай Ховд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, | 12 | - | Хөтөлбөрийн хэрэгжилт-50 | 10 сая төгрөг | “Соёлтой төрийн үйлчилгээ-Авлига хүнд сурталгүй аймаг болох” зорилтын хэрэгжилт хангагдаж, чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 буюу (MNS ISO 9001-2016) стандартыг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад төрийн үйлчилгээний үндэсний стандарт нэвтрүүлнэ | | | | | 9 байгууллага үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Жаргалант, Дарви, Дөргөн, Мянгад сумд 2021 онд, 2022 онд үлдсэн 12 сум чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 буюу (MNS ISO 9001-2016) стандарт нэвтрүүлэхээр “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай гэрээ байгуулан зөвлөх үйлчилгээ авч байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч манай аймагт үйл ажиллагаа явуулж байсан “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болгон өөрчлөн зохион байгуулан 6 байгууллагын 10 мэргэжилтэн байнгын сууж 7500 иргэнд 37 төрлийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Мөн бүх сумдад операторуудаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр 2450 иргэнд 54 төрлийн лавлагааг гаргаж үйлчилгээ үзүүлсэн байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, e-mongolia академитай хамтран иргэд болон төрийн албан хаагчдад цахим хэрэглээний мэдлэг, ур чадвар олгох сургалтыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 66 төрлийн үйлчилгээг цахимжуулж e-mongolia системд нэгтгэлээ. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 231 | 11. АЗДҮАХ-ийн 4.2.10 | 1. Бараа, ажил үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтын бүх явцыг ил тод болгож, үнэлгээний хорооны гишүүдтэй ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулж, сахилга хариуцлагыг сайжруулна. | 12 | - | Худалдан авах ажлуудыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. | | Аймгийн Засаг даргын Тамгын Газрын даргын 2022 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах журам”-нд худалдан авах ажиллагааг нээснээс хойш 1-3 хоногт багтаан үнэлэх, үнэлгээний хорооны хурлыг нээлттэй, ил тод байдлаар “LIVE”-аар дамжуулан иргэдэд шууд хүргэх талаар нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөж ажиллалаа. Тайлант 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжиж ирсэн 53.563.642,6 (тавин гурван тэрбум таван зуун жаран гурван сая зургаан зуун дөчин хоёр мянга) төгрөгийн 28 ажлын худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан төлөвлөсөн хугацаа буюу 2022 оны 03 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулснаас 2 төсөл, хөтөлбөрийг нь олон улсын байгууллага, 26 төсөл, хөтөлбөрийг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна. Ховд аймгийн бүх тендер шалгаруулалтыг төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу хуулийн хугацаанд нь цахим хэлбэрээр зохион байгуулж, төсөл, хөтөлбөрийн тендерийн урилга, төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үр дүнг https://www.tender.gov.mn/ цахим хуудсанд нийтэлж, худалдан авах ажиллагааны тендерийн 45 үнэлгээний хороо байгуулж, үнэлгээний хороонд давхардсан тоогоор 256 иргэн томилон ажиллуулснаас төрийн албан хаагч 135, төрийн бус байгууллага, иргэний төлөөлөл 90 иргэн орж ажилласан бөгөөд бүх гишүүдтэй ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулж ажилласан байна. | 100% |
| 232 | 12. АЗДҮАХ- | 1. Төрийн албаны ерөнхий болон тусгай | 12 | - | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн | | Төрийн албаны ерөнхий шалгалт 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 19-ны өдрийн хооронд цахимаар зарлагдсантай | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ийн 4.2.11 | шалгалтыг хууль журмын хүрээнд ил тод нээлттэй зохион байгуулна. | | | хүрээнд ил тод нээлттэй зохион байгуулна | | холбогдуулан аймгийн хэмжээнд иргэдийг бүртгүүлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон “Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөл” олон нийтийн facebook хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэж, аймгийн Нутгийн ордны нэг давхарт Эрх зүйн хөтчийн ширээнд интернэтэд холбогдсон компьютер, 3 үйлдэлт принтер зэргийг байрлуулан шалгалтад бүртгүүлэх иргэдэд шуурхай бүртгүүлэх, 24 цагийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.2022 оны 04 дүгээр сарын 01-02-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны ерөнхий шалгалтад 221 иргэн орохоос 194 иргэн шалгалтад орж ерөнхий мэдлэгийн шалгалтад 70 иргэн орж, 36.1 хувьтай, монгол хэл бичгийн шалгалтад 59 иргэн орж, 30.4 хувьтай, дүн шинжилгээ хийх шалгалтад 56 иргэн орж, 28.9 хувьтай тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдэхээр боллоо. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалгыг хүлээн авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлд тусгай шалгалтаар албан тушаалын сул орон тоог нөхөхөөр захиалга хүргүүлж, 2022 оны 02 дугаар сарын 14, 15, 21, 03 дугаар сарын 23, 24, 25, 06 дугаар сарын 16, 17, 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 01, 07-ны өдрүүдэд тусгай шалгалтыг тус тус албан тушаалын ангилал тус бүрээр 18 удаа зохион байгуулж ажиллав. Нутгийн захиргааны байгууллагуудын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn, аймгийн албан ёсны www.khovd.gov.mn цахим хаяг болон “Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөл” олон нийтийн facebook хуудсаар нээлттэй зарлуулж, иргэдэд цахимаар мэдээлэл | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өгч, сул орон тооны захиалга ирүүлсэн нутгийн захиргааны байгууллагын дарга нарт тусгай шалгалтын талаарх мэдээллийг цаг тухай бүр хүргэн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллалаа. | |
| 233 | 13. АЗДҮАХ-ийн 4.2.11 | 1. Нутгийн захиргааны байгууллагуудад гагцхүү чадахуйн зарчмын хүрээнд томилгоо хийнэ. | 12 | - | Төрийн албаны тусгай шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд ил тод нээлттэй зохион байгуулж, чадахуйн зарчмын хүрээнд томилгоо хийнэ. | | Тайлант 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 18 удаа тусгай шалгалт зохион байгуулж, давхардсан тоогоор 232 албан тушаал зарлагдаж, төрийн захиргааны ахлах түшмэлийн удирдах албан тушаалд 5, төрийн захиргааны дэс түшмэлийн удирдах албан тушаалд 4, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн албан тушаалд 6, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлийн албан тушаалд 41, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын туслах түшмэлийн албан тушаалд 17, нийт 73 албан тушаалын сул орон тоог нөхөж, тус тусын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүллээ. Төрийн албаны тусгай шалгалтад төрийн жинхэнэ албан хаагч шатлан дэвшиж 13, туслах түшмэлээс туслах түшмэлд 1, дэс түшмэлээс дэс түшмэлд 1 төрийн жинхэнэ албан хаагч нэр дэвшсэн бол төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй 2019 оны 3, 2020 оны 6, 2021 онд 18, 2022 оны 19 иргэн, төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн нөөцөөс 3 иргэн тус тус нөөцийн бүртгэлээс төрийн жинхэнэ албан тушаалын тусгай шалгалтад орсон байна. 18 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 232 албан тушаал зарлагдаж, төрийн захиргааны ахлах түшмэлийн удирдах албан тушаалд 5, төрийн захиргааны дэс түшмэлийн удирдах албан тушаалд 4, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн албан тушаалд 6, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэс түшмэлийн албан тушаалд 41, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын туслах түшмэлийн албан тушаалд 17 нийт 73 албан тушаалын сул орон тоог нөхөв. | |
| 234 | 14. АЗДҮАХ-ийн 4.2.12 | 1. Аймгийн болон Мянгад, Дөргөн, Дарви, Манхан сумын Нутгийн удирдлагын ордоны барилгад их засвар хийнэ. | 12 | - | Засвар, шинэчлэлт хийгдсэн байна. | 55 сая төгрөг | Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын барилгын дотоод засварыг бүрэн хийж гүйцэтгэлээ.Үүнд: Байрны гадна хаалгыг шинээр сольж, цонх, хана ,шалыг будаж, мөн өрөөнүүдийн хана шал цонхыг будаж зарим өрөөний халаалтын парыг шинэчиллээ. Мөн Тамгын газрын өрөөнүүдийн хаягыг шинэчилэн хаягжууллаа. Мянгад сумын Нутгийн удирдлагын ордонд сумын Орон нутаг хөгжлийн сангийн 55,000,000 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна пассадын засварын ажлыг ХХК хийж гүйцэтгэлээ. | 100% |
| 235 | 15. АЗДҮАХ-ийн 4.2.13 | 1. Ардын хувьсгалын 100, Ховд аймаг байгуулагдсаны 90 жилийн ой болон сум, байгууллагуудын тэгш ой зэрэг арга хэмжээнүүдийг олон, үндэстэн ястны өв соёл, уламжлалын хүрээнд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлнэ. | 12 | - | Ардын хувьсгалын 100, Ховд аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ. | 10 сая төгрөг | Ардын хувьсгалын 100, Ховд аймаг байгуулагдсаны 90 жилийн ой болон Булган, Эрдэнэбүрэн, Мөст, Дуут сум байгуулагдсаны тэгш ойн баяруудыг холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд бүтээн байгуулалтын ажил өрнүүлэн, ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэв. Ховд аймаг байгуулагдсаны 90 жилийн ойд зориулсан "Ховд-90" ойн медаль 1480 ширхэгийг хийлгэж, тус медалиар аймаг, орон нутгийн хөгжил дэвшил, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан ахмадууд, төр, хувийн хэвшилд ажиллаж буй тэргүүний албан хаагчдаа шагнан урамшуулахын зэрэгцээ "Ховд-90 жил" түүхийн ном 1000 ширхэг хэвлүүлж, сум, байгууллага, иргэд олон нийтэд хүргэв. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 236 | 1. АЗДҮАХ-ийн 4.3.1 | 1. Аймаг, сумын төвийн гудамж талбайд гэрэлтүүлэг хийж камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ. | 12 | - | 50 хувь | | Аймгийн төвийн Жаргалант сумын Тарвастай 4 зам, 10 мянгатын уулзвар, Буурлууд дэлгүүрийн уулзвар, Тоглоомтой гудамны 4 зам тус бүрт шинээр гэрлэн дохиог иж бүрнээр суурилуулсан. Дээрх ажлыг орон нутгийн төсвийн 140.0 сая төгрөгөөр барьж байгуулсан. авто зам дагуух камерын засвар үйлчилгээг энэ онд бүрэн хийсэн байна.Жаргалант сумын хэмжээнд 165 гэрэлтүүлгийн 428 сая төгрөгөөр хийж, 130 сая төгрөгөөр хуучин гэрэлтүүлэгүүдэд засвар хийсэн байна. Буянт суманд нэмж 16 ширхэг камер суурилуулсан. | 90% |
| 237 | 2. АЗДҮАХ-ийн 4.3.1 | 1. “Тайван амгалан Ховдчууд” хөтөлбөрийг үргэжлүүлэн хэрэгжүүлнэ. | 12 | - | 50 хувь | 617,0 | Аймгийн төвийн Жаргалант сумын Тарвастай 4 зам, 10 мянгатын уулзвар, Буурлууд дэлгүүрийн уулзвар, Тоглоомтой гудамны 4 зам тус бүрт шинээр гэрлэн дохиог иж бүрнээр суурилуулсан. Дээрх ажлыг орон нутгийн төсвийн 140.0 сая төгрөгөөр барьж байгуулсан. авто зам дагуух камерын засвар үйлчилгээг энэ онд бүрэн хийсэн ба замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч 90 ширхэгийг шинээр хийж 45.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Цагдаагийн газраас зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн, соён гэгээрүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдээс төлбөртэй мэдээлэл авах журам, жишиг, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зэрэг чиглэлээр нийт 164 удаа сургалт, сурталчилгаа, уралдааныг зохион явуулж, 23396 иргэн хамрагдаж, 12450 ширхэг гарын авлага, тараах материал, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тараасан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 43 сурвалжлага мэдээлэл, ярилцлагыг бэлтгэн, Ховд телевиз, МҮОНРТ, Khovdnews.mn сайт зэргээр дамжуулан, иргэд олон нийтэд хүргэсэн. 16 камер шинээр суурилуулсан. Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах нэгдсэн арга хэмжээнд 7 сая төгрөг зарцуулсан. Жаргалант сумын хэмжээнд 165 гэрэлтүүлгийн 428 сая төгрөгөөр хийж, 130 сая төгрөгөөр хуучин гэрэлтүүлэгүүдэд засвар хийсэн байна. | |
| 238 | 3. АЗДҮАХ-ийн 4.3.2 | 1. “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 12 | - | 50% | | Хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 14 арга хэмжээ төлөвлөсөн. Хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх сургалтын агуулгад нийцсэн ШӨХТГ-аас бэлтгэсэн гарын авлага 200 ш-ийг иргэдэд хүргэсэн. ШӨХТГ-ын улсын байцагч нарын сургалтад нэг албан хаагчийн хамруулж чадавхжуулсан. Хэрэглэгчээс ирсэн нийт 5 гомдлыг шийдвэрлэсэн байна. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдөр”, Ахмад хэрэглэгчийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлсэн. Хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд МХГ-аас 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. | 100% |
| 239 | 4. АЗДҮАХ-ийн 4.3.2 | 1. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлнэ. | 12 | - | 50% | | Ховд аймгийн хэмжээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах 2 байгууллага ажилладаг ба "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах "хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 14 арга хэмжээ төлөвлөн хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх сургалтын агуулгад нийцсэн ШӨХТГ-аас бэлтгэсэн гарын авлага 200 ш-ийг иргэдэд хамтран хүргэсэн. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдөр”, Ахмад хэрэглэгчийн | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдөр”-ийг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлсэн. | |
| 240 | 5. АЗДҮАХ-ийн 4.3.3 | 1. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд зориулалттай эрсдэлийн сан байгуулж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ. | 12 | - | 100% | 338.422.175 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах хүрээнд омикрон хувилбарын халдварын эсрэг бэлэн байдлыг хангах эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийг шинэчилж, дархлааны багц 50 ком уян бамбар 4000 ш, ариун бамбар 1000 ш, вакумтейнер 5000 ш, ариутгал халдваргүйтгэлийн жавелин 10 фл тус тус нөөц бүрдүүлсэн байна. Мөн бусад зоонозын өвчний халдварын үед хэрэглэх халат 630 ш, комбинзон 380 ш, бээлий 5600 ш, малгай 641 ш, 1 удаагийн маск 6700 ш, спирт 76 30 л, улавч 740 хос, нүүрний хаалт 76 ш, жавилион 9фл, гар ариутгагч 24 ш, ки94 маск 985ш, ариун савх 4000 ш, вакум тенер 4800 ш, тест 225 ш, ариун бамбар 900 ш, усны хаалт 30 ширхгийг бүрдүүлж ажиллаж байна. Монгол Улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/А/12 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2022 оны 12 дугаар тогтоолоор короновируст халдвар ковид-19 цар тахлын үед Зоонозын өвчин судлалын төвийн хариу арга хэмжээнд ажилласан ажилчдын илүү цагаар ажилласан 1-10 сарын илүү цагийн нэмэгдэл хөлсөнд 338.422.175 төгрөг олгов. | 100% |
| 241 | 6. АЗДҮАХ-ийн 4.3.4 | 1. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж олон талт арга | 12 | - | 12.8% | 10.5 сая | Ховд аймагт архи, тамхи худалдаалах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг зөрчихгүй байх чиглэлээр 243 аж ахуйн нэгжид мэдээлэл, сурталчилгаа хийж, 2 төрлийн сэрэмжлүүлэг, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээг тогтмол зохион байгуулна. | | | | | зурагт хуудас 200 ширхгийг тараасан.“Архигүй бол зөрчилгүй”, “Үггүй үйлдэл”, архины эсрэг аяныг өрнүүлж цахим сүлжээнд соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 4.5 сая төгрөг зарцуулсан.Цагдаагийн газрын ЭСББ-нд зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн 891, баривчлагдсан 354 хүнд дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зан үйлд нөлөөлөх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, хорт зуршлаас татгалзах, архины асуудлаа амжилттай даван туулсан иргэдийн ярилцлага, сэтгэл зүйн болон нөлөөллийн подкастуудыг цагийн хуваарийн дагуу өдөр бүр сонсгож, ухуулга сурталчилгаа, сургалтыг 28 удаа хийсэн. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Ховд аймгийн Жаргалант сумын архины хамааралтай 2 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажилласан. Согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил эрсдэлийг бууруулах зорилгоор согтолт тодорхойлох тандагч багажийг 6 сая төгрөгөөр худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна “Хүчирхийлэлгүй эрүүл амьдралыг та өөрөө бүтээж чадна”, “ Архи шинэ үеийн залуусын сонголт биш” зэрэг нийт 11 төрлийн 1800 ширхэг постер /зурагт хуудас/-ыг бэлтгэж, цагдаагийн газрын пэйж хуудаст байршуулан 95.069 иргэнд хүрсэн. | |
| 242 | 7. АЗДҮАХ-ийн 4.3.5 | 1. Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудыг чадавхжуулах | 12 | - | 100% | 125.3 сая | Гадаадын иргэн харьяатын газрын авто машин худалдан авах 20 сая, Улсын бүртгэлийн хэлтсийн тоног төхөөрөмжийн 5 сая, ШШГГ 457 ангийн сургалтын тоног төхөөрөмжийн 17.5 сая, ШШГГ 457 анги мужааны тоног төхөөрөмжийн 8.8 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | материаллаг байдлыг нь сайжруулахад үе шаттай дэмжлэг үзүүлнэ. | | | | | сая, ШША Бүртгэл мэдээллийн төвийн тоног төхөөрөмж, тохижилтын 9.0 сая, шинжээчийн тоног төхөөрөмжийн 20 сая, Цагдаагийн газар нэгдсэн төвийн өргөтгөлийн 45.0 сая нийт 125.3 сая төгрөгийг төсөвлөж, холбогдох худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгууллаа. | |
| 243 | 8. АЗДҮАХ-ийн 4.3.6 | 1. “Иргэдийн эрх зүйн боловсрол олгох” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 12 | -- | 50% | | Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Орон нутгийн 2 телевизтэй хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Авлигын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай видео 80, текстэн мэдээ 190-ийг бэлтгэн, khovd.khural.mn, khovd.khural.mn, khovd.gov.mn болон Ховд аймгийн Засаг даргын тамгын газар, Хууль, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг фейсбүүк хуудсуудад байршуулж, нийт 164 удаа сургалт, сурталчилгаа, уралдааныг зохион явуулж, 23396 иргэн хамрагдаж, 12450 ширхэг гарын авлага, тараах материал, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг тараасан нийт давхардсан тоогоор 41000 иргэнд мэдээлэл хүргэсэн.Мөн эрх зүйн хөтөч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцааг тухай бүрд нь өгч байна. “Хууль, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа” гэсэн цахим хуудас ажиллуулж байгаа бөгөөд нийт 653 дагагчтай болсон. Иргэдэд мэдээллийг нээлттэй хүргэх үүднээс захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийг khovd.gov.mn цахим хуудсанд 235 захирамж байршуулан давхардсан тоогоор 86773 иргэнд мэдээлэл хүргэсэн байна. Сумдын эрх ажилтнуудыг чадавхжуулах сургалтад хамруулсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 244 | 9. АЗДҮАХ-ийн 4.3.6 | 1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт, мэдээллийг дээшлүүлнэ. | 12 | - | 50% | | Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Орон нутгийн 2 телевизтэй хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Авлигын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай видео 80, текстэн мэдээ 190-ийг бэлтгэн, khovd.khural.mn, khovd.gov.mn болон Ховд аймгийн Засаг даргын тамгын газар, Хууль, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг фейсбүүк хуудсуудад байршуулж, нийт 164 удаа сургалт, сурталчилгаа, уралдааныг зохион явуулж, 23396 иргэн хамрагдаж, 12450 ширхэг гарын авлага, тараах материал, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг тараасан нийт давхардсан тоогоор 41000 иргэнд мэдээлэл хүргэсэн.Иргэдэд мэдээллийг нээлттэй хүргэх үүднээс захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийг khovd.gov.mn цахим хуудсанд 235 захирамж байршуулан давхардсан тоогоор 86773 иргэнд мэдээлэл хүргэсэн байна. | 100% |
| 245 | 10. АЗДҮАХ-ийн 4.3.7 | 1. Мал хулгайлах гэмт хэргийг бууруулна. | 12 | - | 5.4 | 38 | Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр иргэд олон нийтэд Ховд цагдаагийн газар, Ховдын малчдын нэгдэл пэйж хуудсаар дамжуулан мэдээ мэдээлэл түгээж, малчдын бүлгийн гишүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран ажилласан. Цагдаагийн газраас сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нарт малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахимаар уулзалт, хэлэлцүүлгийг 1 удаа зохион байгуулж, “Малчдын бүлэг”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гишүүдийг шинэчлэх | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чиглэлээр албан бичиг хүргүүлсэн. Одоо аймгийн хэмжээнд малчдын 32 бүлэг ажиллаж, цагдаагийн алба хаагчид мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллаж байна. Малчид, мал бүхий иргэдийн эрх зүйн мэдлэг боловсролд зориулж хууль тогтоомжоор бэлтгэсэн 4 төрлийн санамж сэрэмжлүүлэг, 2 шторк бэлтгэн нийтэлж, 1000 гаруй иргэнд тараан өгсөн. Малын хулгайгаас сэргийлэх зорилгоор Буянт суманд шаардлагатай объектууд, авто зам дагуу 16 ширхэг камерыг шинээр байрлуулж 30.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх ажлуудын санхүүжилтийг аймгийн замын сангийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. Камержуулалтад шаардлагатай хүлээн авагчийн 3 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Малчид иргэдэд хүргэх мэдээллийн шторк, санамж, уулзалт, зөвлөгөөнд зориулж 5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэв. | |
| 246 | 11. АЗДҮАХ-ийн 4.3.8 | 1. Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн болон бодлогын орчинд шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулна. | 12 | - | 5.9 | 3 | 2021 оны эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 272 албан тушаалтан ХАСХОМ-ээ хуулийн хугацаанд буюу 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж 100 хувь хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгээ тайлагнасан. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан авлигын эсрэг мэдлэг олгох анхан шатны цахим сургалтад аймгийн ЗДТГ, агентлагууд, сумдын шинээр томилогдсон албан хаагчид нийт 60 орчим хүн, авлигын эсрэг мэдлэг олгох цахим давтан сургалтад аймгийн ЗДТГ, агентлагуудын удирдах болон ахлах ажилтнууд нийт 100 гаруй албан хаагчийг хамруулсан. Шударга ёсны боловсрол олгох сургалтын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөр сонгон шалгаруулах уралдаанд оролцогч багш нарт зориулсан сургалтад аймгийн төвийн 7 сургууль, сумдын сургуулиудын багш нарыг оролцуулах ажлыг зохион байгуулсан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас Мөнххайрхан суманд ажиллаж төрийн албан хаагчдын хоёрдугаар зөвлөгөөнд оролцон “Төрийн албаны шинэтгэл, төрийн бүтээмж” сургалтыг зохион байгуулсан тус сумын нийт 150 орчим төрийн албан хаагч хамрагдсан. ЗДТГ-ын ЭБАТ бие даан аймгийн төвийн 6 байгууллагад Мал эмнэлгийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Ус цаг уур орчны шинжилгээний алба, Гадаадын иргэн, харьяатын газар, Орон нутгийн өмчийн газар болон аймгийн ИТХ-ын болон Мөнххайрхан сумын ИТХ-ын төлөөлөгчдөд “Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ? Түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр танхимын сургалтыг тус бүр байгууллага дээр нь 2022 оны 2, 3 дугаар улиралд зохион байгуулсан. Нийт 160 гаруй албан хаагч хамрагдсан. | |
| 247 | 12. АЗДҮАХ-ийн 4.3.9 | 1. Үндэсний аюулгүй байдлыг хангах хуулийн хүрээнд хэрэгжилтэнд шаардлагатай төсвийг жил бүр батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 12 | - | 100% | 320 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар батлагдсан “ҮАБЗ-г мэдээллээр хангах журам”, аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2021 оны 163 дугаар тогтоолын дагуу байгууллага, сумдын ЗДТГ-уудаас журамд заагдсан танилцуулах болон шуурхай мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч боловсруулан ҮАБЗ-ын ажлын албаны шуурхай жижүүрийн утсанд өдөр бүр мэдээлэв. АИТ-н Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 164 дугаартай тогтоолоор аймгийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдлын талаарх бодлогын баримт бичгийг баталсны дагуу Ховд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймгийн Засаг дарга ҮАБ-ыг хангах 2022 оны арга хэмжээний төлөвлөгөөг баталсан бөгөөд 10 чиглэлд 50 арга хэмжээг төлөвлөн ажилласан. Энэ хүрээнд сургалт сурталчилгааны 24 арга хэмжээнд 3000 орчим иргэн, төрийн албан хаагч оролцсон байна. Ховд аймгийн хэмжээнд тусгай хэрэгцээнд нийт 24 газрын 372566.38 га талбайг хамгаалалтад авсан. Ховд аймгаас 40 алба хаагч энхийг сахиулах ажиллагаанд оролцохоор сонгон шалгаруулалтад хамрагдсан. Боловсрол шинжлэх ухаан, байгаль орчны чиглэлд сургалтын платформ төсөлд 320 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавьж байгаа бөгөөд Ховд аймгийн хэмжээнд нийт 12 орны 225 гадаадын иргэн оршин сууж байгаад байршил, хаяг, бодит байдлыг тогтоох зорилгоор нэг удаа хяналт шалгалт хийсэн байна.Өрхийн аж ахуйн түвшинд 68 иргэний төсөлд 229.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд Ховд аймгийн хэмжээнд байнгын ажлын байр 327, улирлын 23, түр 14 ажлын байр бий болсон. Төрийн аудитын газар, цагдаагийн байгууллага хамтран холбогдох мэдээллийг нэгтгэн хяналт тавьж ажиллаж байна. ҮАБЗ-г мэдээллээр хангах журмын дагуу аймгийн Цагдаагийн газар, ОБГазар, ЭМГазар болон бусад холбогдох байгууллагаас мэдээллийг өдөр бүр авч ҮАБЗ-н шуурхай албаны жижүүрийн 5126959 дугаарт өгч хэвшсэн. Тайлант хугацаанд Ховд аймагт гарсан малын гоц халдварт Шүлхий, Тарваган тахал өвчнүүдийн тохиолдол бүрийг цаг хугацаанд нь мэдээллэж ажилласан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 248 | 13. АЗДҮАХ-ийн 4.3.10 | 1. Цагдаагийн газрын барилгыг шинэчлэн барина. | 12 | - | 100% | 100 | Цагдаагийн газрын шинэ конторын барилгын зураг, төсвийг 55.000.000 төгрөгөөр хийлгэсэн. Газрын асуудал шийдэгдсэн. 2024 оны төсөвт суулгахаар холбогдох газруудад саналаа хүргүүлсэн. Цагдаагийн газрын өргөтгөлийг орон нутгийн төсвийн 45 сая төграгийн хөрөнгө оруулалтаар барьсан. | 50% |
| 249 | 14. АЗДҮАХ-ийн 4.3.10 | 1. Хөдөлгөөнт эргүүлийн парк шинэчлэлтийг шийдвэрлэнэ. | 12 | - | 100 | 50 | Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар Цагдаагийн газарт эргүүл хамгаалалтад ашиглах Старекс болон приус-20 автомашиныг ашиглалтад авч, хүлээлгэн өгсөн. | 100% |
| 250 | 15. АЗДҮАХ-ийн 4.3.11 | 1. Улсын бүртгэлийн хэлтэс болон Төрийн архивын нэгдсэн байрны асуудлыг шийдвэрлэнэ. | 12 | - | 2.4 тэрбум | 6000 | Улсын бүртгэлийн хэлтсийн байр барих газрыг шийдвэрлэж, санхүүжилтийг шийдвэрлэсэн бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 75%-тай явагдаж байна. | 100% |
| 251 | 16. АЗДҮАХ-ийн 4.3.12 | 1. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг дэмжинэ. | 12 | - | 100% | 3 | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо энэ онд 3 удаа хуралдаж 3 удаагийн тогтоол гаргасан бөгөөд эрсдэлт бүлгийн 175 хүүхдийг даатгалд хамруулахаар төлөвлөсөн. Даатгалд хамруулах ажил явагдаж байна. Эрх ашиг нь зөрчигдсөн 3 хүүхдийн өмгөөллийн зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн ба мөн 3 хүүхдийн өмгөөллийн зардлыг шийдвэрлэсэн. | 100% |
| 252 | 17. АЗДҮАХ-ийн 4.3.12 | 1. Эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн судалгааг гаргаж, даатгалд хамруулан, хамгаалах | 12 | - | 100% | 4 | Ховд аймаг нь 0-18 насны 36736 хүүхэдтэй бөгөөд нийт хүн амын 40.6 хувийг эзэлж байна. Аймгийн 23329 өрхтэй. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 663 хүүхэд байна. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг явуулын хэлбэрээр шуурхай үзүүлэх зорилгоор “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-г 17 сум, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээг үзүүлнэ. | | | | | Ерөнхий боловсролын 25 сургууль дээр 2022 оны 05 дугаар сараас 11 дүгээр явуулж 9206 хүүхэд, 16500 эцэг эхчүүд, хамтарсан багийн 203 гишүүн, сургууль, цэцэрлэгийн 405 багш ажилчдыг хамрууллаа. Эрсдэлийн программд 2022 онд 154 хүүхэд бүртгэгдсэн. Бүтэн өнчин 13, үрчлэгдсэн-10, хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн 9, хөгжлийн бэрхшээлтэй-21, кейс үйлчилгээнд хамрагдсан-101 хүүхэд байна. Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн эрхийг зөрчсөн хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ үл биелүүлсэн гэх 23 гомдол мэдээлэл хүлээн авч сумын хамтарсан багт шилжүүлж, тохиолдол бүрт нөхцөл байдлын үнэлгээ хийж 39 хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зогсоох дүгнэлтийг ХХҮГ-т хүргүүлж шийдвэрлэсэн. Гэр бүл цуцлалтад хүүхдийн асран хамгаалагч тогтооход шүүгчийн захирамжийн дагуу 3 гэр бүлийн асуудал дээр шинжээчээр ажиллаж дүгнэлтийг шүүхэд хүргүүлсэн. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас сумдын хамтарсан багтай хамтран үрчлэгдсэн 16 хүүхдийн гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийхэд эрх нь зөрчигдсөн хүүхэд байхгүй халамжийн болон хөгжлийн үйлчилгээнд 4 хүүхдийг холбон зуучилсан. Урьдчилан сэргийлэх чиглэлээр 24 арга хэмжээнд 9206 хүүхэд, нөхөн сэргээх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд 133 хүүхэд хамрагдсан. Явуулын үйлчилгээний хүрээнд 15 өрхөд хүнсний багц, 75 хүүхдэд дархлаажуулалтын багц, 30 хүүхдэд хичээлийн хэрэгсэл, 52 хүүхдэд өвлийн хувцасны дэмжлэг үзүүлсэн. Аймгийн засаг даргын нэрэмжит “Гэрэлт-Ирээдүй” тэтгэлэгт 2022 онд шинээр хамрагдах бүтэн өнчин хүүхдийн судалгааг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сумдаас авч 11 хүүхдийг хамруулан нийт 45 бүтэн өнчин хүүхэд тус тэтгэлэгт хамрагдсан. | |
| 253 | 1. АЗДҮАХ-ийн 4.4.1 | 1. “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд Хятад-Монгол-Оросын эдийн засаг, дэд бүтэц, шинжлэх ухаан, нийгэм, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 12 | - | Бүс нутгийн хамтын ажиллагаа сайжирсан байна. | | Ховд аймгийн Их нууруудын хотгорын жижиг нууруудын биологийн (бичил биетэн) нөөцийг судлах судалгааны ажлыг 2022 оны 07 дугаар сарын 21-ээс 30-нд Ховд их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны багш нар ОХУ-ын Алтай их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зохион байгууллаа. Мөн 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Ховд аймаг Ба БНХАУ-ын Цонж Хуй өөртөө Засах аймагтай Байтаг-Улиастай боомтыг нээх тухай цахим хурал хийж, Байтаг-Улиастай боомтын үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, одоогийн нөхцөл байдлын талаар хэлэлцэв. Байтаг боомт нь улирлын чанартай, жилдээ 45 хоног нээлттэй ажилладаг, сүүлийн жилүүдэд үүсээд буй Ковид-19 цар тахлын үед ажиллаагүй тул Байтаг боомтод одоогоор тог цахилгаан, ус, цар тахлаас урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, ажиллаж хөнцөл боломж хомс талаар хоёр тал ярилцаж, Байтаг-Улиастай боомтыг байнгын ажиллагаатай болгох, Байтаг боомтоос Булган сум хүртэлх 120 км хатуу хучилттай авто зам барих талаар зөвшилцөж, тус тусын дээд шатны байгууллагад уламжлахаар боллоо. Аймгийн Засаг дарга Э.Болормаа БНХАУ-ын Алтай аймгийн Засаг дарга Жейнс Хаддист боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, 2 аймгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар цахим хурал хийх санал хүргүүлж, 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр БНХАУ-ын Алтай аймагтай Булган-Такешикен боомтыг хилийн 126-127 дугаар тэмдэгтэд өргөжүүлэн шилжүүлэх, хоёр аймгийн найрамдалт харилцаа, хамтын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаа цаашид улам хөгжүүлэх талаар хамтарсан цахим уулзалт зохион байгуулав. Уулзалтаар одоогийн ажиллаж байгаа хуучин боомтыг зорчигч тээврийн гарц хэвээр нь ажиллуулж, хилийн 126-127 дугаар тэмдэгтэд Булган-Такешикен боомтын нүүрс тээврийн шинэ гарц нээх тухай нэгдсэн ойлголтод хүрлээ. | |
| 254 | 2. АЗДҮАХ-ийн 4.4.1 | 1. Бүс ба Зам" санаачилгын хүрээнд Хятад-Монгол-Оросын эдийн засаг, дэд бүтэц, шинжлэх ухаан, нийгэм, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 12 | - | Бүс нутгийн хамтын ажиллагаа сайжирсан байна. | | Ховд аймгийн Их нууруудын хотгорын жижиг нууруудын биологийн (бичил биетэн) нөөцийг судлах судалгааны ажлыг 2022 оны 07 дугаар сарын 21-ээс 30-нд Ховд их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны багш нар ОХУ-ын Алтай их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зохион байгууллаа. Мөн 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Ховд аймаг Ба БНХАУ-ын Цонж Хуй өөртөө Засах аймагтай Байтаг-Улиастай боомтыг нээх тухай цахим хурал хийж, Байтаг-Улиастай боомтын үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, одоогийн нөхцөл байдлын талаар хэлэлцэв. Байтаг боомт нь улирлын чанартай, жилдээ 45 хоног нээлттэй ажилладаг, сүүлийн жилүүдэд үүсээд буй Ковид-19 цар тахлын үед ажиллаагүй тул Байтаг боомтод одоогоор тог цахилгаан, ус, цар тахлаас урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, ажиллаж хөнцөл боломж хомс талаар хоёр тал ярилцаж, Байтаг-Улиастай боомтыг байнгын ажиллагаатай болгох, Байтаг боомтоос Булган сум хүртэлх 120 км хатуу хучилттай авто зам барих талаар зөвшилцөж, тус тусын дээд шатны байгууллагад уламжлахаар боллоо. Аймгийн Засаг дарга Э.Болормаа БНХАУ-ын Алтай аймгийн Засаг дарга Жейнс Хаддист боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, 2 аймгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цахим хурал хийх санал хүргүүлж, 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр БНХАУ-ын Алтай аймагтай Булган-Такешикен боомтыг хилийн 126-127 дугаар тэмдэгтэд өргөжүүлэн шилжүүлэх, хоёр аймгийн найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг цаашид улам хөгжүүлэх талаар хамтарсан цахим уулзалт зохион байгуулав. Уулзалтаар одоогийн ажиллаж байгаа хуучин боомтыг зорчигч тээврийн гарц хэвээр нь ажиллуулж, хилийн 126-127 дугаар тэмдэгтэд Булган-Такешикен боомтын нүүрс тээврийн шинэ гарц нээх тухай нэгдсэн ойлголтод хүрлээ. | |
| 255 | 3. АЗДҮАХ-ийн 4.4.2 | 1. Гуравдагч орнуудын ах дүүгийн хамтын ажиллагаатай хот, мужуудтай уламжлалт хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ. | 12 | - | АНУ, Герман, Солонгос, Япон зэрэг гуравдагч орнуудын муж, хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | АНУ-ын Калифорни мужийн Боррего спрингс хотын дарга Жим болон Анна Верменс тэргүүтэй төлөөлөл Ховд аймагт айлчилж, аймгийн Засаг дарга Б. Дүгэржав болон албаны төлөөлөлтэй уулзав. Уулзалтаар 2019 онд Ховд аймаг, Боррего спрингс хотын хооронд байгуулсан “Эгч дүү” найрамдалт харилцааны санамж бичигт тусгасан боловсрол, соёл урлаг, бизнес худалдааны чиглэлд хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, цаашид хэрхэн хамтран ажиллах тухай санал солилцлоо. Энэ үеэр АНУ-ын Калифорни мужийн Боррего спрингс хотын зөвлөлөөс 2022 оны 8 дугаар сарын 12-ны өдрийг Монгол Улсын Ховд аймаг, АНУ-ын Боррего спрингс хот хооронд найрамдалт харилцаа тогтоосон өдөр болгон тунхагласан ба жил бүр уламжлал болгон тэмдэглэх тунхаг бичгээ аймгийн Засаг дарга Б.Дүгэржавт гардуулан өгөв. Мөн Жим тэргүүлэгчтэй албаны төлөөлөл айлчлалын хугацаанд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, “Шинэ Ховд” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдтэй танилцаж, цаашид хэрхэн хамтран ажиллах, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | талаар санал хүсэлтээ солилцлоо. Тус хуралд ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улсын тэргүүн Хорохордин Олег Леонидович, ОХУ-ын Алтайн хязгаарын Засаг дарга Виктор Петрович Томенко, Казахстаны Дорнод Казахстан мужийн захирагч ноён Даниал Ахметов, МУ-ын Ховд аймгийн Засаг дарга, хадагтай Э.Болормаа, Баян-Өлгий аймгийн Засаг дарга, ноён Д.Бауыржан, “Алтай-Бидний нийтийн гэр” Олон улсын зохицуулах зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн дарга Ларин Борис Владимирович болон БНХАУ-ын ШУӨЗО-ны удирдлагууд оролцож үг хэлж, 11 гадаад дотоодын аж ахуй нэгжүүд гэрээ байгуулж, санамж бичигт гарын үсэг зурав. Америкийн консулын дэд дарга Антони Мотиси, хэлтсийн дэд дарга Б. Уянга нар Ховд аймагт ажиллах үеэр аймгийн Засаг дарга Б. Дүгэржавтай уулзаж, хамтын ажиллагааг хэрхэн бэхжүүлэх, оюутны виз болон энгийн визний талаарх мэдээлэл солилцлоо. | |
| 256 | 4. АЗДҮАХ-ийн 4.4.3 | 1. Хөрш орнуудын уламжлалт харилцаатай хот, мужуудтай харилцаа хамтын ажиллагаагаа улам хөгжүүлж, Алтай бидний нийтийн гэр олон улсын байгууллагын үйл ажиллагаанд | 12 | - | Алтай бидний нийтийн гэр” ОУ-ын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд оновчтой оролцож, бүс нутгийн аялал жуулчлал, хамтын ажиллагааг хөгжүүлнэ | | БНХАУ-ын ШУӨЗО-ны Ардын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан “Хятад-Евроазийн орнуудын экспо-2022” 4 улсын 6 мужийн хамтарсан бүс нутгийн хамтын ажиллагааны форумын хүрээнд зохион байгуулсан “Торгоны замын эдийн засгийн бүс дагуух Алтайн нурууны бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын онлайн форум”-д аймгийн Засаг дарга Э.Болормаа цахимаар оролцож, мэндчилгээ дэвшүүлэв. “Алтай бидний нийтийн гэр” ОУЗЗ-ийн 16 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу “ИХ Алтай буюу Great Altai” олон улсын аялал жуулчлал, спортын их наадмыг 2023 онд Монголын тал зохион байгуулах шийдвэр гарсан. Энэхүү шийдвэрийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | идэвхтэй оролцоно. | | | | | дагуу Ховд, Баян-Өлгий аймаг хамтран 2023 онд уг наадмыг зохион байгуулахаар төлөвлөж, ОХУ-ын Алтай бидний нийтийн гэр” ОУЗЗ-ийн судалгааны ажлын хэсэг 2022 оны 6 дугаар сард Ховд аймагт ажиллаж, спортын наадам зохион байгуулах газар зүйн байршлын талаар судалгаа хийлээ. "Алтай бидний нийтийн гэр" олон улсын зохицуулах зөвлөлийн хүрээнд байгуулсан "Бүс нутгийн эдийн засгийн форум"-ын ээлжит хуралдааныг онлайн хэлбэрээр зохион байгуулах ба Ховд аймгаас "Шинэ-Ховд" үйлдвэр технологийн паркийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн талаар танилцуулга хийхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 257 | 5. АЗДҮАХ-ийн 4.4.4 | 1. НҮБ, Олон улс, төсөл, хөтөбөрүүдийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулж, орон нутагт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. | 12 | - | Олон Улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, хөрөнгө оруулалтын үр нөлөө дээшилсэн байна. | | АНУ-ын консулын дэд дарга Антони Мотиси, хэлтсийн дэд дарга Б. Уянга нар Ховд аймагт ажиллаж, аймгийн Засаг дарга Б. Дүгэржав, холбогдох албаны хүмүүстэй тай уулзаж, хамтын ажиллагааг хэрхэн бэхжүүлэх, оюутны виз болон энгийн визний талаарх мэдээлэл солилцлов. Мөн аливаа байгалийн гамшигт үзэгдлийн үеэр гадны иргэдэд үзүүлэх тусламж, нөөц бололцооны талаар ярилцаж, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар болон Эрүүл мэндийн газрын төлөөлөгчидтэй уулзал хийв. НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн Др Халид, хөтөлбөрийн мэргэжилтнүүд Ховд аймагт ажилласан ажлын тайлангаа хэлэлцэж, цаашид анхаарах асуудал, хамтран ажиллах нөхцөл боломжийн талаар ярилцаж, санал солилцлоо.Швецарийн хөгжлийн агентлагийн хамтын ажиллагааны дарга Стефани Бурри, Хөтөлбөрийн ахлах зохицуулагч Л. Золзаяа нар ажиллаж, Хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсролын чиглэлээр олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүнгийн талаар ЗДТГ-ын дарга Д. Энхболд болон албаны төлөөлөлтэй уулзаж, хэрэгжиж дууссан төслүүдийн үр дүн, ач холбогдлын талаар санал солилцлов. НҮБ-ын шадар суурин төлөөлөгч Аяако Кайно тэргүүтэй ажлын хэсэг Ховд аймагт ажиллаж, хүүхдэд үзүүлж буй боловсрол, эрүүл мэнд, хоол тэжээл, хүүхэд хамгаалал зэрэг нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, хүүхдийн эрхийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийн талаар мэдээлэл солилцов. | |
| 258 | 6. АЗДҮАХ-ийн 4.4.5 | 1. Олон улсын Ардын язгуур урлагийн Анхдугаар наадмыг Гадаад харилцааны болон Соёлын яам, Олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | 12 | - | Бэлтгэл ажлаа хангана. | | Ардын язгуур урлагийн Анхдугаар наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Өвлөн уламжлагчдын анхдугаар зөвлөлдөх уулзалтыг 2022 оны 03 сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулж уулзалтанд 17 сумын 85 өвлөн уламжлагчид оролцон уг үйл ажиллагааны хүрээнд баярын хурал, илтгэл, хэлэлцүүлэг, хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын өргөмжлөлөөр 17, аймгийн 90 жилийн ойн медиалаар 80 өв тээгчийг шагналаа. -“Ардын язгуур урлагийг өвлөн уламжилцгаая” уриан дор 2022 оны 04 сарын 01-нээс 07 сарын 01-н хүртэл морин хуур, бий биелгээ, хөөмий, уран нугаралт, уртын дуу 5 чиглэлээр 16 сум болон аймгийн төвийн 350 гаруй насанд хүрэгчид, 850 гаруй хүүхдэд ХДТ, Соёлын төв, Хүүхдийн ордны мэргэжлийн багш нар сургалт зохион байгууллаа. -Булган, Дарви, Зэрэг, Мянгад, Чандмань сумууд хуучир, ёочин, ятга, морин хуур, их хуур, бөмбөр, шанз, уртын дуу, бүжгийн зэрэг дугуйлангуудыг хичээллүүлж 160 гаруй хүүхэд, багачууд суралцаж байна. -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газраас санаачлан Соёлын өвийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Соёл урлагийн газартай хамтран Соёлын биет бус өвлөн уламжлагчдын бүсчилсэн судалгааг 2022 оны 10 сарын 10-наас 2023 оны 10 сарын 15-ны өдөр хүртэл зохион байгуулах бөгөөд судалгааны эхний хэсгийг 2022 оны 10 сарын 15-наас 11 сарын 15-ны хооронд цахимаар асуулгын 2 маягтаар зохион байгуулж байна. Ховд аймгийн хувьд 924 өвлөн уламжлагч судалгаанд хамрагдахаас 875 өвлөн уламжлагч судалгааны эхний хэсэгт  100 хувь хамрагдаж дууслаа. | |
| 259 | 1. АЗДҮАХ-ийн 4.5.1 | 1. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг холбогдох байгууллага, сумуудтай хамтран зохион байгуулж, аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” дайчин алдрын булан байгуулна. | 12 | - | Ерөнхий боловсролын 6 сургуульд дайчин алдрын булан хийгдсэн байна | | “Хүүхэд залуучуудад эх-оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах үүднээс дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: Монгол Цэргийн нэгдсэн холбоо, Отгонтэнгэр их сургуультай хамтран 12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан эсээ бичлэгийн уралдааны удирдамжийг аймгийн БШУГ-тай хамтран цахимаар зохион байгуулж уралдаанд ирүүлсэн 5 сурагчийн бүтээлийг Монгол Цэргийн нэгдсэн холбоонд хүргүүлж ажилласан. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан аймгийн ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол Улсын Зэвсэгт хүчний талаарх миний мэдлэг” эсээ бичлэгийн уралдааныг аймгийн БШУГ-тай хамтран зохион байгуулж явуулсан. Уралдаанд нийт 49 эсээ ирсэнээс тэргүүн байранд Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын Прогресс сургуулийн 10а ангийн сурагч Х.Үүрцайх, дэд байранд Ховд аймгийн Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11а ангийн сурагч Х.Төрмөнх, гутгаар байранд Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 6 дугаар сургуулийн 12а ангийн сурагч Б.Мөрөн нар тус тус шалгарч шагнагдсан. Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсэний 20 жилийн ойн хүрээнд Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж аймгийн төв талбайд цэргийн зэвсэг, техникийн үзэсгэлэн гаргаж Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн алба хаагчдын урлагийн тоглолт болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит марш тактик, тусгай бэлтгэлийн тэмцээний хүрэл медаль, Зэвсэгт хүчний марш тактик тусгай бэлтгэлийн тэмцээний мөнгөн медаль хүртсэн хугацаат цэргийн алба хаагчдын гардан тулааны үзүүлэх тоглолтыг ард иргэдэд үзүүлж сонирхуулан батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилж ажилласан. Монгол цэрэг-дэлхийн цэрэг дайчин алдарын танхимыг 2021 оны цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс Хөгжил политехник коллеж дээр энхий танхимыг байгуулсан дараагийн сургуулийг сонгох ажил хийгдэж байна. | |
| 260 | 2. АЗДҮАХ-ийн 4.5.2 | 1. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 5 | - | 41 | | Аймгийн ИТХ-аар батлуулсан “Эрүүл-эр хүн” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021 оны II ээлжийн хугацаат цэргийн албаны татлагаар эрүүл мэндээр цэргийн жинхэнэ албанд тэнцээгүй иргэдийн нэрийн жагсаалтыг гаргаж аймгийн Эрүүл мэндийн газар болон сумдын Засаг дарга нарт хүргүүлж иргэдийг эрүүлжүүлсэн байх үүрэг чиглэл хүргүүлсэн. Цэргийн төв эмнэлэгтэй хамтран цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй иргэдийг үзлэгт хамруулж дүгнэлт гаргуулах талаар анхааран ажиллаж байна. 2021 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оны ээлжит цэрэг татлагад хамрагдсан нийт цэргийн насны залуучуудын назлогийн судалгаанд үнэлгээ дүгнэлт хийж Ховд аймгийн бүсийн оношлогоо эмчилгээний төв болон сумдын Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ажиллаж 2022 онд 15 иргэнийг эрүүлжүүлсэн байна. 2022 оны I, II ээлжийн цэрэг татлагаар аймгийн 17 суманд цэрэг татлагын товчоо ажиллахдаа цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан нийт иргэнээс Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нарийн мэргэжлийн эмч нар “Хугацаат цэргийн албанд татагдсан болон гэрээгээр цэргийн жинхэнэ алба хаах хүсэлт гаргасан иргэнийг эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах” журмын дагуу эрүүл мэндийн үзлэг явуулсан ба нийт хамрагдсан иргэдийн 31.4 хувь нь эрүүл мэндээр тэнцээгүй. Эрүүл мэндээр тэнцээгүй нийт иргэнээс I болон II ээлжийн татлагаар дотрын өвчнөөр 36/26,1 хувь, мэс засал гэмтлийн өвчнөөр 32,7/30,1 хувь, чих хамар хоолойн өвчнөөр 9,8/9,5 хувь, нүдний өвчнөөр 6,5/3,5 хувь, сэтгэцийн өвчнөөр 1,6/8,3 хувь, мэдрэлийн өвчнөөр 3,2/8,3 хувь, арьс өнгөний өвчнөөр 4,9 хувь, сүрьеэгийн өвчнөөр 4,9/2,3 хувь нь цэргийн жинхэнэ албанд тэнцээгүй байгаа нь цэргийн насны залуучуудын өвчлөл буурч байгааг харуулж байна. 2022 оны ээлжит цэрэг татлагад орж цэргийн жинхэнэ албанд тэнцсэн залуучуудын боловсролын түвшин өмнөх оныхоос дээшилж байгааг харуулж байна. | |
| 261 | 3. АЗДҮАХ-ийн 4.5.2 | 1. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, | 12 | | 22.: | | Аймгийн ИТХ-аар батлуулсан “Эрүүл-эр хүн” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2021 оны II ээлжийн хугацаат цэргийн албаны татлагаар эрүүл мэндээр цэргийн | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрүүлжүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | | | | | жинхэнэ албанд тэнцээгүй иргэдийн нэрийн жагсаалтыг гаргаж аймгийн Эрүүл мэндийн газар болон сумдын Засаг дарга нарт хүргүүлж иргэдийг эрүүлжүүлсэн байх үүрэг чиглэл хүргүүлсэн. Цэргийн төв эмнэлэгтэй хамтран цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй иргэдийг үзлэгт хамруулж дүгнэлт гаргуулах талаар анхааран ажиллаж байна. 2021 оны ээлжит цэрэг татлагад хамрагдсан нийт цэргийн насны залуучуудын назлогийн судалгаанд үнэлгээ дүгнэлт хийж Ховд аймгийн бүсийн оношлогоо эмчилгээний төв болон сумдын Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ажиллаж 2022 онд 15 иргэнийг эрүүлжүүлсэн байна. 2022 оны I, II ээлжийн цэрэг татлагаар аймгийн 17 суманд цэрэг татлагын товчоо ажиллахдаа цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан нийт иргэнээс Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нарийн мэргэжлийн эмч нар “Хугацаат цэргийн албанд татагдсан болон гэрээгээр цэргийн жинхэнэ алба хаах хүсэлт гаргасан иргэнийг эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах” журмын дагуу эрүүл мэндийн үзлэг явуулсан ба нийт хамрагдсан иргэдийн 31.4 хувь нь эрүүл мэндээр тэнцээгүй. Эрүүл мэндээр тэнцээгүй нийт иргэнээс I болон II ээлжийн татлагаар дотрын өвчнөөр 36/26,1 хувь, мэс засал гэмтлийн өвчнөөр 32,7/30,1 хувь, чих хамар хоолойн өвчнөөр 9,8/9,5 хувь, нүдний өвчнөөр 6,5/3,5 хувь, сэтгэцийн өвчнөөр 1,6/8,3 хувь, мэдрэлийн өвчнөөр 3,2/8,3 хувь, арьс өнгөний өвчнөөр 4,9 хувь, сүрьеэгийн өвчнөөр 4,9/2,3 хувь нь цэргийн жинхэнэ албанд тэнцээгүй байгаа нь цэргийн насны залуучуудын өвчлөл буурч байгааг харуулж байна. 2022 оны ээлжит | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цэрэг татлагад орж цэргийн жинхэнэ албанд тэнцсэн залуучуудын боловсролын түвшин өмнөх оныхоос дээшилж байгааг харуулж байна. | |
| 262 | 4. АЗДҮАХ-ийн 4.5.3 | 1. Цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд жил бүр зохион байгуулна. | 12 | - | 29.1 | | | Батлан хамгаалах сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулах үүднээс Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/50 дугаар тушаалын дагуу аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 үе шаттайгаар аймгийн нийт сургуулиудыг хамруулан зохион байгуулсан. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтыг сумдын сургуулийн 10, 11 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан. Сумдаас шалгарсан баг тамирчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэж оролцуулах тухай сургуулийн удирдлагууд мэдэгж хоёрдугаар шатны шалгаруулалтыг 05 дугаар сарын 30-31-ний хооронд явуулсан. Тэмцээнийг жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, тасгийн захирагчийн тэмцээн, асуулт хариулт, эсээ бичлэг, гэрийн даалгавар, 6 километрийн марш гэсэн төрлүүдээр Зэвсэгт хүчний 123 дугаар ангийг түшиглэн зохион байгуулсан. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 13 сургуулийн 160 гаруй сурагчид оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт Жаргалант сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн сурагч Н.Энхбаяр захирагчтай тасаг, дэд байрт Үенч сумын ерөнхий боловсролын сургуулийн О.Тэмүүжин захирагтай тасаг, гутгаар байрт Жаргалант сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн М.Нямлхагва захирагчтай тасгууд шалгарсан. Тэмцээнийг зохион байгуулахад аймгийн ЗДТГ, ЗДТГ-ын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Боловсрол, шинжлэх ухааны газар, Соёл, урлагын газар, Биеийн тамир спортын газар, Хөгжимт драмын театр хамтран оролцсон. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 08 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан ба аймгийн аваргаар шалгарсан баг тамирчид 07 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 18-ны хооронд Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Жаргалант сумын 12 жилийн VI сургуулийн материаллаг баазыг түшиглэн бэлтгэл сургуулилтаа хангаж амжилттай оролцсон. | |
| 263 | | 1. Цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд жил бүр зохион байгуулна. | 12 | - | 29.1 | | Батлан хамгаалах сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулах үүднээс Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/50 дугаар тушаалын дагуу аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 үе шаттайгаар аймгийн нийт сургуулиудыг хамруулан зохион байгуулсан. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтыг сумдын сургуулийн 10, 11 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан. Сумдаас шалгарсан баг тамирчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэж оролцуулах тухай сургуулийн удирдлагууд мэдэгж хоёрдугаар шатны шалгаруулалтыг 05 дугаар сарын 30-31-ний хооронд явуулсан. Тэмцээнийг жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, тасгийн захирагчийн тэмцээн, асуулт хариулт, эсээ бичлэг, гэрийн даалгавар, 6 километрийн марш гэсэн төрлүүдээр Зэвсэгт хүчний 123 дугаар ангийг түшиглэн зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 13 сургуулийн 160 гаруй сурагчид оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт Жаргалант сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн сурагч Н.Энхбаяр захирагчтай тасаг, дэд байрт Үенч сумын ерөнхий боловсролын сургуулийн О.Тэмүүжин захирагтай тасаг, гутгаар байрт Жаргалант сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн М.Нямлхагва захирагчтай тасгууд шалгарсан. Тэмцээнийг зохион байгуулахад аймгийн ЗДТГ, ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Боловсрол, шинжлэх ухааны газар, Соёл, урлагын газар, Биеийн тамир спортын газар, Хөгжимт драмын театр хамтран оролцсон. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 08 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан ба аймгийн аваргаар шалгарсан баг тамирчид 07 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 18-ны хооронд Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Жаргалант сумын 12 жилийн VI сургуулийн материаллаг баазыг түшиглэн бэлтгэл сургуулилтаа хангаж амжилттай оролцсон. | |
| 264 | 5. АЗДҮАХ-ийн 4.5.5 | 1. Улсын болон цэргийн дайчилгааны даалгавраар тогтоосон материал, эд хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах, | 12 | - | Тайлант хугацаанд өргөн хэрэглээний болон шаардлагатай эд материалын үнийн өсөлтөөр | | Аймгийн “Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө”, “Зэвсэгт хүчний анги, салбарыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, “Орон нутгийн цэргийг байгуулах, бэлтгэлийг хангах төлөвлөгөө”-г тус тус заврын дагуу боловсруулж ЗХЖШ-ын холбогдох албан тушаалнуудаар хянуулан 2021 онд батлуулсан. Сумдад тогтоосон дайчилгааны даалгаврын дагуу сумдаас оногдуулан бүртгэгдсэн цэргийн бэлтгэл | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | үүрэгтэн, техникийн тодотголыг 2022 оны 05, 10 дугаар саруудад Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 дугаар салбартай оногдуулан бүртгэгдсэн цэргийн бэлтгэл үүрэгтэн, авто техникийг тодотгосон. Батлан хамгаалах яамнаас Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан аймгийн Улсын дайчилгаа хариуцсан албан тушаалтан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас холбогдох судалгаа авсан бөгөөд Улсын дайчилгаа хариуцсан мэргэжилтэн тогтоосон хугацаанд тайланг БХЯ-нд хүргүүлсэн. | |
| 265 | 6. АЗДҮАХ-ийн 4.5.6 | 1. Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Хилийн 0130 дугаар ангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 12 | - | Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон үзүүлэлт | 8,459,700 | 2022 онд хил хамгаалахад туслах зөвлөлийн хүрээнд орон нутгийн төсвөөс хилийн зөрчил үүсч болзошгүй газрын хамгаалалтын тор сайжруулах ажилд Булган сумтай хамтран 80 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.Зэвсэгт хүчний марш тактик тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн баг тамирчдад эд материалын дэмжлэг үзүүлж тэмцээнд уралдаанд нь амжилт хүссэн. Мөн Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан “Сэлэнгэ-2022” хээрийн сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд амрах байр, зөөврийн халуун ус, угаалгын газар, эко бие засах газар зэргийг 49000000 төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж ажилласан. Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн 100 жилийн ой 2022 онд тохиож байгаа тул ой тэмдэглэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/515 дугаар захирамжаар ангийн үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх үүднээс 2949900 төгрөгийн мотоциклийг аймгийн Засаг даргын нөөц | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөрөнгөөс, 2022 оны А/516 дугаар захирамжаар сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний ажиллаж амьдрах ая тухтай орчныг хангах үүднээс 2519800 төгрөгийн зөөврийн компьютер, TCL зурагт зэргийн цэргийн дүйцүүлэх албын мөнгөн төлбөрийн орлогоос тус тус гарган дэмжлэг үзүүлж ажилласан. | |
| 5. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 266 | 1. АЗДҮАХ-ийн 5.1.1 | 298. “Ховд аймгийн Ногоон хөгжлийн /2016-2026 он/ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ. | 12 сар | - | Хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтуудын хэрэгжилтийг 60 хувьд хүргэсэн байна. | | 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 17 заалт хяналтанд авч хэрэгжүүлэхэд 14 заалт 100 хувьтай, 2 заалт 70 хувьтай, 1 заалт 30 хувьтай ногоон хөгжлийн хөтөлбөр 91,8 хувьтай хэрэгжсэн байна. | 90% |
| 267 | 2. АЗДҮАХ-ийн 5.1.2 | 299. Буянт голын зуслангийн айлуудад “Хоггүй цэвэрхэн Ховд” аяныг зохион байгуулж, ус, хөрсний бохирдолоос сэргийлнэ. | 12 сар | - | “Хоггүй цэвэрхэн Ховд” аяныг Буянт голын зуслангийн бүсэд зохион байгуулж ус, хөрсний бохирдолыг бууруулсан байна. | 50 000 000 | Ховд аймгийн Засаг даргын А/592 дугаар захирамж гаргуулан аймгийн хэмжээнд “Хоггүй Ховд” бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж нийт 5,407 тонн орчим хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэн отволдох болон ландфиллын аргаар булж устгаад байна. Ховд аймгийн хэмжээнд 2022 онд ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгүүд нийт зориулалтын бус 42 нүхэн жорлон ашиглаж байгаа судалгаа байна. 2022 онд “Шинэ Ховд Жаргалант” ТҮК ОНӨААТГазар нь Буянт голын зуслангийн айл өрхүүдэд 11 ширхэг эко соруулдаг жорлон болон зөөврийн татан зайлуулдаг 16 ширхэг функер байршуулж хөрсний бохирдлоос сэргийлэн ажилласан. Буянт голын зуслангийн айл өрхүүдэд зориулалтын бус 90 гаруйн нүхэн жорлонг ашиглаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
